



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД
С.АМАРСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.04 № хэрг / 1470
танай _____-ны № _____-т

**Санал, дүгнэлтийн
төсөл бэлтгэх тухай**

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаас “Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай” анхдагч хуулийн төслийг санаачлан боловсруулж, Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасны дагуу санал, дүгнэлтийн төслийг бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг хүсье.

Хавсралт ¹⁴⁶ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265006137

Хянасан:
Хууль, эрх зүйн газрын дарга Я.Жавхлан
Боловсруулсан:
ЗГ-ын референт Д.Энхцэцэг
Хувь: 27 *Д.Энхцэцэг*

00000000000000000000



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД НЯМ-ОСОРЫН УЧРАЛ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Болдын УЯНГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-62, Факс: 32-70-16
E-mail: uyanga@parliament.mn
http://www.parliament.mn

2026.04.28 № УИХ-03/4571
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар хүргүүлж байна.

Тус хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, саналаа ирүүлэхийг хүсье.

“Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай” хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулга болон холбогдох судалгааг хавсаргав.

Хавсралт 145 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Б.УЯНГА



000077

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН

ГИШҮҮН

Б.УЯНГА



**БАЙГАЛИЙН БАЯЛАГ АШИГЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫН
ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

1.1 .Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна" гэж, тус зүйлийн 2 дахь хэсэгт "...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй." гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.6 дахь заалтын 1-д "Газар, түүний нөөцийг зохистой, ур дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдсэн байна." гэж, 4.2 дахь заалтын 1-д "Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдсэн байна." гэж, 6.2 дахь заалтын 1 -д "Биологийн олон янз байдлыг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэж хомсдолоос сэргийлэх, ашигт зүйлийг үржүүлэх, тарималжуулах, Ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөц бүрдүүлнэ." гэж, мөн заалтын 2-т "Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна." гэж, мөн заалтын 4-т "Байгаль орчны хяналт шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлж, шинэ үеийн техник, технологийн шинэчлэл хийнэ." гэж, 6.3 дахь заалтын 2-т "Усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ус хангамжийн эх үүсвэрийн эруул ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна." гэж, мөн заалтын 4т "Хүн амыг баталгаат ундны усаар хангах, усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлэх, төлөвлөлт, менежмент хийх нөхцөлийг бүрдүүлнэ." гэж, мөн тус тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.1.5-д "Ил тод байдал, хамтын ажиллагаанд тулгуурлан гадаадад хөрөнгө оруулалтыг татах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ." гэж, 4.2.11-д "Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ." гэж, 4.2.12-т "Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө." гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.1.6.5-д "олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах" гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 130-д Монгол Улсад эдийн засаг, нийгмийн урт хугацааны тогтвортой хөгжилд эрдэс баялгийн салбарын үзүүлэх ур нөлөөг дээшлүүлэх, эрдэс баялгийн салбарын ил тод байдлын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор "Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах" гэж тус тус заасан байна.

1.2. Практик шаардлага

Байгалийн баялаг олборлох үйлдвэрлэл нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 20-30 орчим хувийг дангаараа хангаж, эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж болж ирсэн төдийгүй эдийн засгийн бусад салбарт томоохон нөлөө үзүүлдэг. Байгалийн баялгийг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд түшиглэн, улсын эдийн засгийг бэхжүүлэх, нөгөө талаас уг салбарыг нээлттэй, ил тод, хариуцлагатай байлгаж, татварыг улсын төсөвт зохистой төвшинд төвлөрүүлэх, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор хяналт, дүн шинжилгээ болон тайлагнал зэргийг иж бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага тулгамдаад байна.

Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаа нь зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, гэрээ, эрхийн хүрээнд явагддаг бөгөөд Олон улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага, Дэлхийн банк, Мөнгө угаахтай тэмцэх, санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага зэрэг олон улсын байгууллагууд байгалийн баялаг, ялангуяа ашигт малтмалын нөөц баялаг ихтэй улс орны олборлох үйлдвэрлэлийг эрсдэлтэйд тооцож, авлига, хээл хахууль, мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэргийн эрсдэлийг өндөр гэж үздэг.

Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаан дахь шударга бус өрсөлдөөн, давамгайл байдлыг бууруулах нь нийгмийн давхаргын ялгааг арилгахад бодит хувь нэмэр болно гэж үздэг. Төрийн болон орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газрын худалдан авалтаар дамжуулж авлига хээл хахуулийг бодит бус үнэ өртгөөр худалдан авалт хийж дамжуулах, улсад их хэмжээний хохирол учруулсан жишээ өнгөрсөн хугацаанд гарснаар Монгол Улс олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр дорвитой арга хэмжээ авах шаардлага бий болсныг харуулж байна.

Дэлхийн улс орнуудын олборлох салбар, байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлыг хангахад чиглэгдсэн зохицуулалт нь ихэвчлэн кодекс буюу суурь хуулийн шинжтэй, энэ нь эрчим хүч, ашигт малтмал, газрын тос, байгалийн хий болон газар, ус зэрэг байгалийн баялгийн цогц мэдээллийг агуулдаг.

Түүнчлэн эдгээр салбарт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн эрх, зөвшөөрөл, гэрээ, эцсийн өмчлөгч, эцсийн эзэмшигч болоод орлого, татвар төлөлт, орон нутгийн харилцаа, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөж, нөлөөллийн талаар маш нарийн чиг үүргийн зохицуулалттай, харилцан уялдааг хангасан, аливаа төлөвлөлтийн шийдвэрт сонирхол нь хөндөгдөж буй бүх талын оролцогчид чөлөөтэй оролцох нөхцөлийг бүрдүүлсэн байдаг.

Монгол Улс байгалийн баялаг ашиглалтын ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлж ирсэн бөгөөд олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төр болон хувийн хэвшлийг хариуцлагажуулах зорилго бүхий, дэлхийн 52 улс орон нэгдэн орсон "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилга" /цаашид "ОУИТБС" гэх/-д 2007 онд, Нээлттэй засаглалын түншлэлд 2013 онд тус тус нэгдэж, олборлох үйлдвэрлэлд мэдээллийн ил тод байдлыг ханган хэрэгжүүлэхээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг амлалтыг авсан.

Монгол Улсын Засгийн газраас 2006 онд “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгыг дэмжих тухай” тогтоолыг баталж, санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг төрийн болон төрийн бус байгууллага, компанийн төлөөлөлтэйгөөр байгуулан ажиллах болсноор манай улс албан ёсоор “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай” олон улсын санаачилгыг хэрэгжүүлж эхэлсэн. ОУИТБС-д байнга шинэ дэвшилтэт өөрчлөлтүүд гарч байгаа боловч ОУИТБС-ын хүрээнд авсан үүрэг амлалтаа Монгол Улс бүрэн хэрэгжүүлэхэд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, журам, маягт батлах зэргээр хэрэгжилтэд баримталж ирсэн өнөөгийн эрх зүйн орчин хангалтгүй байна.

Тиймээс бие даасан хууль боловсруулан, хамаарах салбарыг тодорхойлох, тэдгээрийн мэдээллийг бүрдүүлсэн мэдээллийн сан бий болгох, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан хуульчлах шаардлагатай байна. Түүнчлэн тусгай зөвшөөрлийн тоо өсөн нэмэгдэж, байгалийн баялгийг ашиглах үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр хариуцлагын асуудлыг иргэд, олон нийтийн зүгээс улам хурцаар тавих нь нэгэнт тодорхой болжээ. Төр, аж ахуйн нэгж болон орон нутгийн иргэд хоорондын харилцан ойлголцлыг бий болгосноор байгалийн баялаг ашиглалтын үл ажиллагаанд хөрөнгө оруулахад үүсэх эрсдэлийг бууруулж, эдийн засагт жинтэй хувь нэмэр оруулах холбогдох салбарын хөгжил зогсонги байдалд хүрэхээс сэргийлэх боломж бүрдэхээр байна.

Мөн эрдэс баялгийн салбарын хувьд эдийн засгийн үр өгөөжийг иргэдэд хүртээхэд үүсдэг гол асуудлын нэг болох татвараар нэгэнт цугларсан орлогын хуваарилалтыг үндэсний баялгийн сангаар дамжуулан зөв зохистой удирдах төрийн бодлогын гол түшиц, иргэдийн мэдлэгийг дэмжих, иргэдээс дэмжлэг авах улмаар олборлолтын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх шийдвэртэй гарц нь байгалийн баялаг ашиглах салбарын ил тод байдлыг хангах явдал юм.

Байгалийн баялаг ашиглалтын үйл ажиллагааг ил тод байлгаж, иргэдийн мэдэх эрхийг хангахын тулд зөвхөн эрдэс баялгийн салбараар хязгаарлах бус байгалийн бусад баялаг болох ан амьтан, ойн баялаг, байгалийн ургамал, үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглах үйл ажиллагаанд мөн ил тод байдлыг хангах нийтлэг зохицуулалт бүхий бие даасан хуулиар зохицуулах нь оновчтой зохицуулалт болох юм.

2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, түүнийг дагалдан гарсан Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудаар хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн нэрийг Улсын бүртгэлийн байгууллагаас хариуцаж нээлттэй байлгахгаар тусгасан. Тус хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд бүртгүүлсэн нийт 232,239 хуулийн этгээдийн 59.68 хувь буюу 138,594 хуулийн этгээд нь эцсийн өмчлөгчийн нэрийн мэдээллээ бүртгүүлж, түүнийг улсын бүртгэлийн байгууллагаас нээлттэй болгосон байна. Харин гадаадын хөрөнгө оруулалттай 9,349 хуулийн этгээд бүртгэлтэй байгаагаас 5,888 нь буюу 62.9 хувь нь эцсийн өмчлөгчийн нэрийн мэдээллээ тус тус бүртгүүлж, түүнийг улсын бүртгэлийн байгууллагаас нээлттэй болгосон байна.

Түүнчлэн, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шууд бусаар шилжүүлэхэд татвар төлөхөөс зайлсхийх эрсдэлийг арилгах зорилгоор 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Татварын ерөнхий хуулийг шинэчлэн найруулснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн “эцсийн эзэмшигч”-ийн мэдээллийг төрийн холбогдох байгууллагууд бүртгэх болсон.

Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар олгосон, сунгасан, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрөл букуу зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиг, алдагдлын тайлан, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, гишүүд болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, цалин хөлсний мэдээлэл, урамшууллын дүн, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ зэрэг мэдээллийг нээлттэй байхаар тусгасан байна.

Байгалийн баялаг болох эрдэс баялаг, ан амьтан, ойн баялаг, байгалийн ургамал болон усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах харилцаанд төр болон бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах нь тухайн улс орны байгалийн баялгийн нөөцийг хэрхэн удирдаж, ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа талаар олон нийтэд бодитой ойлголт өгөх чухал ач холбогдолтой юм.

Дээрх харилцаанд зөвшөөрлийг эзэмшиж байгаа этгээд хэн болох, түүний үйл ажиллагаа, олж байгаа орлого болон зарцуулалтын мэдээллийг ил тод болгох нь байгалийн баялгийн нөөц болоод төвлөрүүлэх орлогыг өндөр үр ашигтайгаар ашиглах, тогтвортой хөгжил, шударга хуваарилалт, олон нийтийн итгэлийг бий болгох түүнчлэн хариуцлагатай хөрөнгө оруулагчдыг татаж, хөрөнгө оруулалтын орчин сайжрах нөхцөл бүрдэх юм.

Оролцогч этгээдүүдийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, цаг үеэ олсон, чанартай мэдээллийн ил тод байдал нь хариуцлагатай байдал болон сайн засаглалыг дэмжиж, төрийн хариуцлагатай, үр дүнтэй байдлыг сайжруулах, улмаар авлигыг бууруулах, төрийн үйлчилгээг сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Мөн иж бүрэн мэдээллийн хүртээмжээр хангах нь иргэн, бизнес эрхлэгч, иргэний нийгмийн болоод хэвлэл мэдээллийн байгууллагын хүчтэй оролцоог төрийн үйл ажиллагаанд нэмэгдүүлэх ба иргэн, хуулийн этгээд нь төрөөс авч байгаа үйлчилгээ, хулээх үүрэг, хариуцлагынхаа талаар мэдээлэлтэй болж, авсан мэдээлэлдээ тулгуурлан шийдвэр гаргахад ихээхэн тус дөхөм болдог. Нөгөө талаас байгалийн нөөцийн талаар төрийн бодлого боловсруулах, удирдлагыг сайжруулахад төрд үнэ цэнэтэй арга зүй болж өгнө.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагын дагуу Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төслийн зорилт нь байгалийн баялаг ашиглалт, олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах замаар хувийн хэвшлээс хариуцлагатай хөрөнгө оруулалтыг татах, гадны хөрөнгө оруулагчдад ил тод, таатай орчин бүрдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүнээс хамаарах субъектив хамаарлыг бууруулах, салбарын үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтын талаарх мэдээллийг нэгтгэж, хяналттай, хариуцлагатай бөгөөд үр дүнтэй байхад төрийн бодлогыг чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хуулийн төсөл нь 5 бүлэгтэй байх ба доор дурдсан харилцааг зохицуулна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуульд хэрэглэгдэх нэр томъёоны тодорхойлолт, байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим зэргийг тусгана.

Хоёрдугаар бүлэгт байгалийн баялаг ашиглалтын талаар мэдээлэл, мэдээллийн нэгдсэн портал, мэдээллийн нууцлал, мэдээллийн сангийн мэдээлэл нийлүүлэгч, түүний эрх үүрэг, мэдээллийн сан дахь мэдээлэл хадгалалт, хамгаалалтын талаар тусгана.

Гуравдугаар бүлэгт, байгалийн баялаг ашиглалтын мэдээллийн улсын нэгдсэн болон төрөлжсөн тайлан, тайлангийн зөрүүг хянан шийдвэрлэх талаар зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт, ил тод байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох шатны Засаг даргын бүрэн эрх, ил тод байдлын хэрэгжилтийг Засгийн газарт тайлагнах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл, салбар зөвлөл, түүний Ажлын албаны бүрэн эрх, тэдгээрийн үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт, ил тод байдлыг хангахтай холбогдуулан гомдол хянан шийдвэрлэх, маргаан шийдвэрлэх журам, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлын тухай хууль батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй ба эрх зүйн орчныг бүрдүүлснээр урт хугацаанд нийгэм, эдийн засагт дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

1/Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон улсын дэвшилтэт хандлагад нийцсэн хамтын удирдлага, хамтын хяналтын тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц бий болно.

2/Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд үргүй зардал гаргахад хүргэж буй, мөн хууль бус төлбөр, хураамж өгч, авдаг зохисгүй хандлагыг бууруулах, цаашид гарахаас урьдчилан сэргийлэх хууль, эрх зүйн зохицуулалттай болно.

3/Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн зохистой түншлэлийн хэлбэр бий болно.

4/Авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулах, таслан зогсоох нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

5/тусгай зөвшөөрөл эзэмшигч, төр, олон нийтийн байгууллага хоорондын харилцаа, үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд ил тод болж олон нийтийн зүгээс хяналт тавих боломжтой болно.

6/Төрийн өмчит аж ахуйн нэгжийн зардал буурснаар ашигт үйл ажиллагаа нэмэгдэж улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого нэмэгдэнэ.

7/Төлсөн татвар, хураамжийн зарцуулалт, хуваарилалт ил тод болсноор баялгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх сэдлийг үр дүнтэй болгож бэхжүүлнэ.

8/Хуулийн төсөл батлагдсанаар өнгөрсөн хугацаанд улс, орон нутгийн төсвийн тодорхой хувийг бүрдүүлж байгаа орлогын талаарх мэдээллийг нэгдсэн байдлаар ил тод болгож байгаа амжилтыг улам цааш бэхжүүлж, хамрах хүрээг тэлнэ.

9/Засгийн газар, компаниудын удирдах болон шийдвэр гаргах эрх бүхий ажилтнуудын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж, салбарын оролцогчдыг тодорхой болгож, олон нийт үнэн зөв мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ.

10/Хуулийн нэр томъёо тодорхой болж, олборлох үйлдвэрлэлийн нээлттэй байдал нэмэгдсэнээр хөрөнгө оруулалтын орчин сайжирна.

11/Байгалийн баялгийн засаглал, үр өгөөж нэмэгдсэнээр нийгэм, эдийн засгийн зангилаа асуудлыг шийдвэрлэх боломжтой болж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах нөхцөл бололцоотой болно.

12/Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх болон байгаль орчныг хамгаалах талаас томоохон зэрэг нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Цөмийн энергийн тухай, Ойн тухай, Усны тухай, Амьтны тухай, Компанийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад шаардлагатай хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго байгалийн нөөцийг ашиглахад олон нийт хяналт тавих, иргэний мэдэх эрхийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд оршино.

2 дугаар зүйл.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын хууль тогтоомж

2.1.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль тогтоомж Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль амьтан, ус, ой, ургамлын нөөц, эрдэс баялгийг ашиглахтай холбоотой энэ хуульд заасан мэдээлэл, тайланг нээлттэй, ил тод болгохтой холбоотой харилцаанд үйлчилнэ.

3.2.Мэдээллийг ил тод болгохтой холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл” гэж ус, ой, ургамал, амьтан, эрдэс баялгийг ашиглахтай холбоотой энэ хуульд заасан болон Засгийн газраас баталсан жагсаалтад хамаарах мэдээллийг;

4.1.2.“зөвшөөрөл эзэмшигч” гэж Байгалийн нөөц ашиглалтын үйл ажиллагаа эрхлэхээр зөвшөөрөл авсан Зөвшөөрлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.3-т заасан этгээдийг;

4.1.3.“мэдээлэл нийлүүлэгч” гэж энэ хуулийн 8.1-д заасан этгээдийг;

4.1.4. “мэдээллийн нэгдсэн портал” гэж энэ хуульд заасан тайлан, мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хадгалах, нийтлэх зориулалттай цахим системийг;

4.1.5. “олборлох үйлдвэрлэл” гэж ашигт малтмал, газрын тос хайх, ашиглахтай холбоотой Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай хуульд хамаарах эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг;

4.1.6. “тайлан” гэж энэ хуулийн 9.1, 10.1-т заасан тайланг;

4.1.7. “тайлангийн зөрүү” гэж өөр өөр мэдээлэл нийлүүлэгчийн тайланд ижил үзүүлэлтээр зөрүүтэй дүн, тайлбар, мэдээлэл гарсныг.

4.1.8. “эрдэс баялаг” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.1-д заасан ашигт малтмал, Газрын тосны тухай хуулийн 4.1.1-д заасан газрын тосыг.

4.1.9. “эцсийн өмчлөгч гэж” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан этгээдийг;

4.1.10. “эцсийн эзэмшигч” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.48-д заасан этгээдийг;

4.1.11. “мэдээлэл бий болсон” гэж гэрээ, хэлэлцээр, шийдвэр, зөвшөөрлийн баримт бичиг албан ёсоор байгуулагдсан, гаргасан, эсхүл бүртгэгдсэн, төлбөр, хураамж, татвар, төлбөр тооцоо хийгдсэн, хяналт шалгалт, үзлэг, шинжилгээ, хэмжилт хийгдэж, түүний үр дүн бүрдсэн, тайлан, акт, дүгнэлт, зөвлөмж албан ёсоор бүрдсэн, баталгаажсан, мэдээлэл бодит байдалд үүсч, түүнийг баримтжуулсан, бүртгэсэн өдөр зэргийн аль нэгээр үүссэн, бүрдүүлсэн, эсхүл бүртгэгдсэн байдлыг.

4.1.12. “мэдээлэл нийлүүлэгч болох үндэслэл үүссэн” гэж энэ хуулийн 8.1.2-т заасан төрийн бус байгууллага нь зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал, санхүүжилт, эсхүл бусад хэлбэрийн үнэ бүхий зүйлийг анх удаа хүлээн авсан өдрийг.

5 дугаар зүйл. Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн баримтлах зарчим

5.1. Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангахад дараах зарчмыг баримтална:

5.1.1. мэдээлэл, тайлан олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байх;

5.1.2. мэдээлэл, тайлан үнэн зөв, бүрэн байх;

5.1.3. оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

5.1.4. мэдээлэл, тайлан харилцан уялдаатай, нэгдмэл байх;

5.1.5. олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх;

5.1.6.төр өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

6 дугаар зүйл. Байгалийн нөөц ашиглалтын нэгдсэн портал

6.1. Энэ хуульд заасан тайлан, мэдээллийг цахимаар хүлээн авах, бүртгэх, хадгалах, боловсруулах, шалгах, нийтлэх, мэдээлэл солилцох зориулалт бүхий мэдээллийн нэгдсэн портал (цаашид “нэгдсэн портал” гэх) ажиллуулна.

6.2. Нэгдсэн портал Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.6-д заасан шаардлагад нийцсэн, 27.10-т заасан нэгдсэн, ангилал, код, тайлбартай байна.

6.3. Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн жагсаалтыг Засгийн газар батална.

6.4. Нэгдсэн порталд бүртгэх мэдээлэл тоон мэдээлэл, өгөгдөл, дуу авиа, дүрс бичлэг, зураг, газрын зураг, кадастрын зураг, график, бичгийн хэлбэртэй байна.

6.5. Нэгдсэн порталд байрших газрын зураг, кадастрын зурган мэдээлэл Засгийн газраас тодорхойлсон солбицол, өндрийн тогтолцоонд нийцсэн байна.

6.6. Үндэсний зөвлөл нэгдсэн порталын үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн хариуцна.

6.7. Нэгдсэн портал бусад хуульд заасан байгалийн нөөцийн, зөвшөөрлийн, шилэн дансны, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн, татварын зэрэг холбогдох мэдээллийн сантай холбогдсон, мэдээлэл солилцох боломжтой байна.

6.8. Нэгдсэн порталд цахим хэлбэрээр хүргүүлсэн мэдээлэл, тайлан цахим гарын үсэг, эсхүл хуульд заасан бусад баталгаажуулах арга, хэрэгслээр баталгаажсан байна.

6.9. Байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой бусад хуульд заасан тайлан, мэдээ, мэдээллийг нэгдсэн порталаар дамжуулан цахимаар хүргүүлсэн бол тухайн мэдээллийг холбогдох төрийн байгууллагад хүргүүлсэнд тооцно.

6.10. Нэгдсэн порталд бүртгэгдээгүй, эсхүл баталгаажаагүй мэдээллийг байгалийн нөөц ашиглалттай холбоотой зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, төлөвлөгөө батлах, хяналт шалгалт хийх, тайлан боловсруулах үндэслэл болгохгүй.

6.11. Нэгдсэн порталын мэдээллийг 16 жилээс доошгүй хугацаанд хадгална.

6.12. Нэгдсэн порталд мэдээлэл нийлүүлэх, хадгалах, ашиглах, ашиглалтад хяналт тавих журмыг Үндэсний зөвлөл батална.

6.13. Үндэсний зөвлөлийн ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх) нэгдсэн порталд илгээсэн мэдээллийн хэлбэр, хугацаа, бүрдлийг шалгана.

6.14.Ажлын алба мэдээлэл дутуу, алдаатай, зөрүүтэй бол мэдээлэл нийлүүлэгчид буцааж, засварлах шаардлага хүргүүлнэ.

6.15.Мэдээлэл нийлүүлэгч энэ хуулийн 6.15-т заасан шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор засварласан мэдээллийг дахин илгээнэ.

6.16.Энэ хууль болон холбогдох бусад хуульд заасан тайлан, мэдээллийг мэдээлэл нийлүүлэгч холбогдох мэдээллийн сан, нэгдсэн портал, эсхүл салбарын эрх бүхий байгууллагад цахимаар хүргүүлсэн бол төрийн байгууллага уг мэдээллийг дахин шаардахгүй бөгөөд нийтийн мэдээллийн дэд бүтэц, мэдээлэл солилцооны системээр дамжуулан авч ашиглана.

6.17.Үндэсний зөвлөл нэгдсэн порталаар тайлан, мэдээллийг нэг цонхоор хүлээн авах, харилцан солилцох, дахин шаардахгүй байх техникийн боломжтой байна.

7 дугаар зүйл.Мэдээллийн нууц

7.1.Байгалийн нөөц ашиглалтын улмаас зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, бохирдол, доройтол, осол, нөхөн сэргээлт, аюултай эсхүл хортой бодисын хэрэглээ, хог хаягдал, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамж, татвар, эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгч, улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого, төрийн болон орон нутгийн өмчит этгээдэд төлсөн төлбөр, ногдол ашиг, хандив, тусламж, дэмжлэгийн мэдээллийг Байгууллагын нууцын тухай болон бусад хуулиар хамгаалагдсан нууц мэдээлэл гэж үзэхгүй.

7.2.Энэ хуульд заасан гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийг нэгдсэн порталд бүтнээр нь ил тод байршуулна.

7.3.Гэрээ хэлэлцээрийн хуулиар хамгаалагдсан төрийн нууц, байгууллагын нууцад хамаарах хэсгийг нууцалж нийтэлж болох бөгөөд энэ нь гэрээний бусад хэсгийг ил болгох үүргийг хязгаарлахгүй.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан мэдээллийг нууцлах шалгуур, тэмдэглэгээ, нууцлах хугацаа, шийдвэрлэх журмыг Засгийн газар батална.

7.5.Энэ хуулийн 7.3-т заасны дагуу мэдээллийг тодорхой хугацаанд нууцлах тохиолдолд мэдээлэл нийлүүлэгч тайлан, мэдээлэл гаргах үүргээс чөлөөлөгдөхгүй.

8 дугаар зүйл.Мэдээлэл нийлүүлэгч, түүний эрх, үүрэг

8.1.Дараах этгээд мэдээлэл нийлүүлэгч байна:

8.1.1.зөвшөөрөл эзэмшигч;

8.1.2.энэ хуулийн 10.5-д заасан төрийн бус байгууллага;

8.1.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан мэдээлэл хариуцагч.

8.2. Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөл олгосноос хойш ажлын 5 өдрийн дотор нэгдсэн порталд бүртгүүлнэ.

8.3. Энэ хуулийн 8.1.2-т заасан төрийн бус байгууллага нь энэ хуулиар мэдээлэл нийлүүлэгч болох үндэслэл үүссэнээс хойш ажлын 15 өдрийн дотор нэгдсэн порталд бүртгүүлнэ.

8.4. Мэдээлэл нийлүүлэгчийн бүртгэлийн журмыг Үндэсний зөвлөл батална.

8.5. Мэдээлэл нийлүүлэгч дараах үүрэгтэй:

8.5.1. мэдээлэл бий болсноос хойш ажлын 10 өдрийн дотор багтаан нэгдсэн порталд баталгаажуулан оруулах, тухайн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 5 өдрийн дотор шинэчлэх;

8.5.2. Үндэсний зөвлөл, түүний Ажлын албанаас шаардсан тодруулгын хариуг ажлын 10 өдөрт багтаан хүргүүлэх;

8.5.3. мэдээлэл, тайлангийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах;

8.5.4. энэ хуульд заасан тайланг нэгдсэн порталд байршуулах;

8.5.5. хууль тогтоомж болон Үндэсний зөвлөлөөс баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх;

8.5.6. нэгдсэн порталд энэ хуульд заасан журмын дагуу бүртгүүлэх.

8.6. Мэдээлэл нийлүүлэгч дараах эрхтэй:

8.6.1. энэ хуульд заасан тайлан гаргахтай холбоотой сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө, тодруулга, мэдээллийг авах;

8.6.2. энэ хуулийн 7.4-т заасан журмын дагуу тодорхой мэдээллийг нууцлах хүсэлт гаргах.

8.7. Энэ хуулийн 8.1.3-т заасан мэдээлэл нийлүүлэгч дараах үүрэгтэй:

8.7.1. өөрийн эрхлэх асуудлын эсхүл чиг үүргийн хүрээнд үүссэн, энэ хуульд заасан мэдээллийг бүрдүүлэх, хадгалах, боловсруулах, шинэчлэх, нэгдсэн порталд хүргүүлэх;

8.7.2. Ажлын албанд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх, цахимаар хүргүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАН

9 дүгээр зүйл. Байгалийн нөөц ашиглалтын улсын нэгдсэн тайлан

9.1. Байгалийн нөөц ашиглалтын Улсын нэгдсэн тайлан (цаашид “Улсын нэгдсэн тайлан” гэх) дор дурдсан тайлангаас бүрдэнэ:

9.1.1. амьтны нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан;

9.1.2. үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан;

9.1.3. ой, түүний дагалт баялгийн нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан;

9.1.4. байгалийн ургамлын нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан;

9.1.5. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан.

9.2. Улсын нэгдсэн тайлан боловсруулах, нэгдсэн порталд байршуулах, тайланд залруулга хийх журмыг Үндэсний зөвлөл батална.

9.3. Үндэсний зөвлөл Улсын нэгдсэн тайланг жил бүр боловсруулна.

9.4. Үндэсний зөвлөл мэдээллийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр түгээх зорилгоор Улсын нэгдсэн тайлангийн хураангуй тайланг жил бүр боловсруулна.

9.5. Үндэсний зөвлөл Улсын нэгдсэн тайланг энэ хуулийн 10.6-д заасан тайлан ирүүлэх хугацаа дууссанаас хойш хуанлийн 30 хоногийн дотор хэлэлцэн олон нийтэд мэдээлж, Засгийн газарт хүргүүлнэ.

9.6. Энэ хуулийн 9.1.5-д заасан тайланд дор дурдсан мэдээллийг тусгана:

9.6.1. улсын эдийн засагт олборлох үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээ;

9.6.2. олборлох үйлдвэрлэлийн нийт орлого, тэдгээрээс төсөвт болон бусад байдлаар улсад төвлөрүүлсэн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, зарцуулалт, төсвийн орлогын тогтвортой байдлын талаар;

9.6.3. олборлосон, баяжуулсан, боловсруулсан, борлуулсан, экспортолсон эрдэс баялгийн төрөл, хэмжээ /зөвшөөрөл тус бүрээр/;

9.6.4. зөвшөөрөл эзэмшигчээс бусдад өгсөн хандив, зээл, тусламж, дэмжлэгийн хэмжээ, хэлбэр;

9.6.5. нийгмийн хариуцлагын хүрээнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн нийт дүн;

9.6.6.зөвшөөрөл эзэмшигчийн болон төрийн байгууллагын ил тод байдлын тайлан хоорондын зөрүү, түүний тайлбар, тодруулга;

9.6.7.ил тод байдлын тайлан ирүүлээгүй зөвшөөрөл эзэмшигч болон төрийн байгууллагын талаарх мэдээлэл;

9.6.8.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, засаглалыг сайжруулах талаарх дүгнэлт, зөвлөмж, өмнөх тайлангийн зөвлөмжийн хэрэгжилт;

9.6.9.төлбөр, орлогын дүнгийн тэнцэл;

9.6.10.олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах хувь нэмрийн талаарх дүгнэлт;

9.6.11.олборлох үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;

9.6.12.уурхайн хаалт, байгаль орчин нөхөн сэргээлтийн мэдээлэл.

9.7.Энэ хуулийн 9.1.1-9.1.4-т заасан нөөц ашиглалтын ил тод байдлын тайланд дор дурдсан мэдээллийг тусгана:

9.7.1.улсын эдийн засагт тухайн салбарын байгалийн нөөц ашиглалтын эзлэх хувь хэмжээ;

9.7.2.тухайн салбарын байгалийн нөөц ашиглалтын нийт орлого, тэдгээрээс төсөвт төвлөрүүлсэн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, зарцуулалт, төсвийн орлогын тогтвортой байдлын талаар;

9.7.3.зөвшөөрөл эзэмшигчийн болон төрийн байгууллагын ил тод байдлын тайлан хоорондын зөрүү, түүний тайлбар, тодруулга;

9.7.4.ил тод байдлын тайлан ирүүлээгүй зөвшөөрөл эзэмшигч болон төрийн байгууллагын талаарх мэдээлэл;

9.7.5.тухайн салбарын байгалийн нөөц ашиглалтын ил тод байдал, засаглалыг сайжруулах талаарх дүгнэлт, зөвлөмж, өмнөх тайлангийн зөвлөмжийн хэрэгжилт.

9.8.Улсын нэгдсэн тайлан, эсхүл түүний бүрдэл тайланд төрийн бус байгууллага дүгнэлт гаргаж болно.

9.9.Энэ хуулийн 9.8-д заасан дүгнэлт гаргасан төрийн бус байгууллага нь 10.6-д заасан тайлан ирүүлэх хугацаа дууссанаас хойш ажлын 25 өдрийн дотор дүгнэлтээ Ажлын албанд хүргүүлнэ.

10 дугаар зүйл. Байгалийн нөөц ашиглалтын төрөлжсөн тайлан

10.1.Энэ хуулийн 9.1.1-9.1.5-д заасан тайлан дор дурдсан төрөлтэй байна:

- 10.1.1.төрийн байгууллагын;
- 10.1.2.зөвшөөрөл эзэмшигчийн;
- 10.1.3.төрийн бус байгууллагын;

10.2.Энэ хуулийн 10.1.1, 10.1.2-т заасан тайлангийн маягтыг байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл бүрийг хамруулж Үндэсний зөвлөл батална.

10.3.Энэ хуулийн 8.1.3-т заасан мэдээлэл нийлүүлэгч тухайн жилийн төрийн байгууллагын ил тод байдлын тайланг гаргана.

10.4.Зөвшөөрөл эзэмшигч тухайн жилийн зөвшөөрөл эзэмшигчийн ил тод байдлын тайланг гаргана.

10.5.Зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал зэрэг болон бусад аливаа хэлбэрээр санхүүжилт авсан төрийн бус байгууллага тухайн жилийн төрийн бус байгууллагын ил тод байдлын тайланг гаргана.

10.6.Энэ хуулийн 10.1.1-10.1.3-т заасан ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Үндэсний зөвлөлөөс баталсан загварын дагуу гаргаж, нэгдсэн порталд оруулна.

10.7.Мэдээлэл нийлүүлэгч энэ хуулийн 10.1.1-10.1.2-т заасан ил тод байдлын тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн гаргана.

10.8.Төрийн бус байгууллагын ил тод байдлын тайланд дор дурдсан мэдээллийг тусгана:

10.8.1.үүсгэн байгуулагч, удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын дэлгэрэнгүй мэдээлэл;

10.8.2.санхүүжилт, түүний зориулалт, зарцуулалтын мэдээлэл;

10.8.3.үйл ажиллагааны чиглэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, олборлолтын мэдээ, засаглалын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл;

10.8.4.мэдээлэл нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, хэлцлийн мэдээлэл.

11 дүгээр зүйл.Ил тод байдлын тайлангийн зөрүүг хянан шийдвэрлэх

11.1.Ажлын алба ил тод байдлын тайлангийн мэдээллийн зөрүүг тодруулах хүсэлтийг холбогдох тайлан гаргасан этгээдэд хүргүүлж болно.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан хүсэлтийг хүлээн авсан этгээд ажлын 5 өдрийн дотор холбогдох нэмэлт мэдээлэл, тайлбарыг Ажлын албанд хүргүүлнэ.

11.3. Ажлын алба энэ хуулийн 11.2-т заасан нэмэлт мэдээлэл, тайлбарыг хүлээн авсны дараа зөрүүг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ. Тухайн этгээд шаардлагатай тохиолдолд зөрүү үүсгэж байгаа мэдээлэлтэй танилцаж болно.

11.4. Ажлын алба тайлангийн зөрүүг шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл энэ талаар тайлбар, зөвлөмжийг Улсын нэгдсэн тайланд тусгаж, тайлан гаргах үүрэг бүхий этгээдэд мэдэгдэнэ.

11.5. Үндэсний зөвлөл Улсын нэгдсэн тайланд тусгагдсан зөрүүг хэрхэн шийдвэрлэж болох талаарх зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

12 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

12.1. Улсын Их Хурал байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1. Засгийн газраас хүргүүлсэн Улсын нэгдсэн тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан холбогдох байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж Засгийн газарт чиглэл өгөх.

13 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

13.1. Засгийн газар байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

13.1.2. Улсын нэгдсэн тайланг бүрдэл бүрээр хэлэлцэн, хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт 8 дугаар сарын 25-ны дотор Улсын Их Хуралд хүргүүлэх;

13.1.3. энэ хуулийн 12.1.1-д заасан холбогдох байнгын хорооны санал, дүгнэлт, Засгийн газарт өгсөн чиглэлийн биелэлтийг хангах арга хэмжээ авах;

13.1.4. энэ хуулийн 6.3-д заасан жагсаалтыг батлах;

13.1.5. Үндэсний зөвлөлийн дүрмийг батлах.

13.2. Засгийн газар энэ хуулийн 13.1.4-т заасан байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн жагсаалтыг дараах ангиллын хүрээнд батална:

13.2.1. зөвшөөрөл, түүний бүртгэлийн мэдээлэл;

13.2.2. гэрээ, хэлэлцээрийн мэдээлэл;

13.2.3. зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны мэдээлэл;

13.2.4. байгалийн нөөцийн олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын мэдээлэл;

13.2.5. төсвийн болон орлого төвлөрүүлэлтийн мэдээлэл;

13.2.6. нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн хөрөнгө зарцуулалтын мэдээлэл;

13.2.7. уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн мэдээлэл;

13.2.8. ашиг хүртэгч хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн мэдээлэл;

13.2.9. олборлох үйлдвэрлэл эрхлэгч төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээлэл;

13.2.10. олборлох үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах байдлаар олсон орлогын мэдээлэл;

13.2.11. олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах хувь нэмрийн мэдээлэл;

13.2.12. олборлох үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийн мэдээлэл.

14 дүгээр зүйл. Засаг даргын бүрэн эрх

14.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. өөрийн нутаг дэвсгэрт зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан захиргааны шийдвэр, түүний үндэслэлийг өөрийн цахим хуудаст нийтлэх;

14.1.2. түгээмэл тархацтай ашигт малтмалын зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон мэдээллийг нэгдсэн порталд байршуулах, өөрийн цахим хуудаст нийтлэх;

14.1.3. байгаль орчны хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааг зохион байгуулах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

14.1.4. ажлын алба, салбар зөвлөлтэй хамтран ажиллах, байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах талаар санал, мэдээллийг тогтмол солилцох;

14.1.5. Ажлын алба, байгаль орчны хяналтын улсын байцаагчаас ирүүлсэн мэдээллийг хянан үзэж, шаардлагатай арга хэмжээг авах.

15 дугаар зүйл. Үндэсний зөвлөл

15.1. Улсын хэмжээнд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хэрэгжүүлэх зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллах ба орон тооны Ажлын албатай байна.

15.2. Үндэсний зөвлөл Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, байгаль орчин, геологи, уул уурхай, санхүү, төсөв, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, зөвшөөрөл эзэмшигчийн төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байна.

15.3. Үндэсний зөвлөлийн 7 гишүүнийг зөвшөөрөл эзэмшигч, төрийн бус байгууллагын төлөөллөөс нээлттэй сонгон шалгаруулж, 3 жилийн хугацаагаар, үлдсэн 8 гишүүнийг энэ хуулийн 15.2-т заасан төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосноор Засгийн газар томилно.

15.4. Энэ хуулийн 15.3-т заасан төрийн бус байгууллага нь Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдал, сайн засаглалыг хангах, авлига болон ашиг сонирхлын зөрчлийг бууруулах чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан мэргэжлийн холбоо эсхүл төрийн бус байгууллага байна.

15.5. Үндэсний зөвлөл болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд зөвшөөрөл эзэмшигч, төрийн бус байгууллагын төлөөллийг сонгон шалгаруулж, томилох журмыг Засгийн газар батална.

15.6. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг тухайн шатны Засаг дарга Үндэсний зөвлөлөөс баталсан журамд нийцүүлэн батална.

15.7. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Ажлын албаны дарга байна.

16 дугаар зүйл. Үндэсний зөвлөлийн бүрэн эрх

16.1. Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1. Улсын нэгдсэн тайланг бүрдэл бүрээр хэлэлцэх, олон нийтэд мэдээлэх, Засгийн газарт хүргүүлэх;

16.1.2. мэдээлэл нийлүүлэгчийн тайланд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, холбогдох этгээдэд хүргүүлэх, зөвлөмжийн биелэлтийг шаардах, хариу, мэдээлэл авах;

16.1.3. байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг сурталчлах, олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авч, холбогдох хэлэлцүүлгийг зохион байгуулах;

16.1.4. байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын талаар авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээний талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

16.1.5. төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагатай харилцах, хамтран ажиллах;

16.1.6.энэ хуульд заасан этгээдээс байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын талаар авч хэрэгжүүлсэн ажил, ирүүлсэн мэдээлэл, тайлан, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, шалгалт хийх, биелэлтийг хангуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

16.1.7.энэ хуульд заасан мэдээлэл нийлүүлэгчээс тайлан, мэдээлэл гаргуулан авах;

16.1.8.Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын хэрэгжилт, нэгдсэн порталын үйл ажиллагаа, мэдээлэл бүрэн нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих, энэ чиглэлээр энэ хуульд заасан этгээдтэй хамтарч ажиллах;

16.1.9.Үндэсний зөвлөлийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх талаар холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах, хариу авах;

16.1.10.байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хэрэгжүүлэх асуудлаар гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

16.1.11.байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах;

16.1.12. Байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл тайлангийн заавар, маягт батлах.

17 дугаар зүйл.Ажлын алба

17.1.Үндэсний зөвлөл дараах чиг үүрэг бүхий Ажлын албатай байна:

17.1.1.энэ хуульд заасан мэдээлэл нийлүүлэгчээс байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тайланг хүлээн авах;

17.1.2.Улсын нэгдсэн тайланг боловсруулах;

17.1.3.нэгдсэн порталын үйл ажиллагаа болон мэдээлэл нийлүүлэгчээс мэдээлэл, тайланг бүрэн нийлүүлж байгаа эсэхэд хяналт тавих, мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

17.1.4.шаардлагатай тохиолдолд холбогдох шинжээч, мэргэжилтэн оролцуулж дүгнэлт гаргуулах, мэдээлэл, тайлангийн үнэн зөв байдлыг нягтлах;

17.1.5.байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг сайжруулах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах санал, зөвлөмж боловсруулах;

17.1.6.Улсын нэгдсэн тайланд үндэслэн цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж гаргах, зөвлөмжийг холбогдох этгээдэд хүргүүлэх, зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнгийн хариуг тогтоосон хугацаанд хүлээн авах;

17.1.7.Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

17.2. Зөвшөөрөл эзэмшигчийн эрх бүхий этгээд ил тод байдлын тайланг баталгаажуулаагүй бол Ажлын алба тайланг хүлээн авахаас татгалзаж, үндэслэлийн хамт мэдээлэл нийлүүлэгчид ажлын 2 өдрийн дотор мэдэгдэнэ.

17.3. Энэ хуулийн 17.2-т зааснаар татгалзсан тайланг мэдээлэл нийлүүлэгч засварлан, баталгаажуулалтыг хангасны дараа дахин хүргүүлж болно. Дахин хүргүүлсэн тайланг энэ хуулийн 10.6-д заасан хугацаа дуустал хүлээн авна.

17.4. Хэрэв мэдээлэл нийлүүлэгч 10.6-д заасан хугацаанд баталгаажуулалтыг хангасан тайланг хүргүүлэхгүй бол тайлан ирүүлээгүйд тооцож, энэ хуулийн 9.6.7, 9.7.4-т заасны дагуу Улсын нэгдсэн тайланд тусгана.

17.5. Нэгдсэн порталын мэдээлэл, тайланг Ажлын алба олон нийтэд ойлгомжтой байдлаар байршуулан мэдээлж, тогтмол шинэчилж байна.

18 дугаар зүйл. Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

18.1. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс, түүний орон нутагт ажиллах салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

18.2. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу бэлтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба төсвийн ерөнхийлөн захирагч уг төсвийн төслийг багцдаа тусган батлуулна.

18.3. Үндэсний зөвлөл салбар зөвлөлийн төсвийг тухайн аймаг, нийслэлийн төсөвт тусган баталуулна.

18.4. Үндэсний зөвлөл, түүний салбар зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт бие даасан, хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд хүрэлцээтэй байна.

18.5. Үндэсний зөвлөл, салбар зөвлөл мэдээлэл нийлүүлэгч этгээдээс зээл, хандив, дэмжлэг авахыг хориглоно.

19 дүгээр зүйл. Байгаль орчны хяналтын улсын байцаагч

19.1. Байгаль хамгаалагч байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг ил тод болгох чиглэлээр дараах үүрэгтэй ажиллана:

19.1.1. нэгдсэн порталд байршуулсан мэдээлэл бодит нөхцөлтэй нийцэж байгаа эсэхэд газар дээр нь хяналт тавих;

19.1.2. хяналт шалгалтын дүн, акт, албан шаардлагыг нэгдсэн порталд байршуулах.

ТАВДУГААР БҮЛЭГ

БУСАД

20 дугаар зүйл.Гомдол хянан шийдвэрлэх

20.1.Энэ хуулийн мэдээлэл нийлүүлэгч этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл холбогдох хуулийн дагуу гомдол гаргах эрхтэй:

20.1.1.салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох гомдлыг Үндэсний зөвлөлд;

20.1.2.Үндэсний зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагаатай холбогдох гомдлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасны дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

21 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

21.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

21.2.Энэ хуулийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

22 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

22.1.Энэ хуулийг 2026 оны сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлд газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх, иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байх зарчмыг тогтоосон. Мөн иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй гэж заасан нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг ил тод, хүртээмжтэй, нэгдсэн байдлаар зохицуулах эрх зүйн үндэслэл болж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хууль зүйн үндэслэл, практик шаардлагад тулгуурлан Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулсан болно. Тус хуулийн төсөл нь эрдэс баялаг, ус, ой, амьтан, ургамлын нөөц ашиглалттай холбоотой мэдээлэл, тайланг нэгтгэн ил тод болгох, байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн нэгдсэн архитектур, нэг цонхны цахим портал, тайлагналын нэг мөр журам, олон талт хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэж байна.

Хуулийн зорилго нь байгалийн нөөцийг ашиглахад олон нийт хяналт тавих, иргэний мэдэх эрхийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд оршино. Энэ хүрээнд мэдээлэл, тайлан олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байх, үнэн зөв, бүрэн байх, харилцан уялдаатай, нэгдмэл байх, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх, төр өөрт байгаа буюу нийтийн мэдээллийн дэд бүтцээр авах боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс дахин шаардахгүй байх зарчмыг тусгасан.

Хуулийн төсөл 5 бүлэг, 22 зүйлтэйгээр боловсруулагдсан. Төсөлд хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томьёо, зарчим, байгалийн нөөц ашиглалтын нэгдсэн портал, мэдээллийн нууц, мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, Улсын нэгдсэн тайлан, төрөлжсөн тайлан, тайлангийн зөрүүг хянан шийдвэрлэх журам, Улсын Их Хурал, Засгийн газар, Засаг дарга, Үндэсний зөвлөл, Ажлын алба, санхүүжилт, гомдол, хариуцлагын зохицуулалтыг тусгасан. Хуулийн үйлчлэх хүрээнд амьтан, ус, ой, ургамлын нөөц, эрдэс баялгийг ашиглахтай холбоотой энэ хуульд заасан мэдээлэл, тайланг нээлттэй, ил тод болгох харилцаа хамаарна.

Хуулийн төслийн гол шинэчлэл нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн нэгдсэн портал бөгөөд уг портал нь тайлан, мэдээллийг цахимаар хүлээн авах, бүртгэх, хадгалах, боловсруулах, шалгах, нийтлэх, мэдээлэл солилцох

зориулалттай цахим систем байна. Тус портал нь байгалийн нөөцийн, зөвшөөрлийн, шилэн дансны, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн, татварын болон бусад холбогдох мэдээллийн сантай холбогдож, нэг цонхоор мэдээлэл хүлээн авах, цахим хэлбэрээр баталгаажуулах, төрийн байгууллага мэдээллийг давхар шаардахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хуулийн төсөлд мэдээллийн нууц, гэрээний ил тод байдлыг тусгайлан зохицуулсан. Байгалийн нөөц ашиглалтын улмаас байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, бохирдол, доройтол, осол, нөхөн сэргээлт, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамж, татвар, эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгч, улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого, төрийн болон орон нутгийн өмчит этгээдэд төлсөн төлбөр, ногдол ашиг, хандив, тусламж, дэмжлэгийн мэдээллийг байгууллагын нууцад хамааруулахгүй байхаар тусгасан. Мөн гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийг нэгдсэн порталд бүтнээр нь ил тод байршуулна.

Байгалийн нөөц ашиглалтын Улсын нэгдсэн тайлан нь амьтны нөөц ашиглалт, үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглалт, ой, түүний дагалт баялгийн нөөц ашиглалт, байгалийн ургамлын нөөц ашиглалт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлангаас бүрдэнэ. Үндэсний зөвлөл Ерөнхий сайдын дэргэд олон талт бүтэцтэйгээр ажиллаж, орон тооны Ажлын алба нь мэдээлэл хүлээн авах, Улсын нэгдсэн тайлан боловсруулах, тайлангийн зөрүүг шалгах, санал, зөвлөмж боловсруулах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай зэрэг салбарын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан. Эдгээр өөрчлөлтөөр эцсийн өмчлөгч, эцсийн эзэмшигч, өмчлөлийн хэлхээ холбооны зураглал, гэрээ, аудит, байгаль орчны нөхөн сэргээлт, орон нутгийн гэрээ, мэдээлэл, тайланг нэгдсэн порталд хүргүүлэх зохицуулалтыг уялдуулна.

Иймд хуулийн төсөл батлагдсанаар байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл нэг эх сурвалжид төвлөрч, гэрээ, зөвшөөрөл, төлбөр, татвар, орлого, эцсийн өмчлөгч, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, орон нутгийн гэрээ, хандив, дэмжлэгийн мэдээлэл харилцан уялдаатай, олон нийтэд хүртээмжтэй болно. Энэ нь иргэний мэдэх эрх, олон нийтийн хяналт, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, хариуцлагатай хөрөнгө оруулалт, сайн засаглал, байгаль орчны хариуцлагын итгэлцлийг бэхжүүлэхэд бодит хувь нэмэр оруулах юм.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төсөл

НЭГ. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх суурь зарчмыг тогтоосон. Мөн тус зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байх, байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлах, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэхээр заасан.

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй болохыг Үндсэн хуульд тусгасан нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг ил тод, хүртээмжтэй, нэгдсэн байдлаар зохицуулах эрх зүйн шууд үндэслэл болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй болохыг, мөн тус зүйлийн 17-д төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй болохыг баталгаажуулсан. Иймд байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл нь зөвхөн салбарын техникийн мэдээлэл бус, иргэний үндсэн эрхийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай нийтийн мэдээлэл юм.

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ нь Монгол Улсын Үндсэн хуулийн “ард түмний мэдэл”, “төрийн нийтийн өмч”, “эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх”, “мэдээлэл авах эрх”, “үр өгөөжийг тэгш, шударга хүртээх” зэрэг зарчмыг байгалийн нөөц ашиглалтын бүх үе шатанд бодитоор хэрэгжүүлэх эрх зүйн механизмыг бүрдүүлэхэд чиглэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод газар, түүний нөөцийг зохистой, үр

дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдүүлэх, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлэх, усны нөөцийн мэдээллийн бааз суурийг бэхжүүлэх зэрэг зорилтууд туссан. Эдгээр зорилт нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг нэгдсэн, харьцуулах боломжтой, олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр ил тод болгох хэрэгцээ шаардлагыг улам тодотгож байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-т олборлох салбарын ил тод байдлыг хангах зорилт тусгагдсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд эдийн засаг, нийгмийн урт хугацааны тогтвортой хөгжилд эрдэс баялгийн салбарын үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах анхдагч хуулийн төслийг боловсруулах шаардлагыг тусгасан.

Түүнчлэн Монгол Улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад 2007 онд, Нээлттэй засаглалын түншлэлд 2013 онд тус тус нэгдэн орсон. Энэ хүрээнд олборлох үйлдвэрлэлийн орлого, гэрээ, зөвшөөрөл, эцсийн өмчлөгч, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгаль орчин, орон нутгийн үр өгөөж зэрэг мэдээллийг олон нийтэд ил тод болгох олон улсын үүрэг, амлалтыг хүлээж ирсэн. Гэвч эдгээр үүргийг тогтвортой, хуульчлагдсан, нэгдсэн мэдээллийн тогтолцоогоор хангах эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байна.

Иймд хуулийн төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, авлигын эсрэг бодлого, нээлттэй засаглалын зорилт, олон улсын сайн туршлага, байгалийн баялагт суурилсан эдийн засгийн тогтвортой байдлыг хангах шаардлагад нийцсэн анхдагч хууль юм.

ХОЁР. ПРАКТИК ХЭРЭГЦЭЭ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Монгол Улсын эдийн засагт эрдэс баялаг, газрын тос, түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, ой, амьтан, ургамал зэрэг байгалийн нөөцийн ашиглалт шууд болон шууд бусаар ихээхэн нөлөө үзүүлдэг. Байгалийн нөөц ашиглалт нь төсвийн орлого, дотоод, гадаад худалдаа, орон нутгийн хөгжил, ажлын байр, хөрөнгө оруулалт, байгаль орчин, нийгмийн хариуцлага зэрэг олон төрлийн харилцааг хамардаг.

Одоогийн байдлаар байгалийн нөөц ашиглалттай холбоотой мэдээлэл олон хууль, олон байгууллагын мэдээллийн санд салангид байдлаар зохицуулагдаж байна. Үүний улмаас олон нийт, орон нутгийн иргэд, иргэний нийгэм, судлаачид, хөрөнгө оруулагчид болон төрийн байгууллага өөрөө байгалийн нөөц ашиглалттай холбоотой мэдээллийг нэг эх сурвалжаас, харьцуулах боломжтой, ойлгомжтой хэлбэрээр авахад хүндрэлтэй байгаа бөгөөд практикт дараах асуудлууд нийтлэг байна. Үүнд:

- зөвшөөрөл, гэрээ, төлбөр, орлого, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, орон нутгийн гэрээ, хандив, дэмжлэгийн мэдээлэл хоорондоо холбогдохгүй байх;
- төрийн байгууллагууд нэг ижил мэдээллийг хүн, хуулийн этгээдээс давхар шаардах, тайлагналын ачаалал нэмэгдэх;
- иргэд болон орон нутгийн байгууллага бодит мэдээлэлд суурилан хяналт тавих боломж хязгаарлагдах;
- авлига, ашиг сонирхлын зөрчил, эцсийн өмчлөгчийн далд байдал, гэрээний ил тод бус байдал, байгаль орчны үүргийн хэрэгжилт сулрах эрсдэл нэмэгдэх;
- хөрөнгө оруулагч, олон улсын түнш, санхүүжүүлэгч байгууллагад салбарын засаглалын талаар нэгдсэн, баталгаатай мэдээлэл хүргэх боломж сулрах.

Тиймээс энэ хуулийн төслийн практик үндсэн шаардлага нь зөвхөн “ил тод мэдээлэл” үүргийг нэмэхэд бус, харин байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн нэгдсэн архитектур, нэг цонхны цахим портал, тайлагналын нэг мөр журам, олон талт хяналт, төрийн байгууллагын уялдаа, орон нутгийн оролцоог хуульчлан тогтооход оршино.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗОРИЛГО, БҮТЭЦ, ҮНДСЭН ШИНЭЧЛЭЛ

Хуулийн төслийн зорилго нь байгалийн нөөцийг ашиглахад олон нийт хяналт тавих, иргэний мэдэх эрхийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд оршино. Энэ хүрээнд хуулийн төсөл нь байгалийн нөөц ашиглалтын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй, ойлгомжтой болгох, мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, мэдээлэлд суурилсан олон нийтийн болон олон талт хяналтын механизмыг бүрдүүлэх зорилготой.

Хуулийн төслийг 5 бүлэг, 22 зүйлтэйгээр боловсруулсан. Бүтцийн хувьд хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо, зарчим, мэдээллийн нэгдсэн портал, мэдээллийн нууц, мэдээлэл нийлүүлэгч, Улсын нэгдсэн тайлан, төрөлжсөн тайлан, тайлангийн

зөрүү, төрийн байгууллагын бүрэн эрх, Үндэсний зөвлөл, Ажлын алба, санхүүжилт, байгаль орчны хяналт, гомдол, хариуцлага, хүчин төгөлдөр болох хугацааг тус тус зохицуулсан.

Хуулийн төсөлд дараах үндсэн шинэчлэлийг тусгалаа. Үүнд:

- амьтан, ус, ой, ургамлын нөөц, эрдэс баялгийг ашиглахтай холбоотой мэдээлэл, тайланг хамарсан байгалийн нөөц ашиглалтын нэгдсэн зохицуулалт бий болгох;
- байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн нэгдсэн портал ажиллуулах;
- төр өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцээр солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс дахин шаардахгүй байх зарчмыг тогтоох;
- гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлт, хэрэгжилтийг нээлттэй болгох;
- байгаль орчны нөлөөлөл, төлбөр, хураамж, татвар, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого, эцсийн өмчлөгч, хандив, тусламж, дэмжлэгийн мэдээллийг байгууллагын нууцад хамааруулахгүй байх үндсэн зарчмыг тогтоох;
- Улсын нэгдсэн тайлан, төрөлжсөн тайлан, тайлангийн зөрүүг хянан шийдвэрлэх журмыг хуульчлах;
- Ерөнхий сайдын дэргэд олон талын оролцоотой Үндэсний зөвлөл, орон тооны Ажлын алба ажиллуулах;
- орон нутаг дахь салбар зөвлөлийн үүрэг, Засаг даргын бүрэн эрх, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн мэдээлэл ил тод болгох үүргийг тодорхойлох.

3.1. Хуулийн үйлчлэх хүрээ ба зарчим

Хуулийн төсөл нь амьтан, ус, ой, ургамлын нөөц, эрдэс баялгийг ашиглахтай холбоотой мэдээлэл, тайланг нээлттэй, ил тод болгох харилцаанд үйлчилнэ. Энэ нь уламжлалт “олборлох салбарын ил тод байдал” гэсэн ойлголтыг зөвхөн ашигт малтмал, газрын тосны салбараар хязгаарлахгүй, Үндсэн хуульд заасан байгалийн баялаг бүхэлдээ ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх зарчимтай уялдуулан өргөжүүлж байгаа ач холбогдолтой.

Мэдээллийг ил тод болгохтой холбоотой энэ хуульд тусгайлан заагаагүй бусад харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар зохицуулахаар тусгасан нь мэдээллийн ил тод байдлын ерөнхий хууль болон салбарын тусгай хуулийн уялдааг хангана.

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангахад дараах зарчмыг баримтална:

- мэдээлэл, тайлан олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байх;
- мэдээлэл, тайлан үнэн зөв, бүрэн байх;
- оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
- мэдээлэл, тайлан харилцан уялдаатай, нэгдмэл байх;
- олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх;
- төр өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх.

3.2. Мэдээллийн нэгдсэн портал

Хуулийн төслийн гол зохицуулалтын нэг нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн нэгдсэн портал юм. Нэгдсэн портал нь энэ хуульд заасан тайлан, мэдээллийг цахимаар хүлээн авах, бүртгэх, хадгалах, боловсруулах, шалгах, нийтлэх, мэдээлэл солилцох зориулалттай цахим систем байна.

Нэгдсэн портал нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан шаардлага, нэгдсэн ангилал, код, тайлбарын системд нийцэх бөгөөд бусад хуульд заасан байгалийн нөөцийн, зөвшөөрлийн, шилэн дансны, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн, татварын зэрэг холбогдох мэдээллийн сантай холбогдсон, мэдээлэл солилцох боломжтой байна.

Нэгдсэн порталын хүрээнд дараах зохицуулалтыг хэрэгжүүлнэ:

- тайлан, мэдээ, мэдээллийг нэг цонхоор цахимаар хүлээн авах;
- мэдээллийг цахим гарын үсэг эсхүл хуульд заасан бусад баталгаажуулах арга, хэрэгслээр баталгаажуулах;
- нэгдсэн порталд бүртгэсэн мэдээллийг төрийн байгууллага хүн, хуулийн этгээдээс дахин шаардахгүй байх;
- бусад хуульд заасан тайлан, мэдээ, мэдээллийг нэгдсэн порталаар дамжуулан хүргүүлсэн бол холбогдох төрийн байгууллагад хүргүүлсэнд тооцох;
- нэгдсэн порталд бүртгэгдээгүй, эсхүл баталгаажаагүй мэдээллийг зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, төлөвлөгөө батлах, хяналт шалгалт хийх, тайлан боловсруулах үндэслэл болгохгүй байх;
- порталын мэдээллийг 16 жилээс доошгүй хугацаанд хадгалах.

Энэ зохицуулалт нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг зөвхөн нийтэд ил тод болгохоос гадна төрийн байгууллагын шийдвэр гаргалт, зөвшөөрлийн процесс,

хяналт шалгалт, тайлагнал, бодлогын дүн шинжилгээний үндсэн өгөгдөл болгон ашиглах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3. Мэдээллийн нууц ба гэрээний ил тод байдал

Хуулийн төсөлд мэдээллийн нууцын асуудлыг тусгайлан зохицуулсан. Байгалийн нөөц ашиглалтын улмаас зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, бохирдол, доройтол, осол, нөхөн сэргээлт, аюултай эсхүл хортой бодисын хэрэглээ, хог хаягдал, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамж, татвар, эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгч, улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого, төрийн болон орон нутгийн өмчит этгээдэд төлсөн төлбөр, ногдол ашиг, хандив, тусламж, дэмжлэгийн мэдээллийг байгууллагын нууц болон бусад хуулиар хамгаалагдсан нууц мэдээлэлд хамааруулахгүй байхаар тусгасан.

Мөн энэ хуульд заасан гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийг нэгдсэн порталд бүтнээр нь ил тод байршуулна. Харин хуулиар хамгаалагдсан төрийн болон байгууллагын нууцад хамаарах хэсгийг зохих журмын дагуу нууцалж нийтэлж болох боловч энэ нь гэрээний бусад хэсгийг ил болгох үүргийг хязгаарлахгүй.

Энэ зохицуулалт нь гэрээний ил тод байдлыг байгалийн баялгийн засаглалын гол хэрэгсэл болгон хуульчилж, “нууц” гэсэн ерөнхий үндэслэлээр нийтийн ашиг сонирхлын мэдээллийг хаах эрсдэлийг бууруулна.

3.4. Мэдээлэл нийлүүлэгч, тайлан ба тайлангийн зөрүү

Хуулийн төсөлд зөвшөөрөл эзэмшигч, зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал болон бусад хэлбэрээр санхүүжилт авсан төрийн бус байгууллага, мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагчийг мэдээлэл нийлүүлэгчээр тодорхойлсон.

Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөл олгосноос хойш ажлын 5 өдрийн дотор нэгдсэн порталд бүртгүүлнэ. Төрийн бус байгууллага нь мэдээлэл нийлүүлэгч болох үндэслэл үүссэнээс хойш ажлын 15 өдрийн дотор нэгдсэн порталд бүртгүүлнэ. Мэдээлэл бий болсноос хойш ажлын 10 өдрийн дотор нэгдсэн порталд баталгаажуулан оруулах, тухайн мэдээлэлд өөрчлөлт орсон бол ажлын 5 өдрийн дотор шинэчлэх үүргийг мэдээлэл нийлүүлэгч хүлээнэ.

Байгалийн нөөц ашиглалтын Улсын нэгдсэн тайлан нь амьтны нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан, үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан, ой, түүний дагалт баялгийн нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан,

байгалийн ургамлын нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлангаас бүрдэнэ.

Төрийн байгууллагын, зөвшөөрөл эзэмшигчийн, төрийн бус байгууллагын ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Үндэсний зөвлөлөөс баталсан загварын дагуу гаргаж, нэгдсэн порталд оруулна. Тайлангийн зөрүүг Ажлын алба тодруулж, нэмэлт тайлбар авч, шийдвэрлэх боломжгүй зөрүүг Улсын нэгдсэн тайланд тусган зөвлөмж гаргана.

3.5. Төрийн байгууллага, Үндэсний зөвлөл, Ажлын албаны тогтолцоо

Хуулийн төсөлд төрийн байгууллагын бүрэн эрхийг Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга, Үндэсний зөвлөл, Ажлын алба, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн түвшинд тусгаж өгсөн.

Улсын Их Хурал Засгийн газраас хүргүүлсэн Улсын нэгдсэн тайланг жил бүрийн дөрөвдүгээр улиралд холбогдох байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлт гарган Засгийн газарт чиглэл өгөх бүрэн эрхтэй байна. Засгийн газар хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, Улсын нэгдсэн тайланг бүрдэл бүрээр хэлэлцэн хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт Улсын Их Хуралд хүргүүлэх, байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн жагсаалтыг батлах, Үндэсний зөвлөлийн дүрмийг батлах бүрэн эрхтэй байна.

Үндэсний зөвлөл нь Ерөнхий сайдын дэргэд ажиллах бөгөөд орон тооны Ажлын албатай байна. Үндэсний зөвлөл нь Хүний эрхийн Үндэсний Комисс, Авлигатай тэмцэх газар, байгаль орчин, геологи, уул уурхай, санхүү, төсөв, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх бусад байгууллага, төрийн бус байгууллага, зөвшөөрөл эзэмшигчийн төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байхаар тусгасан.

Ажлын алба нь мэдээлэл нийлүүлэгчээс тайлан хүлээн авах, Улсын нэгдсэн тайлан боловсруулах, мэдээллийн бүрэн байдал, хэлбэр, хугацаа, зөрүүг шалгах, шаардлагатай тохиолдолд шинжээч, мэргэжилтэн оролцуулан дүгнэлт гаргуулах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах санал, зөвлөмж боловсруулах чиг үүрэгтэй.

ДӨРӨВ. ДАГАЛДАХ ХУУЛИУДЫН ШИНЭЧЛЭЛ, СИСТЕМИЙН УЯЛДАА

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд холбогдох салбарын болон бүртгэлийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан. Эдгээр нь энэ хуулийн төслийг дангаар нь бус, харин одоо хүчин төгөлдөр үйлчилж буй зөвшөөрөл, бүртгэл, тайлагнал, байгаль орчин, орон нутгийн гэрээ, эцсийн өмчлөгчийн мэдээлэл, хариуцлагын зохицуулалттай уялдуулах зорилготой.

Дагалдах хуулийн төслүүдээр дараах үндсэн өөрчлөлтийг тусгасан:

- Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд эцсийн өмчлөгч, эцсийн эзэмшигч, тав болон түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, өмчлөлийн хэлхээ холбооны зураглал, улс төрд нөлөө бүхий этгээдийн мэдээллийг бүртгэх, ил тод болгох зохицуулалтыг нарийвчлах;
- Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай хуульд мэдээлэл, тайланг нэгдсэн порталд хүргүүлэх, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн мэдээлэл, гэрээ, аудит, байгаль орчны нөхөн сэргээлт, орон нутгийн гэрээний ил тод байдлыг хангах зохицуулалтыг тусгах;
- Усны тухай, Ойн тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай хуульд тухайн нөөц ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллага зэрэг этгээд байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг нэгдсэн порталд хүргүүлэх үүргийг бий болгох;
- Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Төрийн аудитын тухай, Зөрчлийн тухай зэрэг хуульд нээлттэй мэдээлэл, аудит, хяналт, хариуцлагын зохицуулалтыг энэ хуулийн төсөлтэй уялдуулах.

Ингэснээр энэ хуулийн төсөл нь мэдээллийн нэгдсэн портал, тайлагнал, хяналт, ил тод байдлын ерөнхий тогтолцоог тогтоох бол дагалдах хуулиуд нь тухайн салбарын зөвшөөрөл, гэрээ, бүртгэл, тайлан, хариуцлагын харилцаанд уг тогтолцоог бодитоор хэрэгжүүлэх холболтыг бий болгоно.

ТАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ, ХЭРЭГЖИХ БОЛОМЖ, ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төслийн үр нөлөөг хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу үнэлсэн. Үнэлгээнд зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, ойлгомжтой байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдал, харилцан уялдаа гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авч хуулийн төслийн зохицуулалтыг үнэлсэн.

Зорилгод хүрэх байдлын хувьд хуулийн төсөл нь байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийг тайлагнах, ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, байгалийн баялгаас ард түмэн үр өгөөж хүртэх орчныг бүрдүүлэх зорилготой нийцэж байна гэж дүгнэсэн.

Практикт хэрэгжих боломжийн хувьд Үндэсний зөвлөл, Ажлын албаны зохицуулалт нь шинээр огт бий болж буй бүтэц бус, Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүрээнд олон талт зөвлөл, ажлын хэсэг, ажлын алба ажиллаж ирсэн туршлагад тулгуурлаж байна. Иймд хуулийн төсөл нь одоо байгаа институцийн туршлагыг хуульчлан баталгаажуулах, өргөжүүлэх, тогтвортой болгох шинжтэй.

Ойлгомжтой байдлын хувьд хуулийн төслийг эцэслэн найруулахдаа нэр томьёо, давтамж, хугацаа, мэдээллийн жагсаалт, журам батлах эрх, дагалдах хуулиудын нэр томьёоны нийцлийг нэг мөр болгох шаардлагатай. Тухайлбал, “тогтмол мэдээлэх” зэрэг ойлголтыг нэг мөр тодорхойлох, мөн “олборлох салбар”, “олборлох үйлдвэрлэл”, “байгалийн нөөц ашиглалт” гэсэн нэр томьёоны уялдаа, давхардлыг цэгцлэх шаардлагатай байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдлын хувьд хуулийн төсөл нь иргэний эрх чөлөөг хязгаарлах бус, харин иргэний мэдэх эрх, олон нийтийн хяналт тавих боломжийг нэмэгдүүлнэ. Аж ахуйн нэгжид шинээр тайлагналын үүрэг бий болгож байгаа боловч уг үүрэг нь цахим хэлбэрээр, одоо бүрдэж буй мэдээлэлд тулгуурлан хэрэгжихээр зохицуулагдсан тул зохистой ачааллын хүрээнд байна.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу хийсэн. Зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн ангиллын дагуу авч үзсэн бөгөөд иргэнд шууд үүрэг тусгагдаагүй тул иргэний зардлыг тусгайлан тооцоолоогүй.

Төрийн байгууллагын хувьд хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагууд нь тухайн чиг үүргийг одоо ажиллаж буй хүний нөөц, батлагдсан төсөвтөө тулгуурлан хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн. Харин Үндэсний зөвлөл, Ажлын алба болон салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардалд жилд 248.4 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж тооцсон. Үүнээс ажилтнуудын цалин, урамшуулалд 151.8 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 96.6 сая төгрөг тусгагдсан.

Хуулийн этгээдийн хувьд мэдээллийн санд бүртгүүлэх, ил тод байдлын тайлан гаргах, Үндэсний зөвлөл, Ажлын албанаас тавьсан тодруулгын хариу өгөх, мэдээллийг цахимаар хүргүүлэх зэрэг үүрэг нь тухайн байгууллагын нягтлан бодогч, геологич, байгаль орчны ажилтан зэрэг одоо ажиллаж буй хүний нөөцийн ажлын хүрээнд хэрэгжих боломжтой гэж үзсэн. Тиймээс тайлан гаргагч болон хуулийн этгээд хэрэгжүүлэгчдэд нэмэлт зардал үүсэхгүй гэж тооцсон.

Иймд хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал нь хүлээгдэж буй үр өгөөжтэй харьцуулахад бага бөгөөд салбарын ил тод байдал, хариуцлага, мэдээллийн чанар, төрийн байгууллагын шийдвэр гаргалт, олон нийтийн хяналтыг сайжруулах нийгэм, эдийн засгийн ач холбогдол өндөр байна.

ЗУРГАА. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын эрх зүйн орчныг бүрдүүлснээр урт хугацаанд дараах эерэг үр дүн гарах боломжтой:

- байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл нэгдсэн порталд төвлөрч, олон нийт нэг эх сурвалжаас мэдээлэл авах боломж бүрдэнэ;
- төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, төрийн бус байгууллагын тайлагналын үүрэг, хариуцлага тодорхой болно;
- гэрээ, зөвшөөрөл, төлбөр, татвар, орлого, эцсийн өмчлөгч, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, орон нутгийн гэрээ, хандив, дэмжлэгийн мэдээлэл уялдаатай, харьцуулах боломжтой болно;
- төрийн байгууллага нэг ижил мэдээллийг давхар шаардахгүй байх, цахим мэдээлэл солилцох, нэг цонхны зарчим хэрэгжих нөхцөл бүрдэнэ;
- олон нийтийн хяналт, иргэний мэдэх эрх, орон нутгийн оролцоо нэмэгдэнэ;
- авлига, ашиг сонирхлын зөрчил, эцсийн өмчлөгчийн далд байдал, гэрээний ил тод бус байдлаас үүдэх эрсдэл буурна;

- Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний зөвлөл, салбар зөвлөл, Ажлын алба хоорондын тайлагнал, хяналтын тогтолцоо бүрдэнэ;
- хариуцлагатай хөрөнгө оруулалт, сайн засаглал, байгаль орчны хариуцлагын итгэлцэл нэмэгдэнэ;
- Монгол Улсын олон улсын үүрэг, амлалт, нээлттэй засаглалын зорилт, ОУИТБС-ын стандартын хэрэгжилт бэхжинэ.

Хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр Монгол Улсад байгалийн баялгийн засаглалыг мэдээлэлд суурилсан, нээлттэй, хариуцлагатай, олон нийтийн хяналттай болгох эрх зүйн суурь бэхжинэ. Энэ нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих, байгаль орчны хамгаалалт, орон нутгийн оролцоо, олон улсын итгэлцлийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулах юм.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд дараах агуулга бүхий заалт нэмсүгэй.

1/ 12 дугаар зүйлийн 12.2.5дахь заалт:

“12.2.5. Байгалийн нөөц ашиглах чиглэлээр зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааны тав болон түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч, эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн нэр, иргэний харьяалал, төрсөн огноо (хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газрын хаяг), тэдгээрийн аль нэг нь улс төрд нөлөө бүхий этгээд эсэх мэдээлэл, улс төрд нөлөө бүхий этгээдэд тооцогдож эхэлсэн бол улс төрд нөлөө бүхий этгээдэд тооцогдож эхэлсэн хугацаа.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

“4.1.12."эцсийн эзэмшигч" гэж Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.48-д заасан этгээдийг.”

2 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт:

“10.1.14.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, эцсийн эзэмшигч, хуулийн этгээдийн хувьцааны тав болон түүнээс хувийн хувьцаа эзэмшигч хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний харьяалал, төрсөн огноо, улс төрд нөлөө бүхий этгээд эсэх мэдээлэл, улс төрд нөлөө бүхий этгээдэд тооцогдож эхэлсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газрын хаяг, хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл.”

2/14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт:

“14.2.10.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, эцсийн эзэмшигч, хуулийн этгээдийн хувьцааны тав болон түүнээс хувийн хувьцаа эзэмшигч хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний харьяалал, төрсөн огноо, улс төрд нөлөө бүхий этгээд эсэх мэдээлэл, улс төрд нөлөө бүхий этгээдэд тооцогдож эхэлсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газрын хаяг, хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтынБайгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашиг малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/45 дугаар зүйлийн 45.3, 45.4, 45.5, 45.6 дахь хэсэг:

“45.3. Уурхайн талбайг нийтийн зориулалтаар ашиглахад аюулгүй болгосон арга хэмжээ, уурхайн эдэлбэр байсан газрыг нийтийн зориулалтаар ашиглахад аюул учирч болзошгүй бол түүнээс сэргийлсэн арга хэмжээний тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны албаар баталгаажуулсан байгаль орчныг нөхөн сэргээсэн арга хэмжээний тайлан болон холбогдох нотлох баримтын хамт тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг буцаан өгөхөөс өмнө ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

45.4. Байгаль орчныг нөхөн сэргээсэн арга хэмжээний тайланг холбогдох нотлох баримтын хамт аймаг, нийслэлийн байгаль орны албанд хүргүүлнэ.

45.5. Энэ хуулийн 45.3, 45.4-т заасан тайланг хүлээн авсан байгууллага нь тайлангийн үнэн зөв байдалд хяналт шалгалт хийж, тайланг баталгаажуулна.

45.6. Энэ хуулийн 45.3-т заасан тайлангийн маягт, тайлан гаргах заавар, холбогдох нотлох баримтын жагсаалт, түүнд тавигдах шаардлагыг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан Үндэсний зөвлөл батална.”

2/48 дугаар зүйлийн 48.15 дахь хэсэг:

“48.15. Тусгай зөвшөөрөл эзэмшигч Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл, тайланг гаргаж тус хуульд заасан нэгдсэн порталд хүргүүлнэ.”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийн “тайлан,” гэсний дараа “хайгуулын ажлын төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөө,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг:

“2.1. Ашигт малтмалын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгалийн нөөц ашиглалтын Байгалийн нөөц ашиглалтын ил тод

байдлын тухай, Хөрөнгө оруулалтын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

2/35 дугаар зүйлийн 35.12 дахь хэсэг:

“35.12.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хаяг, цахим шуудан, утас, факсны дугаар, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч өөрчлөгдсөн тохиолдолд 14 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.”

3/48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсэг:

“48.10.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд олборлосон, борлуулсан ашигт малтмал, баяжмал, бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэлгээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, орон нутагт өгсөн хандив, дэмжлэгийн хэмжээ, тусгай зөвшөөрөл тус бүрээр гаргасан зардлын хэмжээ, хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, тэдгээрийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл, төрийн болон нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.”

4/42 дугаар зүйл:

“42 дугаар зүйл.Нутгийн захиргааны байгууллагатай харилцах

42.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдуулан орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, Монгол Улсын иргэдийн ажлын байр нэмэгдүүлэх, уурхайн ажилтны эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл, нийгмийн асуудал, тухайн сум, дүүргийн иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах асуудлаар тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших нутгийн захиргааны байгууллагатай гэрээг байгуулна.

42.2.Стратегийн ач холбогдол бүхий орд газрын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан гэрээг аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулна.

42.3.Энэ хуулийн 42.2-т зааснаас бусад ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 42.1-д заасан гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулна.

42.4.Энэ хуулийн 42.1-д заасан гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигч уурхай ашиглахын өмнө байгуулах ба гэрээний загвар, гэрээ байгуулах журмыг Засгийн газар батална.

42.5.Нутгийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан энэ хуулийн 42.1-д заасан гэрээг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана.

42.6.Нутгийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 42.1-д заасан гэрээнд тусгагдаагүй хандив, тусламж, дэмжлэгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахыг хориглоно.

42.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нутгийн захиргааны байгууллагаас баталсан хуваарийн дагуу энэ хуулийн 42.1-д заасан гэрээний хэрэгжилтийн талаар болон бусад шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлгийг тухайн орон нутагт жил тутам явуулна.

42.8.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэ хуулийн 42.1-д заасан гэрээний хэрэгжилт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа болон түүний байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох эрх бүхий байгууллага болон иргэний нийгмийн байгууллага, мэргэжилтэн, шинжээч, тухайн орон нутгийн иргэдийн бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулж болно.”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.2.21, 11.2.22 дахь заалт:

“11.2.21.гэрээлэгч нь Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл, тайланг нэгдсэн порталд хүргүүлэх;

2/36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг:

“36.1.Гэрээлэгч нь Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл, тайланг гаргаж нэгдсэн порталд хүргүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалт:

“8.4.4. Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл, тайланг гаргаж нэгдсэн порталд хүргүүлэх.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт:

“20.1.10.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл, тайланг гаргаж нэгдсэн порталд хүргүүлэх.”

2/25 дугаар зүйлийн 25.7, 25.8, 25.9, 25.10 дахь хэсэг:

“25.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдуулан орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, Монгол Улсын иргэдийн ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж, дэмжлэг өгөх асуудлаар тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай гэрээг байгуулна.

25.8.Энэ хуулийн 25.7-д заасан гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигч уурхай ашиглахын өмнө байгуулах ба гэрээний загвар, гэрээ байгуулах журмыг Засгийн газар батална.

25.9.Сум, дүүргийн Засаг дарга нь тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан энэ хуулийн 25.7-д заасан гэрээг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана.

25.10.Нутгийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 25.7-д заасан гэрээнд тусгагдаагүй хандив, тусламж, дэмжлэгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахыг хориглоно.

25.11.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нутгийн захиргааны байгууллагаас баталсан хуваарийн дагуу энэ хуулийн 25.7-д заасан гэрээний хэрэгжилтийн талаар болон бусад шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлгийг тухайн орон нутагт жил тутам явуулна.

25.12.Сум, дүүргийн Засаг дарга нь энэ хуулийн 25.7-д заасан гэрээний хэрэгжилт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа болон түүний байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох эрх бүхий байгууллага болон иргэний нийгмийн байгууллага, мэргэжилтэн, шинжээч, тухайн орон нутгийн иргэдийн бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулж болно.”

3/34 дүгээр зүйлийн 34.10 дахь заалт:

“34.10.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээ, хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, тэдгээрийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл, нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээг дараа оны 01 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.”

3 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийн “17.10-т” гэснийг “38 дугаар зүйлийн 38.2-т” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 28 дугаар зүйлийн 28.4.6 дахь заалт:

“28.4.6.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл, тайланг гаргаж нэгдсэн порталд хүргүүлэх.”

2/28 дугаар зүйлийн 28.6.6 дахь заалт:

“28.6.6.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл, тайланг гаргаж нэгдсэн порталд хүргүүлэх.”

3/29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг:

“29.5.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ зүйлд заасан гэрээг байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор тус гэрээг нийтэд цахимаар ил тод болгоно.”

4/30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг:

“30.5.Засгийн газар нь энэ хуулийн 30.1-д заасан гэрээг байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор тус гэрээг нийтэд цахимаар ил тод болгоно.”

5/34 дүгээр зүйлийн 34.9 дэх хэсэг:

“34.9.Энэ хуулийн 34.2-т заасан үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нууцлахыг хориглоно.”

2 дугаар зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалт:

“7.2.1.энэ хуулийн 7.1.1-д заасан шийдвэрийн албан ёсны эх хувь, хувьцааг өмчлөл, эзэмшил, ашиглалтдаа авах этгээдийн нэр, хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч этгээдийн буюу хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний харьяалал, төрсөн огноо, улс төрд нөлөө бүхий этгээд эсэх мэдээлэл, улс төрд нөлөө бүхий этгээдэд тооцогдож эхэлсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл,

хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газрын хаяг, хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл болон уг шийдвэртэй холбоотой Цөмийн энергийн комиссоос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

“15.37 дугаар зүйл.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль зөрчих

1.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль зөрчсөн, эсхүл тус хуульд заасан Үндэсний зөвлөлийн шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгож, арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.20 дахь хэсэг:

“9.20.Хуульд нээлттэй байхаар заасан мэдээлэл нь хязгаарлалттай мэдээлэлд хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн аудитын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг:

“37.7. Төрийн аудитын байгууллага нь Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасны дагуу ил тод байдлын тайлан гаргаж нэгдсэн порталд хүргүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.14, 3.1.15 дахь заалт:

“3.1.14.“хувьцаа эзэмшигч” гэж Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн 10.1.14-т заасан этгээдийг;

3.1.15.“эцсийн өмчлөгч” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан хүнийг.”

2/32 дугаар зүйлийн 32.3.4 дэх заалт:

“32.3.4.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл.”

3/34 дүгээр зүйлийн 34.12 дахь хэсэг:

“34.12.Сум, дүүргийн газрын даамал нь энэ хуулийн 34.1-д заасан гэрээг байгуулмагц ажлын 5 өдрийн дотор цахимаар нийтэд ил тод болгоно.”

4/37 дугаар зүйлийн 37.1.4 дэх заалт:

“37.1.4. хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл.”

5/38 дугаар зүйлийн 38.2.5 дахь заалт:

“38.2.5.эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээдийн хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн мэдээлэл.”

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.2 дахь заалтын "явуулах" гэсний дараа "тус гэрээг ил тод байлгах;" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Газрын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/35 дугаар зүйлийн 35.3.6 дахь заалт:

“35.3.6.энэ хуульд заасны дагуу эрхийн гэрчилгээгээ барьцаалах, шилжүүлэх, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч өөрчлөгдөх бүрт улсын бүртгэлд бүртгүүлэх.”

4 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.8 дахь хэсгийн “34.7-34.10” гэснийг “34.7-34.12” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт:

“2/нутаг дэвсгэртээ газрын хэвлийн баялгийг ашиглуулахтай холбогдуулан эдэлбэр газар олгох, эдэлбэр газар олголтын мэдээллийг нийтэд ил тод байлгах;”

2/8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

“4/ердийн ашигт малтмал, газар доорхи цэнгэг усыг ашиглах тухай саналыг холбогдох байгууллагад тавих, ердийн ашигт малтмалын ордыг зохистой ашиглах болон газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулахад хяналт тавих, засаж тохижуулсан газрыг хүлээн авах, түүнтэй холбогдох мэдээллийг нийтэд ил тод байлгах;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 11 дэх заалтын “олборлох үйлдвэрийн” гэснийг “эрдэс баялаг, олборлох үйлдвэрлэлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Усны тухай хуулийн доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг:

“7.6.Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг тус хуульд заасан нэгдсэн порталд хүргүүлэх үүрэгтэй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг:

“6.6.Ой ашиглагч иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, ойн мэргэжлийн байгууллага Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг тус хуульд заасан нэгдсэн порталд хүргүүлэх үүрэгтэй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дах хэсгийн “санд” гэсний дараа “Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг тус хуульд заасан нэгдсэн порталд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсэг:

“8.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг тус хуульд заасан нэгдсэн порталд хүргүүлэх.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Амьтны тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг:

“25.8.Иргэн, хуулийн этгээд Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг тус хуульд заасан нэгдсэн порталд хүргүүлэх.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ
АНХДАГЧ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТУХАЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2026

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАНУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын байгалийн баялаг нь зөвхөн ашигт малтмал, газрын тос, нүүрс, зэс зэрэг эрдэс баялгаар хязгаарлагдахгүй. Монгол Улсын Үндсэн хуульд газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх зарчмыг тогтоосон байна. Иймээс олборлох үйлдвэрлэл буюу эрдэс баялгийн салбар нь байгалийн баялгийн нэг хэсэг бөгөөд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын асуудлыг зөвхөн уул уурхай, газрын тосоор хязгаарлан авч үзэх нь хангалтгүй байна.

Байгалийн нөөц ашиглалт нь Монгол Улсын эдийн засаг, төсөв, экспорт, орон нутгийн хөгжил, ажлын байр, хөрөнгө оруулалт, байгаль орчны хамгаалал, иргэний мэдэх эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй шууд холбоотой байна. Ялангуяа эрдэс баялгийн салбар нь эдийн засгийн хувьд хамгийн том жинтэй байгалийн нөөц ашиглалтын төрөл хэвээр байна. Ашигт малтмал, газрын тосны газрын 2026 оны 3 дугаар сарын 31-ний статистик мэдээгээр хүчин төгөлдөр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл 2,831, тусгай зөвшөөрөл бүхий талбай 7.259 сая га, улсын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь 4.5 хувь байна.

Гэвч байгалийн нөөц ашиглалтын асуудал нь зөвхөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, олборлолт, экспортын мэдээллээр хязгаарлагдахгүй. Ус ашиглалт, ойн нөөц ашиглалт, ан амьтан, байгалийн ургамал ашиглалт, газар, газрын хэвлий, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, орон нутгийн гэрээ, хандив дэмжлэг, төсөвт төвлөрөх төлбөр, татвар, эцсийн өмчлөгчийн мэдээлэл зэрэг олон төрлийн мэдээлэл энэ хүрээнд хамаарч байна. Иймээс байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг илүү өргөн хүрээнд, байгалийн баялгийн нийтлэг засаглалын асуудал гэж авч үзэх шаардлага байгаа эсэхийг тандан судлах шаардлагатай байна.

Одоогийн байдлаар байгалийн нөөц ашиглалттай холбоотой мэдээлэл Монгол Улсад огт байхгүй гэсэн үг биш юм. Харин мэдээлэл олон хууль, олон байгууллага, олон цахим систем, мэдээллийн санд салангид байдлаар бүрдэж байна. Тухайлбал, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл нэг эх сурвалжид, гэрээний мэдээлэл өөр эх сурвалжид, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө өөр мэдээллийн санд, төсөв, төлбөрийн мэдээлэл шилэн данс болон төсвийн системд, эцсийн өмчлөгчийн мэдээлэл улсын бүртгэл болон ОҮИТБС-ын тайлагналын хүрээнд тус тус бүрдэж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль нь иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим, нээлттэй, ил тод, шуурхай болгох зорилготой байна. Мөн Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх журам болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журмыг баталсан байна. Уг журмаар нээлттэй өгөгдлийг машин унших боломжтой хэлбэрээр, тухайлбал XML, CSV, JSON, RDF, GeoJSON зэрэг нийтлэг форматаар нийтлэх шаардлагыг тогтоосон байна.

Гэвч байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл нь ерөнхий мэдээллийн ил тод байдлын хүрээнээс илүү нарийн шинжтэй байна. Учир нь энэ төрлийн мэдээлэл нь зөвшөөрөл, гэрээ, төлбөр, татвар, хураамж, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, ус ашиглалт, орон нутгийн үр өгөөж, эцсийн өмчлөгч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа зэрэг олон төрлийн харилцааг нэгтгэн харуулах шаардлагатай. Иймээс зөвхөн “мэдээллийг нийтлэх” бус, мэдээллийг нэгтгэх, баталгаажуулах, харьцуулах, тайлангийн зөрүүг тодруулах, олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр хүргэх тусгай зохицуулалт шаардлагатай эсэхийг судлах хэрэгтэй байна.

Монгол Улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлж ирсэн нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн ил тод байдлын нэг чухал туршлага юм. ОУИТБС-ын нэгтгэлийн тайлангийн мэдээллээр гэрээний ил тод байдлын мэдээллийн санд 1,365 гэрээ бүртгэгдсэн, эцсийн өмчлөгчийн мэдээллийн хувьд 452 аж ахуйн нэгж тайлагнасан бөгөөд тэдгээрийн 88 хувь нь өмчлөгчөө хувь хүний түвшинд тодорхойлсон байна. Мөн эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд 2026 оны байдлаар 1,545 гэрээ, 61 эрдсийн төрөл, 16 баримтын төрөл, 28 гэрээний төрөл, 1,111 компани, 333 төрийн байгууллагын мэдээлэл бүртгэгдсэн байна.

Гэвч энэхүү туршлага нь үндсэндээ олборлох үйлдвэрлэл буюу уул уурхай, газрын тосны салбарт төвлөрч ирсэн байна. Байгаль орчны мэдээллийн төвийн цахим системд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын лавлагаа, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлан, ОУИТБС-ын цахим тайлангийн систем зэрэг холбогдох мэдээллийн эх сурвалжууд тус тус байрлаж байна. Энэ нь мэдээллийн сангууд байгаа боловч тэдгээрийг байгалийн нөөц ашиглалтын нэгдсэн мэдээллийн архитектур болгон холбох хэрэгцээ байгаа эсэхийг судлах шаардлагатайг харуулж байна.

Иймд энэ тандан судалгааны хүрээнд байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн өнөөгийн байдал, мэдээллийн сангуудын уялдаа, олон нийтэд мэдээлэл хүрч байгаа хэлбэр, мэдээлэл нийлүүлэгчийн үүрэг, төрийн байгууллагын мэдээлэл солилцоо, гэрээ ба эцсийн өмчлөгчийн ил тод байдал, байгаль орчны мэдээллийн ашиглалт, тайлангийн зөрүү, нууц мэдээллийн ялгаа, орон нутгийн оролцоо зэрэг асуудлыг судлах шаардлагатай байна.

Доорх хүснэгтэд Монгол Улсад одоо ашиглагдаж байгаа, байгалийн нөөц ашиглалтын ил тод байдалтай хамаарах мэдээллийн сан, цахим системүүдийг зөвхөн энэ судалгаанд хамаарах хүрээгээр нэгтгэн харуулав.

Монгол Улсын зарим мэдээллийн сан, цахим систем

Мэдээллийн сан, цахим систем	Хамаарах мэдээлэл	Судалгаанд хамаарах асуудал
Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын мэдээлэл	Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, тусгай	Эрдэс баялгийн зөвшөөрлийн мэдээлэл байгалийн нөөц ашиглалтын бусад мэдээлэлтэй, тухайлбал гэрээ, төлбөр, байгаль орчны нөлөөлөл,

	зөвшөөрлийн талбай, эзэмшигчийн мэдээлэл	нөхөн сэргээлттэй холбогдох шаардлага байгаа эсэх
ОУИТБС-ын цахим тайлангийн систем	Олборлох үйлдвэрлэлийн төлбөр, орлого, компани, төрийн байгууллагын тайлан, тайлангийн тулгалт	ОУИТБС-ын туршлагыг бүх байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн ил тод байдлын суурь болгон өргөжүүлэх хэрэгцээ байгаа эсэх
Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан /iltodgerree.mn/	Уул уурхай, газрын тосны салбарын гэрээ, орон нутгийн гэрээ, бичил уурхайн гэрээ, газар ашиглах гэрээ зэрэг	Гэрээний ил тод байдлыг зөвхөн олборлох салбараар хязгаарлахгүй, байгалийн нөөц ашиглалтын бусад гэрээ, хэлэлцээртэй холбох шаардлага байгаа эсэх
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан	Төслийн мэдээлэл, байршил, төсөл хэрэгжүүлэгч, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний мэдээлэл	Зөвшөөрөл, гэрээ, олборлолт, ус ашиглалт, нөхөн сэргээлтийн мэдээлэлтэй уялдуулах шаардлага байгаа эсэх
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлангийн сан	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлт, хамгаалах арга хэмжээ, зардлын мэдээлэл	Байгаль орчны үүргийн хэрэгжилт, нөхөн сэргээлт, олон нийтийн хяналтад ашиглах боломжийг нэмэгдүүлэх хэрэгцээ байгаа эсэх
Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын лавлагаа	Ой, ус, тусгай хамгаалалттай газрын байршил, кадастрын мэдээлэл	Байгалийн нөөц ашиглалтын зөвшөөрөл, төлбөр, орон нутгийн мэдээлэлтэй холбох шаардлага байгаа эсэх
Шилэн дансны цахим систем	Төсөв, орлого, зарлага, төрийн болон орон нутгийн байгууллагын санхүүгийн мэдээлэл	Байгалийн нөөц ашигласны төлбөр, орон нутгийн төсөвт төвлөрсөн орлого, тусгай сан, хандив, зарцуулалтын мэдээлэлтэй уялдуулах хэрэгцээ байгаа эсэх
Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал	Төрийн байгууллагуудын нийтлэх нээлттэй өгөгдөл	Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг машин унших, татаж авах, харьцуулах боломжтой нээлттэй өгөгдөл болгох шаардлага байгаа эсэх

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл	Хуулийн этгээд, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчтэй холбоотой бүртгэлийн мэдээлэл	Байгалийн нөөц ашиглагчийн эцсийн өмчлөгч, улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой мэдээллийг зөвшөөрөл, гэрээ, төлбөрийн мэдээлэлтэй холбох шаардлага байгаа эсэх
Нийтийн мэдээллийн дэд бүтэц, мэдээлэл солилцооны систем	Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоо	Нэг ижил мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс дахин шаардахгүй байх, төр өөрт байгаа мэдээллийг солилцож ашиглах боломжийг байгалийн нөөц ашиглалтын хүрээнд нарийвчлах шаардлага байгаа эсэх

Дээрхээс үзэхэд Монгол Улсад байгалийн нөөц ашиглалттай холбоотой олон мэдээллийн сан, цахим систем аль хэдийн бий болсон байна. Харин асуудал нь эдгээр мэдээллийн сан байхгүйд бус, тэдгээрийн хоорондын уялдаа, мэдээллийн стандарт, нийтлэх хэлбэр, баталгаажуулалт, тайлангийн зөрүү, олон нийтийн ойлгомжтой хэрэглээ, төрийн шийдвэр гаргалтад ашиглах механизм хангалттай эсэхэд оршиж байна.

Иймээс энэхүү тандан судалгаагаар дараах үндсэн асуултуудыг тодруулах шаардлагатай байна:

1. Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг одоо байгаа олон мэдээллийн сангаас нэгтгэн харах эрх зүйн үндэс шаардлагатай эсэх;
2. Мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг тусгайлан тодорхойлох шаардлагатай эсэх;
3. Гэрээ, төлбөр, татвар, байгаль орчны мэдээлэл, нөхөн сэргээлт, эцсийн өмчлөгчийн мэдээллийг байгууллагын нууц нэрээр хаах эрсдэлийг бууруулах шаардлагатай эсэх;
4. Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг нэг цонхны цахим зарчмаар олон нийтэд хүргэх хэрэгцээ байгаа эсэх;
5. Төрийн байгууллага өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс дахин шаардахгүй байх зарчмыг байгалийн нөөц ашиглалтын мэдээлэлд хэрэгжүүлэх шаардлагатай эсэх;
6. Олон талт оролцоотой, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хяналтын тогтолцоог хуульчлах хэрэгцээ байгаа эсэх.

Ийнхүү “Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай” анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагыг судлахдаа зөвхөн олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн ил тод байдлын асуудлаар хязгаарлахгүй, харин байгалийн нөөцийн бүх төрлийн ашиглалттай холбоотой мэдээллийн салангид байдал, олон нийтийн хяналт, байгаль орчны хариуцлага, орон нутгийн үр өгөөж, авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн шийдвэр гаргалтын чанарыг хамтад нь авч үзэх нь зүйтэй байна.

Судалгааны аргачлал

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэв:

- Асуудалд дүн шинжилгээ хийх;
- Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
- Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
- Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
- Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
- Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
- Зөвлөмж боловсруулах.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1. Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн ил тод байдлын хэрэгцээ

Монгол Улсад байгалийн нөөц ашиглалт нь эдийн засаг, төсөв, экспорт, орон нутгийн хөгжил, ажлын байр, хөрөнгө оруулалт, байгаль орчны хамгаалал болон иргэний үндсэн эрхтэй шууд холбоотой байна.

Байгалийн нөөц гэдэгт зөвхөн ашигт малтмал, газрын тос, нүүрс, зэс зэрэг эрдэс баялаг хамаарахгүй. Монгол Улсын Үндсэн хуульд газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх зарчмыг тогтоосон. Иймээс олборлох үйлдвэрлэл буюу эрдэс баялгийн салбар нь байгалийн баялгийн нэг хэсэг бөгөөд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг зөвхөн уул уурхайгаар хязгаарлах нь хангалтгүй байна.

Өнөөдрийн байдлаар ашигт малтмал, газрын тос, түгээмэл тархацтай ашигт малтмал, цөмийн энергийн түүхий эд, ус, ой, амьтан, байгалийн ургамал ашиглахтай холбоотой зөвшөөрөл, гэрээ, төлбөр, татвар, хураамж, орлого, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, орон нутгийн гэрээ, хандив, дэмжлэг, эцсийн өмчлөгчийн мэдээлэл зэрэг олон төрлийн мэдээлэл төрийн өөр өөр байгууллага, өөр өөр мэдээллийн сан, өөр өөр тайлагналын хэлбэрээр бүрдэж байна.

Энэ нь нэг талаас төрийн байгууллагын мэдээлэл солилцоог хүндрүүлж, нөгөө талаас иргэд, орон нутгийн иргэд, иргэний нийгэм, судлаачид, хөрөнгө оруулагчид байгалийн нөөц ашиглалтын талаарх мэдээллийг нэг эх сурвалжаас, ойлгомжтой, харьцуулах боломжтой хэлбэрээр авах нөхцөлийг хязгаарлаж байна.

Мэдээлэл нь зөвхөн тайлан гаргах хэрэгсэл биш юм. Байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл нь:

- иргэний мэдэх эрхийг хангах,
- эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах,
- байгаль орчны хяналтыг сайжруулах,
- төсвийн орлого, төлбөр, татварын ил тод байдлыг хангах,
- авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх,
- хөрөнгө оруулалтын итгэлцлийг нэмэгдүүлэх,
- орон нутгийн иргэдийн оролцоо, хяналтыг дэмжих суурь нөхцөл болж байна.

Иймээс байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг зөвхөн олборлох салбарын хүрээнд бус, байгалийн баялгийн нийтлэг хүрээнд авч үзэх хэрэгцээ бий болсон эсэхийг тандан судлах шаардлагатай байна.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ

Асуудлын гол нь байгалийн нөөц ашиглалтын талаарх мэдээлэл салангид, давхардсан, харилцан уялдаагүй, олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр хүрэхгүй байгаад оршино. Өөрөөр хэлбэл, байгалийн нөөц ашиглалтын талаар мэдээлэл огт байхгүй гэсэн үг биш. Харин байгаа

мэдээлэл нь олон байгууллагад тархсан, өөр өөр хэлбэрээр хадгалагдсан, нэг стандартгүй, хооронд нь харьцуулахад хүндрэлтэй, зарим тохиолдолд олон нийтэд нээлттэй бус байна.

Асуудлын цар хүрээ нь зөвхөн ашигт малтмал, газрын тосны тайлагналын асуудлаар хязгаарлагдахгүй. Ус ашиглалт, ойн нөөц ашиглалт, ан амьтан, байгалийн ургамлын ашиглалт, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, төлбөр, хураамж, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого, гэрээ, хандив, дэмжлэг, эцсийн өмчлөгчийн мэдээлэл зэрэг олон төрлийн мэдээлэл хамаарч байна.

Иймд дараах асуудлыг тандан судлах шаардлагатай байна:

- байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг нэгтгэх эрх зүйн үндэс шаардлагатай эсэх;
- төрийн байгууллагуудын мэдээллийн сан хооронд уялдаа бий болгох хэрэгцээ байгаа эсэх;
- мэдээллийг нэг цонхны цахим системээр олон нийтэд хүргэх шаардлага байгаа эсэх;
- мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг хуулиар тодорхойлох шаардлагатай эсэх;
- гэрээ, төлбөр, татвар, эцсийн өмчлөгч, байгаль орчны мэдээллийг байгууллагын нууц нэрээр хаах эрсдэлийг бууруулах шаардлага байгаа эсэх;
- тайлангийн зөрүүг тодруулах, засварлуулах, олон нийтэд тайлбарлах механизм шаардлагатай эсэх.

Иймээс энэ судалгаанд шийдвэрлэх гэж буй асуудлыг дараах байдлаар тодорхойлж болно:

Байгалийн нөөц ашиглалтын талаарх нийтийн ач холбогдол бүхий мэдээлэл олон хууль, байгууллага, мэдээллийн санд салангид, давхардсан, харилцан уялдаагүй байгаа тул уг мэдээллийг нэгдсэн, баталгаатай, олон нийтэд нээлттэй, ойлгомжтой, харьцуулах боломжтой болгох эрх зүйн зохицуулалт шаардлагатай эсэхийг тандан судлах.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд

Байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл салангид, дутуу, ойлгомжгүй байх нь дараах этгээд, бүлгийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлж байна.

Эрх ашиг нь хөндөгдөж буй этгээд	Нөлөөлж буй хэлбэр
1. Иргэд, орон нутгийн иргэд	Байгалийн нөөц ашиглалттай холбоотой гэрээ, төлбөр, орлого, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлтийн мэдээллийг авах боломж хязгаарлагдсанаар мэдэх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, олон нийтийн хяналт тавих боломж хөндөгдөнө.
2. Нөлөөлөлд өртсөн олон нийт	Тухайн орон нутагт ямар зөвшөөрөл олгогдсон, ямар гэрээ байгуулсан, ямар төлбөр төвлөрсөн, ямар нөхөн сэргээлт хийгдсэн талаар бүрэн мэдээлэлгүй байх нь итгэлцэл буурах, маргаан үүсэх эрсдэлийг нэмэгдүүлнэ.
3. Зөвшөөрөл	Нэг ижил мэдээллийг олон байгууллагад өөр өөр хэлбэрээр

эзэмшигч, байгалийн нөөц ашиглагч	хүргүүлэх шаардлага нь тайлагналын давхардал, захиргааны ачаалал, эрх зүйн тодорхойгүй байдал үүсгэнэ.
4. Төрийн байгууллага	Мэдээллийн сангууд хоорондоо холбогдоогүйгээс зөвшөөрөл олгох, сунгах, хяналт шалгалт хийх, бодлого боловсруулахад шаардлагатай мэдээллийг бүрэн ашиглах боломж хязгаарлагдана.
5. Орон нутгийн байгууллага	Орон нутгийн гэрээ, хандив, дэмжлэг, тусгай сан, нөхөн сэргээлт, байгаль орчны мэдээлэл нэгдсэн бус байх нь нутгийн иргэдийн өмнө тайлагнах, хяналт хэрэгжүүлэх боломжийг сулруулна.
6. Иргэний нийгэм, судлаачид, хэвлэл мэдээлэл	Нээлттэй, харьцуулах боломжтой, баталгаатай мэдээлэл байхгүйгээс хараат бус судалгаа хийх, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх, бодлогын санал боловсруулах боломж хязгаарлагдана.
7. Хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч	Гэрээ, зөвшөөрөл, эцсийн өмчлөгч, байгаль орчны хариуцлага, орон нутгийн харилцааны мэдээлэл тодорхой бус байх нь хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлнэ.
8. Ирээдүй үе, байгаль орчны нийтлэг ашиг сонирхол	Ус, ой, амьтан, ургамал, газар, газрын хэвлийн нөөцийн ашиглалт, нөхөн сэргээлт, бохирдол, хаалтын мэдээлэл хангалтгүй байх нь байгалийн нөөцийг урт хугацаанд хамгаалах, үе хоорондын шударга ёсыг хангахад сөргөөр нөлөөлнө.

Дээрхээс үзэхэд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын асуудал нь зөвхөн төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигчийн хоорондын тайлагналын асуудал биш байна. Энэ нь иргэний мэдэх эрх, байгаль орчны хамгаалал, орон нутгийн оролцоо, авлигаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулалтын итгэлцэл, төрийн шийдвэр гаргалтын чанарт шууд хамаарах өргөн хүрээний асуудал байна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

1. Мэдээлэл олон газарт салангид байна

Байгалийн нөөц ашиглалттай холбоотой мэдээлэл олон салбарын хуулиар зохицуулагдаж байна. Ашигт малтмал, газрын тос, ус, ой, амьтан, ургамал, газар, татвар, улсын бүртгэл, шилэн данс, байгаль орчны мэдээлэл тус тусдаа мэдээллийн сантай байна.

Гэвч эдгээр мэдээллийг нэгтгэх, харилцан солилцох, олон нийтэд нэг цонхоор хүргэх тогтолцоо хангалттай бүрдээгүй байна. Үүний улмаас иргэд болон төрийн байгууллага өөрөө ч байгалийн нөөц ашиглалтын талаарх бүрэн зураглалыг нэг дороос харахад хүндрэлтэй байна.

2. Ерөнхий мэдээллийн хууль хангалтгүй байна

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль нь мэдээллийн ил тод байдлын ерөнхий зохицуулалтыг тогтоосон. Гэвч байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл нь өөрийн онцлогтой.

Тухайлбал, зөвшөөрөл, гэрээ, төлбөр, татвар, эцсийн өмчлөгч, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, орон нутгийн гэрээ, хандив, дэмжлэг, тайлангийн зөрүү зэрэг мэдээлэл нь тусгай

зохицуулалт шаарддаг. Иймээс ерөнхий мэдээллийн хуулиас гадна байгалийн нөөц ашиглалтын онцлогт тохирсон тусгай зохицуулалт хэрэгтэй эсэхийг судлах шаардлагатай байна.

3. ОУИТБС-ын туршлага хуульчлагдаагүй байна

Монгол Улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг олон жил хэрэгжүүлж ирсэн. Энэ хүрээнд тайлагнал, олон талт зөвлөл, ажлын алба, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн оролцооны тодорхой туршлага бий болсон.

Гэвч энэ тогтолцоо үндсэндээ Засгийн газрын тогтоол, зохион байгуулалтын арга хэмжээнд тулгуурлаж ирсэн. Үндэсний зөвлөл, Ажлын алба, салбар зөвлөлийн эрх хэмжээ, санхүүжилт, мэдээлэл шаардах, тайлан нэгтгэх, зөрүү тодруулах, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах асуудал хуулиар бүрэн баталгаажаагүй байна.

Ийм нөхцөлд ил тод байдлын тогтолцоо нь тогтвортой, бие даасан, бүх байгалийн нөөцийн төрөлд хэрэгжих хэмжээнд хөгжихөд хүндрэлтэй байна.

4. Гэрээ, эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүрэн нээлттэй биш байна

Байгалийн нөөц ашиглагч болон төр, орон нутгийн байгууллага хооронд байгуулсан гэрээ, орон нутгийн хөгжлийн гэрээ, хандив тусламж, нийгмийн хариуцлагын зарцуулалт, эцсийн өмчлөгч, улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой мэдээлэл бүрэн, нэгдсэн, харьцуулах боломжтой хэлбэрээр нийтэд нээлттэй бус байна.

Энэ нь авлига, ашиг сонирхлын зөрчил, далд өмчлөл, шударга бус өрсөлдөөн, орон нутгийн түвшний үл ойлголцол үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

5. Байгаль орчны мэдээлэл хяналтад бүрэн ашиглагдахгүй байна

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, орчны хяналт-шинжилгээ, ус ашиглалт, бохирдол, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, акт, албан шаардлагын мэдээлэл олон нийтэд нэгтгэсэн, баталгаатай, ойлгомжтой хэлбэрээр хүрэхгүй байна.

Үүний улмаас байгаль орчны хяналт зөвхөн төрийн байгууллагын дотоод ажиллагаа мэт үлдэж, орон нутгийн иргэд, иргэний нийгэм, судлаачдын бодит хяналт сулрах эрсдэлтэй байна.

6. Тайлагнал давхарддаг

Зөвшөөрөл эзэмшигч нэг ижил мэдээллийг олон байгууллагад өөр өөр маягт, өөр өөр хугацаа, өөр өөр сувгаар хүргүүлэх шаардлагатай тохиолдол байна. Энэ нь аж ахуйн нэгжид захиргааны ачаалал үүсгэж, тайлангийн чанар, үнэн зөв байдал, цаг хугацаанд нь хүргүүлэх боломжид сөргөөр нөлөөлж байна.

Иймээс төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс дахин шаардахгүй байх, мэдээллийг нэг удаа бүртгээд олон байгууллага ашиглах, нэг цонхны цахим зарчим хэрэгжүүлэх хэрэгцээ байгаа эсэхийг судлах шаардлагатай байна.

7. Нууц мэдээллийн ялгаа тодорхойгүй байна

Байгалийн нөөц ашиглалттай холбоотой зарим мэдээллийг байгууллагын нууц, худалдааны нууц, дотоод мэдээлэл гэх үндэслэлээр нийтэд гаргахгүй байх эрсдэл байна.

Гэвч байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, бохирдол, нөхөн сэргээлт, төлбөр, татвар, орон

нутгийн орлого, эцсийн өмчлөгч, хандив, дэмжлэг зэрэг мэдээлэл нь нийтийн ашиг сонирхлын шинжтэй. Иймээс ямар мэдээллийг нууцад хамааруулахгүй байх, ямар мэдээллийг ямар нөхцөлөөр хязгаарлах, нууцалсан ч тайлагнах үүргээс чөлөөлөгдөхгүй байх зарчмыг тодорхой болгох хэрэгцээ байна.

8. Тайлангийн зөрүүг шийдвэрлэх механизм сул байна

Төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, төрийн бус байгууллагын тайлан хооронд зөрүү гарах боломжтой. Гэвч ийм зөрүүг тодруулах, тайлбар авах, засварлуулах, олон нийтэд тайлбарлах, цаашид авах арга хэмжээний зөвлөмж гаргах тогтолцоо хангалттай тодорхой биш байна.

Иймээс тайлангийн зөрүүг шийдвэрлэх, зөрүүг Улсын нэгдсэн тайланд тусгах, холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх эрх зүйн механизм шаардлагатай эсэхийг судлах нь зүйтэй байна.

9. Мэдээлэл олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр хүрэхгүй байна

Зарим мэдээлэл цахим орчинд байгаа боловч PDF, зураг, скан, тайлангийн хавсралт зэрэг хэлбэрээр байршуулсан байдаг. Ийм мэдээлэл нь “нээлттэй” мэт боловч бодит байдал дээр хайх, боловсруулах, харьцуулах, дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.

Иймээс байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг зөвхөн нийтлэх бус, олон нийт ойлгох, хайх, татаж авах, харьцуулах, дүн шинжилгээ хийх боломжтой хэлбэрээр нийтлэх хэрэгцээ байна.

10. Орон нутгийн оролцоо сул байна

Байгалийн нөөц ашиглалтын нөлөөлөл хамгийн түрүүнд орон нутагт мэдрэгддэг. Гэвч тухайн орон нутагт ямар зөвшөөрөл олгогдсон, ямар гэрээ байгуулсан, ямар төлбөр орсон, ямар хандив дэмжлэг өгсөн, ямар нөхөн сэргээлт хийсэн, байгаль орчинд ямар нөлөө үзүүлсэн талаар нэгтгэсэн мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байна.

Энэ нь нутгийн иргэдийн итгэлцэл буурах, маргаан үүсэх, хяналт сулрах, байгалийн нөөц ашиглалтын үр өгөөж шударга хүртэж байгаа эсэхэд эргэлзээ төрөх шалтгаан болж байна.

Иймээс байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тогтолцоонд орон нутгийн оролцоо, салбар зөвлөл, олон нийтийн хяналт, гомдол мэдээлэл гаргах боломжийг тусгах хэрэгцээ байгаа эсэхийг тандан судлах шаардлагатай байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Өмнөх бүлэгт хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд байгалийн нөөц ашиглалттай холбоотой мэдээлэл нь Монгол Улсад огт байхгүй бус, харин олон хууль, олон байгууллага, олон мэдээллийн санд салангид байдлаар бүрдэж байна. Үүний улмаас зөвшөөрөл, гэрээ, төлбөр, татвар, хураамж, орлого, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, орон нутгийн гэрээ, хандив, дэмжлэг, эцсийн өмчлөгчийн мэдээллийг нэг эх сурвалжаас, ойлгомжтой, баталгаатай, харьцуулах боломжтой хэлбэрээр авах нөхцөл хангалтгүй байна. Ийм нөхцөлд асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго:

Байгалийн нөөц ашиглалттай холбоотой нийтийн ач холбогдол бүхий мэдээллийг нэгдсэн, баталгаатай, ойлгомжтой, харьцуулах боломжтой, олон нийтэд нээлттэй болгох замаар иргэний мэдэх эрх, олон нийтийн хяналт, байгаль орчны хариуцлага, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалт шаардлагатай эсэхийг тандан судлах.

Энэхүү зорилго нь зөвхөн олборлох үйлдвэрлэлийн мэдээллийг ил тод болгох асуудлаар хязгаарлагдахгүй. Ашигт малтмал, газрын тос, түгээмэл тархацтай ашигт малтмал, цөмийн эрчим хүчний түүхий эд зэрэг эрдэс баялгийн мэдээллээс гадна ус, ой, амьтан, байгалийн ургамлын нөөц ашиглалттай холбоотой мэдээллийг мөн хамрах шаардлага бий эсэхийг авч үзнэ. Мөн байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг ил тод болгох асуудлыг зөвхөн “мэдээлэл нийтлэх” хэлбэрээр бус, харин мэдээллийг бүрдүүлэх, баталгаажуулах, нэгтгэх, солилцох, тайлангийн зөрүүг тодруулах, олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх, төрийн шийдвэр гаргалтад ашиглах тогтолцооны асуудал гэж үзэх нь зүйтэй байна.

Дээрх зорилгын хүрээнд дараах асуудлыг тусгайлан судална.

2.1. Мэдээллийг нэгтгэх хэрэгцээ

Байгалийн нөөц ашиглалттай холбоотой мэдээлэл өнөөдөр олон байгууллагад салангид бүрдэж байгаа тул уг мэдээллийг нэг цонхны зарчмаар хүлээн авах, хадгалах, боловсруулах, шалгах, нийтлэх, солилцох цахим тогтолцоо шаардлагатай эсэхийг судална.

Энэ хүрээнд зөвшөөрөл, гэрээ, төлбөр, татвар, байгаль орчны мэдээлэл, нөхөн сэргээлт, орон нутгийн гэрээ, хандив дэмжлэг, эцсийн өмчлөгчийн мэдээллийг хооронд нь холбож харах боломж бүрдүүлэх хэрэгцээ байгаа эсэхийг авч үзнэ.

2.2. Мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүргийг тодорхой болгох хэрэгцээ

Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг хэн, ямар хугацаанд, ямар хэлбэрээр, ямар хариуцлагатайгаар гаргах нь тодорхой байх шаардлагатай.

Иймээс төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, байгалийн нөөц ашиглагч, төрийн бус байгууллага зэрэг мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг тусгайлан тодорхойлох шаардлага байгаа эсэхийг судална.

Энэ нь нэг талаас олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэх, нөгөө талаас мэдээлэл нийлүүлэгчид давхардсан, тодорхойгүй, хэт ачаалалтай тайлагнал үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой байж болох юм.

2.3. Тайлан, зөрүү, баталгаажуулалтын тогтолцоог судлах хэрэгцээ

Байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл нь олон эх сурвалжаас бүрдэх тул төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, бусад мэдээлэл нийлүүлэгчийн тайланд зөрүү гарах боломжтой.

Иймээс Улсын нэгдсэн тайлан, төрөлжсөн тайлан, тайлангийн зөрүүг тодруулах, тайлбар авах, засварлуулах, олон нийтэд мэдээлэх, цаашид авах арга хэмжээний зөвлөмж гаргах тогтолцоо шаардлагатай эсэхийг судална.

Мэдээллийг зөвхөн цуглуулах бус, түүний үнэн зөв, бүрэн, харьцуулах боломжтой байдлыг баталгаажуулах шаардлага байгаа эсэх нь энэ хэсгийн гол асуудал болно.

2.4. Нийтийн ашиг сонирхлын мэдээллийг ил тод болгох хэрэгцээ

Байгалийн нөөц ашиглалттай холбоотой зарим мэдээлэл нь хувийн хэвшлийн арилжааны үйл ажиллагаатай холбоотой байж болох боловч зарим мэдээлэл нь шууд нийтийн ашиг сонирхлын шинжтэй байна.

Тухайлбал:

- гэрээ, хэлэлцээр;
- зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн мэдээлэл;
- төлбөр, татвар, хураамж;
- улсын болон орон нутгийн төсөвт төвлөрсөн орлого;
- хандив, тусламж, дэмжлэг;
- эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч;
- байгаль орчны нөлөөлөл;
- ус ашиглалт, бохирдол;
- нөхөн сэргээлт, уурхайн хаалт;
- орон нутгийн гэрээ, түүний хэрэгжилт зэрэг мэдээлэл нь олон нийтийн хяналт, байгаль орчны хамгаалал, авлигаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой байна.

Иймээс эдгээр мэдээллийг байгууллагын нууц, худалдааны нууц, дотоод мэдээлэл гэх үндэслэлээр хаах эрсдэлийг бууруулах тусгай зохицуулалт шаардлагатай эсэхийг судална.

2.5. Олон талт хяналтын тогтолцоог судлах хэрэгцээ

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотой олон талт зөвлөл, ажлын албаны туршлага бий болсон байна.

Гэвч уг туршлагыг зөвхөн зохион байгуулалтын арга хэмжээний түвшинд бус, илүү тогтвортой, эрх хэмжээ нь тодорхой, санхүүжилт нь ойлгомжтой, тайлан мэдээлэлтэй ажиллах боломжтой тогтолцоо болгох хэрэгцээ байгаа эсэхийг судлах шаардлагатай байна.

Энэ хүрээнд Үндэсний зөвлөл, Ажлын алба, салбар зөвлөл зэрэг олон талт оролцооны бүтцийг хууль тогтоомжийн түвшинд тодорхойлох шаардлагатай эсэхийг авч үзнэ.

2.6. Давхардсан тайлагналыг бууруулах хэрэгцээ

Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцээр дамжуулан авах боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс дахин дахин шаардах нь захиргааны ачаалал үүсгэж байна.

Иймээс нэг ижил мэдээллийг нэг удаа бүртгэж, төрийн байгууллагууд хоорондоо солилцож ашиглах, мэдээлэл нийлүүлэгчээс давхар тайлан шаардахгүй байх зарчмыг байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэхийг судална.

Энэ нь төрийн байгууллагын мэдээлэл солилцоог сайжруулахын зэрэгцээ зөвшөөрөл эзэмшигч, байгалийн нөөц ашиглагчийн тайлагналын ачааллыг бууруулах боломжтой эсэхийг тодорхойлоход ач холбогдолтой.

2.7. Салбарын хуулиудын уялдааг сайжруулах хэрэгцээ

Байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл нь ашигт малтмал, газрын тос, ус, ой, амьтан, байгалийн ургамал, улсын бүртгэл, татвар, шилэн данс, байгаль орчин, зөвшөөрөл зэрэг олон салбарын хуультай холбогдож байна.

Иймээс зөвхөн нэг анхдагч хууль батлах асуудлаар хязгаарлахгүйгээр холбогдох салбарын болон бүртгэлийн хуулиудад уялдуулсан нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхийг судлах нь зүйтэй байна.

Энэ хүрээнд дараах асуудлыг авч үзнэ:

- зөвшөөрөл, бүртгэлийн мэдээллийг нэгдсэн мэдээллийн тогтолцоотой холбох;
- гэрээ, тайлан, төлбөр, байгаль орчны мэдээллийн уялдааг хангах;
- эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигчийн мэдээллийг тодорхой болгох;
- орон нутгийн гэрээ, хандив, дэмжлэгийн мэдээллийг ил тод болгох;
- байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалт, ус ашиглалтын мэдээллийг олон нийтэд ойлгомжтой болгох;
- төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийг ил тод, хяналттай болгох.

Иймд асуудлыг шийдвэрлэх зорилго нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг зөвхөн нэг удаа нийтлэх, эсхүл нэг байгууллагын тайлангаар хязгаарлах бус, харин байгалийн нөөцийн бүх төрөлтэй холбоотой нийтийн ач холбогдол бүхий мэдээллийг нэгтгэх, баталгаажуулах, харьцуулах, олон нийтэд ойлгомжтой хүргэх, төрийн шийдвэр гаргалтад ашиглах эрх зүйн тогтолцоо шаардлагатай эсэхийг тодорхойлоход оршино.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

“Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу өмнөх бүлгүүдэд тодорхойлсон асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбаруудыг авч үзэв. Энэхүү шатанд хуулийн төсөл боловсруулах асуудлыг шууд урьдчилан шийдвэрлэх бус, харин тухайн асуудлыг хууль тогтоомжийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх шаардлага байгаа эсэхийг бусад хувилбартай харьцуулан судлах нь зүйтэй байна.

Өмнөх бүлгүүдэд дурдсанчлан байгалийн нөөц ашиглалттай холбоотой мэдээлэл олон хууль, олон байгууллага, олон мэдээллийн санд салангид байдлаар бүрдэж байна. Иймээс уг асуудлыг зөвхөн шинээр хууль боловсруулах замаар бус, мөн одоогийн хууль тогтоомж, захиргааны шийдвэр, цахим систем, сургалт, олон талт оролцоо зэрэг бусад хувилбараар шийдвэрлэх боломжтой эсэхийг харьцуулан авч үзэх шаардлагатай.

Хүснэгт 2. Зохицуулалтын хувилбаруудын харьцуулалт

Хувилбар	Зорилгод хүрэх боломж	Зардал, үр өгөөжийн харьцаа	Урьдчилсан дүгнэлт
1. “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхгүй байх	Одоогийн хууль, журам, мэдээллийн сан, тайлагналын арга хэмжээг хэвээр үлдээнэ. Энэ тохиолдолд мэдээлэл олон байгууллага, олон системд салангид хэвээр байх, иргэд нэг эх сурвалжаас ойлгомжтой мэдээлэл авах боломж хязгаарлагдах эрсдэлтэй.	Шууд нэмэлт зардал гарахгүй. Гэвч мэдээллийн чанар, олон нийтийн хяналт, байгаль орчны хариуцлага, авлигаас урьдчилан сэргийлэх үр нөлөө сул хэвээр үлдэх магадлалтай.	Суурь асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдмал.
2. Хэвлэл мэдээлэл, сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ авах	Ил тод байдлын ач холбогдлын талаар иргэд, төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигчийн ойлголтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж болно. Гэвч мэдээлэл хэн гаргах, ямар хугацаанд гаргах, ямар мэдээллийг нээлттэй	Сургалт, сурталчилгааны тодорхой зардал гарна. Харин мэдээллийн эрх зүйн болон байгууллагын суурь асуудал хэвээр үлдэх тул үр өгөөж хязгаарлагдмал байна.	Дэмжих арга хэмжээ байж болох боловч үндсэн шийдэл болох боломжгүй.

	байлгах, тайлангийн зөрүүг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлыг дангаар шийдвэрлэхгүй.		
3. Зах зээлийн механизмаар дамжуулан зохицуулах	Байгалийн нөөц ашиглалт нь нийтийн өмч, төрийн зөвшөөрөл, гэрээ, татвар, төлбөр, байгаль орчны хариуцлага, орон нутгийн үр өгөөжтэй холбоотой тул зөвхөн зах зээлийн өөрөө зохицуулах механизмаар ил тод байдлыг бүрэн хангах боломжгүй.	Зарим аж ахуйн нэгж сайн дурын үндсэн дээр мэдээлэл нийтэлж болох боловч мэдээллийн бүрэн байдал, үнэн зөв, харьцуулах боломж, хариуцлага баталгаажихгүй.	Дангаар хэрэглэхэд тохиромжгүй.
4. Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Цахим систем, сургалт, техникийн шинэчлэл, мэдээллийн сангийн хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлж болно. Гэвч мэдээлэл нийлүүлэх үүрэг, мэдээллийн нууцын ялгаа, гэрээний ил тод байдал, тайлангийн зөрүү, хариуцлагын асуудлыг санхүүжилтээр дангаар шийдвэрлэх боломжгүй.	Төсвийн зардал шаардана. Эрх зүйн тодорхой зохицуулалтгүй бол санхүүжилтийн үр дүн тогтвортой байх эсэх нь эргэлзээтэй.	Дэмжих хэрэгсэл байж болох боловч бие даасан шийдэл биш.
5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Иргэний нийгэм, мэргэжлийн холбоо, хувийн хэвшил нь мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах, хараат бус дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй. Гэвч мэдээлэл шаардах, төрийн мэдээллийн сантай холбох, мэдээллийн нууцын ялгаа тогтоох,	Тодорхой ажил гүйцэтгүүлэхэд зардал гарна. Гэвч төрийн үндсэн чиг үүрэг, албан ёсны мэдээллийн баталгаа, иргэний мэдэх эрхийн хамгаалалтыг орлохгүй.	Туслах хувилбар байж болох ч үндсэн зохицуулалтыг орлохгүй.

	хариуцлага тооцох зэрэг нийтийн эрх зүйн чиг үүргийг дангаар хэрэгжүүлэх боломжгүй.		
6. Захиргааны шийдвэр, журам, хэм хэмжээний актаар зохицуулах	Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, журам, цахим системийн зохион байгуулалтаар зарим техникийн асуудлыг шийдвэрлэх боломжтой. Гэвч мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, гэрээний ил тод байдал, мэдээллийн нууцын ялгаа, тайлангийн зөрүү, хариуцлага, олон байгууллагын уялдаа зэрэг асуудлыг бүрэн зохицуулахад хязгаарлагдмал.	Шууд зардал харьцангуй бага байж болно. Гэвч эрх зүйн тогтвортой байдал, хэрэгжилтийн хүч, байгууллага хоорондын уялдаа сул байх эрсдэлтэй.	Богино хугацаанд ашиглаж болох ч дунд, урт хугацааны цогц шийдэл болох боломж хязгаарлагдмал.
7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг нэгтгэх, мэдээлэл нийлүүлэгчийн үүрэг, мэдээллийн нууцын ялгаа, гэрээний ил тод байдал, тайлангийн зөрүү, олон талт хяналт, холбогдох хуулиудын уялдааг нэг зарчимд оруулах боломжтой эсэхийг судлах хувилбар юм.	Хэрэгжилтийн зардал, байгууллагын чадавх, цахим системийн уялдаа, мэдээлэл нийлүүлэгчийн ачааллыг нарийвчлан тооцох шаардлагатай. Гэхдээ мэдээллийн давхардал буурах, олон нийтийн хяналт сайжрах, авлигын эрсдэл буурах, хөрөнгө оруулалтын итгэлцэл нэмэгдэх боломжтой.	Цаашид нарийвчлан судлах шаардлагатай хамгийн цогц хувилбар байж болох юм.

Дээрх хувилбаруудаас үзэхэд “тэг” хувилбар, сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ, зах зээлийн механизм, санхүүгийн дэмжлэг, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлээр тодорхой ажил гүйцэтгүүлэх зэрэг нь тодорхой хэмжээнд дэмжих ач холбогдолтой байж болно. Гэвч эдгээр хувилбар нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн салангид байдал, тайлагналын давхардал, мэдээллийн нууцын тодорхойгүй байдал, гэрээ болон эцсийн өмчлөгчийн

мэдээллийн ил тод байдал, байгаль орчны мэдээллийн ашиглалт, тайлангийн зөрүү, олон талт хяналтын сул талыг бүрэн шийдвэрлэхэд хангалтгүй байна.

Захиргааны шийдвэр, журам, хэм хэмжээний акт гаргах хувилбар нь богино хугацаанд зарим зохион байгуулалтын болон техникийн асуудлыг шийдвэрлэх боломжтой. Гэвч байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн ил тод байдлын асуудал нь олон хууль, олон байгууллага, олон эрх ашиг, нийтийн мэдээлэл, нууц мэдээлэл, гэрээ, зөвшөөрөл, байгаль орчин, татвар, төлбөр, орон нутгийн үр өгөөжтэй холбогдож байгаа тул зөвхөн захиргааны түвшний шийдвэрээр бүрэн шийдвэрлэхэд хүндрэлтэй байна. Иймд цаашид дараах хоёр хувилбарыг илүү нарийвчлан судлах нь зүйтэй гэж үзэв.

Хувилбар 1. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлага байгаа эсэхийг судлах

Энэ хувилбарын хүрээнд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах анхдагч хууль боловсруулах шаардлага байгаа эсэх, мөн холбогдох салбарын болон бүртгэлийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ бий эсэхийг судална. Уг хувилбар нь дараах асуудлыг хууль тогтоомжийн түвшинд шийдвэрлэх шаардлага байгаа эсэхийг шалгана:

- байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг нэг эх сурвалжаас авах боломж бүрдүүлэх;
- мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;
- төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, бусад мэдээлэл нийлүүлэгчийн тайлангийн уялдааг хангах;
- гэрээ, төлбөр, татвар, хандив, дэмжлэг, эцсийн өмчлөгч, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт зэрэг нийтийн ашиг сонирхлын мэдээллийг ил тод болгох хэрэгцээг тодорхойлох;
- мэдээллийн нууцын ялгаа, нууцлах нөхцөл, хугацаа, шалгуурыг тодорхой болгох шаардлага байгаа эсэхийг судлах;
- тайлангийн зөрүүг тодруулах, засварлуулах, тайлбарлуулах, олон нийтэд мэдээлэх механизм шаардлагатай эсэхийг авч үзэх;
- олон талт оролцоотой хяналт, зөвлөмж, тайлагналын тогтолцоо хэрэгтэй эсэхийг судлах;
- төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс дахин шаардахгүй байх зарчмыг байгалийн нөөц ашиглалтын мэдээлэлд хэрэгжүүлэх боломжийг үнэлэх;
- салбарын хуулиудад байгаа зөвшөөрөл, гэрээ, тайлан, бүртгэл, хариуцлагын зохицуулалтыг мэдээллийн нэгдсэн тогтолцоотой уялдуулах шаардлага байгаа эсэхийг судлах.

Энэ хувилбарын давуу тал нь асуудлыг хэсэгчлэн бус, байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн засаглалын нийтлэг асуудал гэж авч үзэх боломжтойд оршино. Харин сул тал нь хууль боловсруулах тохиолдолд хэрэгжилтийн зардал, төрийн байгууллагын чадавх,

мэдээллийн системийн уялдаа, хувийн хэвшлийн тайлагналын ачаалал, мэдээллийн нууцтай холбоотой маргааныг нарийвчлан тооцох шаардлагатайд оршино.

Хувилбар 2. Одоогийн хууль тогтоомжийн хүрээнд захиргааны шийдвэр, журам, хэм хэмжээний актаар зохицуулах

Энэ хувилбарын хүрээнд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, салбарын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, журам, цахим мэдээллийн системийн зохион байгуулалтын арга хэмжээг ашиглан байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах боломжийг авч үзнэ. Уг хувилбараар дараах асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх боломжтой байж болно:

- төрийн байгууллагын мэдээлэл нийтлэх журам, маягтыг сайжруулах;
- одоо байгаа мэдээллийн сангуудын холбоос, лавлагааг сайжруулах;
- нээлттэй өгөгдлийн жагсаалтад байгалийн нөөцтэй холбоотой өгөгдлийг нэмэх;
- ОУИТБС болон бусад цахим тайлагналын практикийг идэвхжүүлэх;
- байгууллага хоорондын мэдээлэл солилцоог захиргааны түвшинд нэмэгдүүлэх;
- сургалт, аргачлал, зөвлөмжөөр мэдээллийн чанарыг сайжруулах.

Гэвч энэ хувилбар дараах хязгаарлалттай байна. Үүнд:

- захиргааны шийдвэр нь зөвхөн тухайн хуульд олгосон эрх хэмжээний хүрээнд үйлчилнэ;
- мэдээлэл нийлүүлэгчийн үүрэг, хариуцлагыг бүх салбарт нэг мөр тогтоох боломж хязгаарлагдана;
- гэрээ, эцсийн өмчлөгч, хандив, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт зэрэг нийтийн ашиг сонирхлын мэдээллийг нууцад хамааруулахгүй байх зарчмыг журам дангаар бүрэн баталгаажуулах боломжгүй;
- тайлангийн зөрүү, зөвлөмжийн хэрэгжилт, олон талт хяналтын тогтолцоог захиргааны шийдвэрээр тогтвортой хэрэгжүүлэхэд хүндрэлтэй;
- олон салбарын хуульд байгаа тайлагнал, зөвшөөрөл, бүртгэл, хариуцлагын зохицуулалтыг нэг журамд уялдуулах боломж хязгаарлагдмал.

Иймээс захиргааны шийдвэр, журам, хэм хэмжээний акт нь богино хугацаанд зохион байгуулалтын зарим асуудлыг сайжруулахад ашиглаж болох боловч байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн нэгдсэн, тогтвортой, олон талт хяналттай тогтолцоог бүрдүүлэх үндсэн хувилбар болох боломж хязгаарлагдмал байна.

Энэ шатны харьцуулалтаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлага байгаа эсэхийг цаашид нарийвчлан судлах нь зүйтэй гэж үзэв. Гэхдээ энэ нь хуулийн төсөл боловсруулах эцсийн шийдвэр биш бөгөөд дараагийн бүлэгт уг хувилбарын хүний эрх, эдийн

засаг, нийгэм, байгаль орчин, төрийн байгууллага, хууль тогтоомжийн уялдаанд үзүүлэх үр нөлөөг илүү нарийвчлан тандан судлах шаардлагатай.

Иймд дараагийн шатанд дараах хоёр хувилбарыг голчлон харьцуулна:

Хувилбар 1: Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлага байгаа эсэхийг судлах;

Хувилбар 2: Одоогийн хууль тогтоомжийн хүрээнд захиргааны шийдвэр, журам, хэм хэмжээний актаар зохицуулах боломжийг судлах.

Энэ хоёр хувилбарыг зорилгод хүрэх байдал, зардал-үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчин, хууль тогтоомжийн уялдаа зэрэг шалгуураар дараагийн бүлэгт нарийвчлан авч үзнэ.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Өмнөх бүлэгт хийсэн харьцуулалтаас үзэхэд байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн салангид байдал, тайлагналын давхардал, гэрээ болон эцсийн өмчлөгчийн мэдээллийн ил тод бус байдал, байгаль орчны мэдээллийн ашиглалт, тайлангийн зөрүү, олон нийтийн хяналтын сул талыг зөвхөн захиргааны шийдвэр, журам, сургалт, санхүүгийн дэмжлэгээр бүрэн шийдвэрлэхэд хүндрэлтэй байж болзошгүй байна.

Иймээс энэ бүлэгт хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон тохиолдолд хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчин, хууль тогтоомжийн нийцэлд ямар үр нөлөө үзүүлж болохыг урьдчилан тандан судлав.

Энэ нь хуулийн төсөл аль хэдийн боловсруулагдсан, батлагдсан гэсэн утга биш юм. Харин байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын асуудлыг хууль тогтоомжийн түвшинд зохицуулах шаардлага байгаа эсэхийг үнэлэх зорилготой.

1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг ил тод болгох эрх зүйн зохицуулалт бий болгох хувилбар нь иргэний мэдэх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, олон нийтийн хяналт тавих боломж, байгалийн баялгийн үр өгөөжийг шударгаар хүртэх зарчимтай шууд холбоотой байна.

Энэ хувилбар нь иргэний эрхийг хязгаарлах бус, харин нийтийн ач холбогдол бүхий мэдээллийг илүү ойлгомжтой, нээлттэй, баталгаатай болгох замаар эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг сайжруулах боломжтой. Гэхдээ эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч, улс төрд нөлөө бүхий этгээд, гэрээ, төлбөр, байгаль орчны мэдээллийг ил тод болгохдоо хувийн мэдээлэл, байгууллагын нууц, худалдааны нууцтай холбоотой тэнцвэрийг нарийвчлан тогтоох шаардлага үүснэ.

Хүснэгт 3. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Мэдээлэл авах эрх	Иргэд байгалийн нөөц ашиглалтын талаарх мэдээллийг илүү нээлттэй авах боломж бүрдэх эсэх	Тийм	Зөвшөөрөл, гэрээ, төлбөр, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, орон нутгийн үр өгөөжийн мэдээллийг нэгдсэн, ойлгомжтой хэлбэрээр хүргэх эрх зүйн зохицуулалт бий болгох боломжтой.
2. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх	Байгаль орчны мэдээлэл ил тод болсноор иргэдийн хяналт сайжрах эсэх	Тийм	Ус ашиглалт, бохирдол, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, байгаль орчны хяналт-шинжилгээний мэдээлэл илүү хүртээмжтэй болбол орон нутгийн иргэд хяналт тавих боломж нэмэгдэнэ.

3. Ялгаварлан гадуурхахгүй байх	Мэдээлэл авах боломжийг бүх иргэн, олон нийгэд тэгш олгох эсэх	Тийм	Мэдээллийг зөвхөн төрийн байгууллага, компани хоорондын тайлангаар хязгаарлахгүй, олон нийгэд нээлттэй болгох зохицуулалт шаардлагатай эсэхийг судална.
4. Оролцоог хангах	Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх эсэх	Тийм	Орон нутгийн иргэд, иргэний нийгэм, судлаач, хэвлэл мэдээлэл бодит мэдээлэлд тулгуурлан хяналт, хэлэлцүүлэгт оролцох боломжтой болно.
5. Хувийн мэдээлэл, нууцын тэнцвэр	Ил тод байдлын зохицуулалт хувийн мэдээлэл, бизнесийн нууцад нөлөөлөх эсэх	Тодорхой хэмжээнд	Эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч, улс төрд нөлөө бүхий этгээдийн мэдээлэл нь нийтийн ашиг сонирхолтой холбоотой байж болох ч ямар мэдээллийг нийтлэх, ямар мэдээллийг хамгаалахыг тодорхой заах шаардлагатай.
6. Эрх агуулагч ба үүрэг хүлээгч	Эрх агуулагч, үүрэг хүлээгчийг тодорхойлох шаардлага бий эсэх	Тийм	Иргэн, олон нийт, орон нутгийн иргэд эрх агуулагч; төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, мэдээлэл нийлүүлэгчид үүрэг хүлээгч байх боломжтой. Үүнийг хууль тогтоомжийн түвшинд тодорхойлох шаардлага байгаа эсэхийг судална.

Дээрхээс үзэхэд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхийг хязгаарлах бус, харин иргэний мэдээлэл авах эрх, орон нутгийн иргэдийн хяналт, байгаль орчны мэдээлэлд нэвтрэх боломжийг сайжруулах эерэг үр нөлөөтэй байж болохоор байна. Харин хувийн мэдээлэл, байгууллагын нууц, худалдааны нууцтай холбоотой тэнцвэрийг дараагийн шатны зохицуулалтад нарийвчлан тусгах шаардлагатай.

2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн ил тод байдал нь зөвхөн хүний эрх, олон нийтийн хяналтын асуудал биш юм. Энэ нь хөрөнгө оруулалтын итгэлцэл, төсвийн орлогын хяналт, татвар, төлбөрийн ил тод байдал, гэрээний тогтвортой байдал, зөвшөөрөл эзэмшигчийн тайлагналын ачаалал, авлигын эрсдэлийг бууруулахтай холбоотой эдийн засгийн ач холбогдолтой.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонговол эдийн засгийн хувьд дараах эерэг болон болзошгүй сөрөг үр нөлөөг тооцох шаардлагатай.

Хүснэгт 4. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Хөрөнгө оруулалтын орчин	Ил тод байдал нэмэгдэх нь хөрөнгө оруулалтын итгэлцэлд эерэг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Гэрээ, зөвшөөрөл, эцсийн өмчлөгч, төлбөр, байгаль орчны мэдээлэл илүү тодорхой болбол хөрөнгө оруулагчид эрсдэлийг бодитой үнэлэх боломж нэмэгдэнэ.
2. Төсвийн орлого, төлбөрийн хяналт	Татвар, төлбөр, хураамж, орон нутгийн орлогын мэдээлэл илүү хяналттай болох эсэх	Тийм	Байгалийн нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөр, орон нутгийн шилжүүлэг, сангийн орлого, зарцуулалтыг олон нийт болон төрийн байгууллага хянах боломж нэмэгдэнэ.
3. Авлига, ашиг сонирхлын зөрчил	Далд өмчлөл, гэрээний ил тод бус байдал, хандив дэмжлэгтэй холбоотой эрсдэл буурах эсэх	Тийм	Эцсийн өмчлөгч, гэрээ, хандив, дэмжлэг, орон нутгийн гэрээний мэдээллийг ил тод болгох зохицуулалт шаардлагатай эсэхийг судлах нь авлигын эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.
4. Захиргааны зардал	Хуулийн этгээдэд нэмэлт тайлагналын ачаалал үүсэх эсэх	Тодорхой хэмжээнд	Шинэ зохицуулалт бий болговол мэдээлэл нийлүүлэх үүрэг тодорхой хэмжээнд нэмэгдэж болно. Гэхдээ нэг цонхны зарчим, давхар шаардахгүй байх зарчмыг хэрэгжүүлбэл одоогийн давхардсан тайлагнал буурах боломжтой.
5. Төрийн байгууллагын зардал	Шинэ бүтэц, орон тоо, санхүүжилт шаардах эсэх	Тодорхой хэмжээнд	Одоогийн мэдээллийн сан, ОУИТБС-ын туршлага, төрийн байгууллагын одоо байгаа бүтэц дээр тулгуурлах боломжтой боловч зохион байгуулалт, цахим системийн уялдаа, орон нутгийн оролцоонд нэмэлт зардал гарах эсэхийг тооцох шаардлагатай.
6. Жижиг, дунд аж ахуйн нэгж	Жижиг зөвшөөрөл эзэмшигчид хэт ачаалал үүсэх эсэх	Болзошгүй	Мэдээлэл нийлүүлэх шаардлагыг нөөц ашиглалтын төрөл, хэмжээ, эрсдэлийн түвшин, үйл ажиллагааны цар хүрээтэй уялдуулж ялгамжтай

			тогтоох шаардлага гарч болно.
7. Мэдээллийн чанар	Нэгдсэн стандарт бий болсноор мэдээллийн чанар сайжрах эсэх	Тийм	Мэдээллийг нэг ангилал, нэг код, нэг стандарт, нэг хугацааны хүрээнд авах боломж бүрдвэл эдийн засгийн дүн шинжилгээ, бодлого боловсруулах чанар сайжирна.

Эдийн засгийн талаас авч үзвэл хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хөрөнгө оруулалтын орчин, төсвийн хяналт, авлигын эрсдэлийг бууруулах, мэдээллийн чанарыг сайжруулах эерэг үр нөлөөтэй байж болохоор байна. Гэхдээ хэрэгжилтийн зардал, мэдээлэл нийлүүлэгчийн ачаалал, цахим системийн хөгжүүлэлт, жижиг аж ахуйн нэгжид үзүүлэх нөлөөг нарийвчлан тооцох шаардлагатай.

3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Байгалийн нөөц ашиглалт нь орон нутгийн иргэд, малчид, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, судлаачид, төрийн болон орон нутгийн байгууллагын хоорондын итгэлцэл, мэдээлэл солилцоо, маргаан, оролцоотой шууд холбоотой.

Мэдээлэл хаалттай, салангид, ойлгомжгүй байх нь орон нутгийн түвшинд үл итгэлцэл, маргаан, буруу ойлголт, эсэргүүцэл, авлигын хардлага үүсгэх эрсдэлтэй. Харин мэдээлэл нээлттэй, ойлгомжтой, баталгаатай болбол иргэдийн оролцоо, хяналт, бодит хэлэлцүүлэг сайжрах боломжтой.

Хүснэгт 5. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Олон нийтийн хяналт	Иргэд бодит мэдээлэлд суурилан хяналт тавих боломж нэмэгдэх эсэх	Тийм	Зөвшөөрөл, гэрээ, төлбөр, байгаль орчны мэдээлэл, нөхөн сэргээлт, хандив дэмжлэгийн мэдээлэл илүү нээлттэй болбол олон нийтийн хяналт бодитой болно.
2. Орон нутгийн оролцоо	Нутгийн иргэдийн мэдээлэл авах, хэлэлцүүлэгт оролцох боломж нэмэгдэх эсэх	Тийм	Тухайн нутагт олгогдсон зөвшөөрөл, байгуулсан гэрээ, төвлөрсөн төлбөр, нөхөн сэргээлтийн мэдээлэл ойлгомжтой байвал орон нутгийн оролцоо сайжирна.
3. Нийгмийн итгэлцэл	Төр, компани, иргэдийн хоорондын итгэлцэлд нөлөөлөх эсэх	Тийм	Мэдээллийн зөрүү, нууцлаг байдал, ойлгомжгүй тайлагнал багасвал үл итгэлцэл буурах боломжтой.
4. Иргэний нийгэм, хэвлэл	Баримтад суурилсан судалгаа, хяналтад дэмжлэг үзүүлэх эсэх	Тийм	Нээлттэй, харьцуулах боломжтой мэдээлэл нь хараат бус судалгаа, эрэн сурвалжилга, бодлогын санал

мэдээлэл			боловсруулахад дэмжлэг болно.
5. Нөлөөлөлд өртсөн бүлэг	Нөлөөлөлд өртсөн иргэдийн эрх ашигт эерэг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Байгаль орчны нөлөөлөл, ус ашиглалт, нөхөн сэргээлт, орон нутгийн гэрээний мэдээлэл илүү тодорхой болбол нөлөөлөлд өртсөн иргэд эрхээ хамгаалах боломж нэмэгдэнэ.
6. Нийгмийн сөрөг нөлөө	Ил тод байдлын зохицуулалт шууд сөрөг нөлөө үүсгэх эсэх	Үгүй	Зохицуулалтын үндсэн зорилго нь эрх хязгаарлах бус, нийтийн мэдээллийг илүү нээлттэй болгоход чиглэх боломжтой. Гэхдээ хувийн мэдээлэл, нууцын тэнцвэрийг хамгаалах шаардлагатай.

Нийгмийн талаас авч үзвэл хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь орон нутгийн иргэдийн мэдээлэл авах боломж, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн оролцоо, төр-иргэн-компанийн итгэлцлийг нэмэгдүүлэх эерэг үр нөлөөтэй байж болохоор байна.

4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын зохицуулалт нь өөрөө олборлолт, ус ашиглалт, ой ашиглалт, ан амьтан, ургамлын ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх шууд зохицуулалт биш юм. Харин байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл, бохирдол, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, ус ашиглалт, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хяналт-шинжилгээний мэдээллийг ил тод болгох замаар байгаль орчны хариуцлага, олон нийтийн хяналтыг сайжруулах боломжтой.

Иймээс байгаль орчинд үзүүлэх үр нөлөө нь шууд бус боловч чухал байна.

Хүснэгт 6. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Байгаль орчны мэдээлэл	Байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлтийн мэдээлэл илүү нээлттэй болох эсэх	Тийм	Байгаль орчны үнэлгээ, менежментийн төлөвлөгөө, биелэлт, нөхөн сэргээлт, хаалтын мэдээллийг олон нийгэд ойлгомжтой хэлбэрээр хүргэх шаардлага байгаа эсэхийг судална.
2. Усны нөөц	Ус ашиглалт, ус бохирдуулсны төлбөр, дахин ашиглалтын мэдээлэлд хяналт нэмэгдэх эсэх	Тийм	Ус ашиглалт нь уул уурхай, үйлдвэр, хөдөө аж ахуй, орон нутгийн хэрэглээтэй давхцдаг тул ил тод мэдээлэл нь усны хяналт, төлөвлөлтөд чухал.
3. Ой, амьтан, ургамлын нөөц	Ой, амьтан, ургамлын ашиглалтын мэдээлэл ил тод болох хэрэгцээ	Тийм	Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг зөвхөн ашигт малтмалаар хязгаарлахгүй бол ой, амьтан, ургамлын

	байгаа эсэх		нөөц ашиглалт, төлбөр, нөхөн сэргээлтийн мэдээлэл мөн хамаарах боломжтой.
4. Нөхөн сэргээлт, уурхайн хаалт	Нөхөн сэргээлт, хаалтын мэдээлэлд олон нийтийн хяналт нэмэгдэх эсэх	Тийм	Нөхөн сэргээлтийн зардал, хийсэн ажил, баталгаажуулалт, хаалтын арга хэмжээний мэдээлэл ил тод болбол байгаль орчны хариуцлага нэмэгдэнэ.
5. Хяналт шалгалт	Мэдээлэлд суурилсан хяналт сайжрах эсэх	Тийм	Баталгаатай, нэгтгэсэн мэдээлэлтэй бол төрийн байгууллага болон олон нийт эрсдэлд суурилсан хяналт хийх боломж нэмэгдэнэ.
6. Байгаль орчинд шууд сөрөг нөлөө	Зохицуулалт өөрөө байгаль орчинд шууд сөрөг нөлөө үүсгэх эсэх	Үгүй	Зохицуулалтын зорилго нь байгалийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх бус, мэдээллийн ил тод байдал, хяналтыг сайжруулахад чиглэх боломжтой.

Байгаль орчны талаас авч үзвэл хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд шууд сөрөг нөлөө үүсгэхгүй байх магадлалтай. Харин ус ашиглалт, бохирдол, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, ой, амьтан, ургамлын нөөц ашиглалтын мэдээллийг илүү нээлттэй болгох замаар байгаль орчны хариуцлага, олон нийтийн хяналтыг сайжруулах эерэг үр нөлөөтэй байж болохоор байна.

5. Хууль тогтоомжийн нийцэлд үзүүлэх үр нөлөө

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын асуудлыг хууль тогтоомжийн түвшинд зохицуулах хувилбарыг сонговол Монгол Улсын Үндсэн хууль, нийтийн мэдээллийн ил тод байдал, шилэн данс, зөвшөөрөл, улсын бүртгэл, татвар, байгаль орчны болон салбарын бусад хуультай нийцүүлэх шаардлага үүснэ.

Энэ хувилбар нь Үндсэн хуулийн дараах зарчимтай уялдах боломжтой:

- газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх зарчим;
- иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх;
- иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрх;
- төрийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх зарчим;
- байгалийн баялгийн үр өгөөжийг шударга, тэгш хүртээх бодлогын суурь зарчим.

Мөн одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль нь мэдээллийн ил тод байдлын ерөнхий хүрээг тогтоож байгаа тул байгалийн нөөц ашиглалтын тусгай мэдээлэлтэй холбоотой зохицуулалт хийх шаардлага байгаа эсэхийг уг хуультай давхардуулахгүй, харин уялдуулах байдлаар судлах нь зүйтэй.

Хүснэгт 7. Хууль тогтоомжийн нийцэлд үзүүлэх үр нөлөө

Шалгах асуудал	Урьдчилсан	Тайлбар
----------------	------------	---------

	үнэлгээ	
Үндсэн хуультай нийцэх эсэх	Нийцнэ	Байгалийн баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх зарчимтай уялдах боломжтой.
Иргэний мэдээлэл авах эрхтэй нийцэх эсэх	Нийцнэ	Нийтийн ач холбогдол бүхий мэдээллийг илүү нээлттэй болгох зорилготой тул мэдээлэл авах эрхийг дэмжих боломжтой.
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай давхцах эсэх	Давхцах эрсдэл бий, уялдуулах шаардлагатай	Ерөнхий мэдээллийн хуулийг давтах бус, байгалийн нөөц ашиглалтын тусгай мэдээллийн хүрээ, тайлан, зөрүү, мэдээлэл нийлүүлэгчийн үүргийг нарийвчлах хэрэгцээ байгаа эсэхийг судална.
Шилэн дансны тухай хуультай уялдах эсэх	Уялдуулах шаардлагатай	Төсөв, төлбөр, орлого, зарлагын мэдээлэл Шилэн дансны мэдээлэлтэй холбогдох тул давхардал үүсгэхгүй байх шаардлагатай.
Зөвшөөрлийн тухай хуультай уялдах эсэх	Уялдуулах шаардлагатай	Байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, бүртгэлийн мэдээлэлтэй холбоотой асуудлыг Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэх шаардлагатай.
Байгаль орчны хууль тогтоомжтой уялдах эсэх	Уялдуулах шаардлагатай	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт, ус ашиглалт, бохирдлын мэдээлэл одоо байгаа салбарын зохицуулалттай холбогдоно.
Улсын бүртгэл, эцсийн өмчлөгчийн мэдээлэлтэй уялдах эсэх	Уялдуулах шаардлагатай	Эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч, хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэл, татвар, мөнгө угаахтай тэмцэх зохицуулалттай нийцүүлэх шаардлагатай.
Хувийн мэдээлэл хамгаалах зохицуулалттай уялдах эсэх	Нарийвчлан судлах шаардлагатай	Эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч, улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой мэдээллийг ил тод болгохдоо хувийн мэдээлэл хамгаалах зарчмыг зөрчихгүй байх шаардлагатай.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг урьдчилан тандан судлахад дараах нөхцөл байдал харагдаж байна.

Нэгдүгээрт, хүний эрхийн хувьд уг хувилбар нь иргэний мэдэх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, олон нийтийн хяналт тавих боломжийг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй байж болохоор байна. Гэхдээ хувийн мэдээлэл, байгууллагын нууц, худалдааны нууцын тэнцвэрийг нарийвчлан зохицуулах шаардлагатай.

Хоёрдугаарт, эдийн засгийн хувьд хөрөнгө оруулалтын итгэлцэл, төсвийн орлого, төлбөрийн хяналт, авлигаас урьдчилан сэргийлэх, тайлагналын давхардлыг бууруулах боломжтой. Гэхдээ хэрэгжилтийн зардал, цахим системийн уялдаа, мэдээлэл нийлүүлэгчийн ачааллыг нарийвчлан тооцох шаардлагатай.

Гуравдугаарт, нийгмийн хувьд орон нутгийн иргэдийн мэдээлэл авах боломж, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн оролцоо, төр-иргэн-компанийн итгэлцлийг нэмэгдүүлэх боломжтой.

Дөрөвдүгээрт, байгаль орчны хувьд шууд сөрөг нөлөө үүсгэхгүй байх магадлалтай бөгөөд ус ашиглалт, бохирдол, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, ой, амьтан, ургамлын нөөц ашиглалтын мэдээллийг ил тод болгох замаар байгаль орчны хариуцлага, хяналтыг сайжруулах боломжтой.

Тавдугаарт, хууль тогтоомжийн нийцлийн хувьд уг хувилбар нь Үндсэн хуулийн байгалийн баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх зарчим, иргэний мэдээлэл авах эрхтэй уялдах боломжтой. Харин Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, байгаль орчны болон улсын бүртгэлийн хууль тогтоомжтой давхардал үүсгэхгүйгээр уялдуулах шаардлагатай.

Иймээс энэ шатны үнэлгээгээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчны хувьд эерэг үр нөлөөтэй байж болох боловч хэрэгжилтийн зардал, мэдээллийн нууц, хувийн мэдээлэл, мэдээлэл нийлүүлэгчийн ачаалал, байгууллага хоорондын уялдааг дараагийн шатанд нарийвчлан тооцох шаардлагатай гэж үзэж байна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Өмнөх бүлгүүдэд байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах боломжит хувилбаруудыг авч үзэж, тэдгээрийн хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчин, хууль тогтоомжийн нийцэлд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тандан судлав.

Энэ шатны үнэлгээ нь хуулийн төсөл аль хэдийн боловсруулагдсан, эсхүл тодорхой зохицуулалт эцэслэн сонгогдсон гэсэн утгатай биш юм. Харин байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын асуудлыг шийдвэрлэхэд ямар зохицуулалтын хувилбар илүү тохиромжтой байж болохыг харьцуулан тогтоох зорилготой.

Судалгааны хүрээнд дараах хоёр хувилбарыг голчлон харьцуулан авч үзэв. Үүнд:

1. Хувилбар 1. Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлага байгаа эсэхийг судлах;
2. Хувилбар 2. Одоогийн хууль тогтоомжийн хүрээнд захиргааны шийдвэр, журам, хэм хэмжээний актаар зохицуулах боломжийг судлах.

Эдгээр хувилбарыг зорилгод хүрэх байдал, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, зардал-үр өгөөжийн харьцаа, хууль тогтоомжийн нийцэл, эрх ашиг нь хөндөгдөх этгээдийн хүрээ зэрэг шалгуураар дараах байдлаар харьцууллаа.

Хүснэгт. Зохицуулалтын хувилбаруудын харьцуулсан дүгнэлт

Шалгуур үзүүлэлт	Хувилбар 1. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлага байгаа эсэхийг судлах	Хувилбар 2. Захиргааны шийдвэр, журам, хэм хэмжээний актаар зохицуулах
Зорилгод хүрэх байдал	Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг нэгтгэх, мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, тайлангийн зөрүү, мэдээллийн нууцын ялгаа, гэрээний ил тод байдал, олон талт хяналт, салбарын хууль тогтоомжийн уялдааг нэг зарчимд оруулах боломжтой эсэхийг судлах давуу талтай.	Одоо байгаа хууль, журам, мэдээллийн сангийн хүрээнд зарим техникийн болон зохион байгуулалтын асуудлыг сайжруулах боломжтой. Гэвч олон салбар, олон байгууллага, олон төрлийн мэдээллийг нэг мөр уялдуулахад хязгаарлагдмал.
Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	Иргэний мэдэх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, орон нутгийн иргэдийн мэдээлэл авах боломж, олон нийтийн хяналтыг сайжруулах эрх зүйн үндэс бий болгох боломжтой. Гэхдээ хувийн мэдээлэл, байгууллагын нууц, худалдааны нууцын тэнцвэрийг нарийвчлан судлах шаардлагатай.	Мэдээллийн хүртээмжийг тодорхой хэмжээнд сайжруулж болох боловч иргэний мэдээлэл авах эрх, нийтийн ашиг сонирхлын мэдээллийн ил тод байдлыг бүх салбарт нэг мөр баталгаажуулах боломж хязгаарлагдмал.
Нийгэмд үзүүлэх үр	Орон нутгийн иргэд, иргэний нийгэм, судлаачид, хэвлэл мэдээлэл бодит	Зарим мэдээллийн хүртээмж сайжрах боловч орон нутгийн

нөлөө	мэдээлэлд тулгуурлан хяналт тавих, хэлэлцүүлэг өрнүүлэх боломж нэмэгдэх магадлалтай. Төр, компани, иргэдийн хоорондын итгэлцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж болно.	оролцоо, олон талт хяналт, тайлангийн зөрүүг олон нийтэд тайлбарлах тогтолцоо бүрэн бүрдэхгүй байх эрсдэлтэй.
Эдийн засаг, хөрөнгө оруулалт	Гэрээ, зөвшөөрөл, төлбөр, татвар, эцсийн өмчлөгч, байгаль орчны хариуцлагын мэдээлэл илүү тодорхой болсноор хөрөнгө оруулалтын итгэлцэл, эрсдэлийн үнэлгээ, төсвийн орлогын хяналт сайжрах боломжтой. Мөн давхардсан тайлагналыг бууруулах боломжийг судлах давуу талтай.	Шууд зардал бага байж болох боловч мэдээллийн чанар, уялдаа, хөрөнгө оруулалтын итгэлцэл, авлигын эрсдэлийг бууруулах үр нөлөө хязгаарлагдмал байж болзошгүй.
Зардал, үр өгөөжийн харьцаа	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар хэрэгжвэл цахим системийн уялдаа, байгууллагын чадавх, сургалт, мэдээлэл нийлүүлэгчийн үүрэгтэй холбоотой тодорхой зардал үүсэж болзошгүй. Гэвч олон нийтийн хяналт, мэдээллийн чанар, авлигын эрсдэлийг бууруулах, тайлагналын давхардлыг багасгах урт хугацааны үр өгөөжтэй байж болох тул нарийвчилсан зардлын тооцоо хийх шаардлагатай.	Богино хугацаанд шууд зардал бага байж болно. Гэвч суурь асуудал хэвээр үлдвэл мэдээллийн салангид байдал, тайлагналын давхардал, итгэлцлийн сулрал, хяналтын зардал урт хугацаанд үргэлжлэх магадлалтай.
Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Ус ашиглалт, бохирдол, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, ой, амьтан, ургамлын нөөц ашиглалтын мэдээллийг илүү нээлттэй болгох боломжтой. Энэ нь байгаль орчны хариуцлага, олон нийтийн хяналтыг сайжруулах зэрэг үр нөлөөтэй байж болно.	Байгаль орчны мэдээллийг зарим хэмжээнд ил тод болгож болох боловч олон эх сурвалжтай мэдээллийг нэгтгэх, баталгаажуулах, хяналтад ашиглах тогтолцоо бүрэн бүрдэхгүй байх эрсдэлтэй.
Хууль тогтоомжийн нийцэл	Үндсэн хуулийн байгалийн баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх зарчим, иргэний мэдээлэл авах эрх, нийтийн мэдээллийн ил тод байдлын бодлоготой уягдах боломжтой. Гэхдээ	Одоогийн хууль тогтоомжид тулгуурлах тул богино хугацаанд хэрэгжүүлэхэд хялбар байж болно. Гэвч хуульд тусгайлан зохицуулаагүй харилцааг журам,

	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, улсын бүртгэл, татвар, байгаль орчны болон салбарын хуультай давхардал үүсгэхгүйгээр уялдуулах шаардлагатай.	захиргааны шийдвэрээр бүрэн нөхөх боломжгүй.
Эрх ашиг нь хөндөгдөх этгээд	Иргэд, орон нутгийн иргэд, төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгэм, хөрөнгө оруулагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд зэрэг олон талын эрх, үүрэг, мэдээллийн горимыг тодорхой болгох боломжтой.	Оролцогч талуудын эрх, үүрэг, мэдээлэл нийлүүлэх хариуцлага, мэдээлэл ашиглах эрхийг бүх салбарт нэг мөр тодорхой болгох боломж хязгаарлагдмал.

Харьцуулсан дүгнэлт

Дээрх харьцуулалтаас үзэхэд Хувилбар 2 буюу одоогийн хууль тогтоомжийн хүрээнд захиргааны шийдвэр, журам, хэм хэмжээний актаар зохицуулах арга нь богино хугацаанд тодорхой зохион байгуулалтын болон техникийн асуудлыг сайжруулах боломжтой байна. Тухайлбал, одоо байгаа мэдээллийн сангуудын холбоосыг сайжруулах, мэдээлэл нийтлэх журам, маягтыг шинэчлэх, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог захиргааны түвшинд нэмэгдүүлэх, сургалт, зөвлөмж гаргах зэрэг арга хэмжээг авч болно.

Гэвч энэ хувилбар нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн салангид байдал, мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, мэдээллийн нууцын ялгаа, гэрээ болон эцсийн өмчлөгчийн ил тод байдал, тайлангийн зөрүү, олон талт хяналт, орон нутгийн оролцоо, салбарын хуулиудын уялдааг бүрэн шийдвэрлэхэд хангалтгүй байх эрсдэлтэй байна. Захиргааны шийдвэр, журам нь зөвхөн тухайн хуульд олгосон эрх хэмжээний хүрээнд үйлчилдэг тул олон салбарыг хамарсан, нийтийн эрх ашигт хамаарах мэдээллийн цогц тогтолцоог дангаар бүрдүүлэх боломж хязгаарлагдмал байна.

Харин Хувилбар 1 буюу хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлага байгаа эсэхийг судлах хувилбар нь асуудлыг илүү өргөн хүрээнд авч үзэх боломжтой байна. Энэ хувилбарын хүрээнд байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг нэгтгэх, мэдээлэл нийлүүлэгчийн үүрэг, мэдээллийн нууцын ялгаа, гэрээний ил тод байдал, тайлангийн зөрүү, олон талт хяналт, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, холбогдох салбарын хуулиудын уялдааг нэг зарчимд оруулах шаардлага байгаа эсэхийг нарийвчлан судлах боломжтой.

Иймээс энэ шатны тандан судалгаагаар байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын асуудлыг хууль тогтоомжийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх шаардлага байгаа эсэхийг цаашид илүү нарийвчлан судлах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь хууль тогтоомжийн төсөл заавал боловсруулна гэсэн эцсийн шийдвэр бус, харин өмнөх бүлгүүдэд тодорхойлсон асуудлын мөн чанар, цар хүрээ, эрх ашиг нь хөндөгдөх этгээд, зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөнд

үндэслэсэн урьдчилсан дүгнэлт юм.

Гарч болох эерэг үр дүн

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг цаашид сонгон судлах тохиолдолд дараах эерэг үр дүн гарах боломжтой байна. Үүнд:

1. байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл олон байгууллага, олон системд салангид байх нөхцөл буурах;
2. иргэд, орон нутгийн иргэд мэдээллийг нэг эх сурвалжаас, ойлгомжтой хэлбэрээр авах боломж нэмэгдэх;
3. зөвшөөрөл, гэрээ, төлбөр, татвар, хураамж, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, эцсийн өмчлөгчийн мэдээллийн уялдаа сайжрах;
4. тайлангийн зөрүүг тодруулах, тайлбарлах, засварлуулах механизм бий болгох боломж бүрдэх;
5. төрийн байгууллага өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс дахин шаардахгүй байх зарчмыг хэрэгжүүлэх боломж нэмэгдэх;
6. орон нутгийн иргэд, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, судлаачдын хяналт, оролцоо сайжрах;
7. авлига, ашиг сонирхлын зөрчил, далд өмчлөл, гэрээний ил тод бус байдлын эрсдэл буурах боломжтой;
8. хөрөнгө оруулалтын орчин, ESG болон сайн засаглалын шаардлагад нийцэх байдал сайжрах боломжтой.

Гарч болох эрсдэл, анхаарах асуудал

Мөн хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгон судлах тохиолдолд дараах эрсдэл, анхаарах асуудлыг нарийвчлан тооцох шаардлагатай. Үүнд:

1. одоо байгаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын хуулиудтай давхардал үүсгэхгүй байх;
2. мэдээлэл нийлүүлэгчид, ялангуяа жижиг, дунд зөвшөөрөл эзэмшигчид хэт тайлагналын ачаалал үүсгэхгүй байх;
3. хувийн мэдээлэл, байгууллагын нууц, худалдааны нууц, нийтийн ашиг сонирхлын мэдээллийн ялгааг тодорхой болгох;
4. цахим системүүдийг шинээр давхар үүсгэх бус, одоо байгаа мэдээллийн сан, нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй уялдуулах;
5. хэрэгжилтийн зардал, хүний нөөц, техникийн чадавх, орон нутгийн байгууллагын оролцоог бодитой тооцох;
6. мэдээллийг зөвхөн нийтлэх бус, олон нийт ойлгох, хайх, татаж авах, харьцуулах боломжтой хэлбэрээр нийтлэх;
7. олон талт хяналтын бүтэц бий болгох тохиолдолд түүний эрх хэмжээ, санхүүжилт, хариуцлагыг тодорхой болгох;
8. байгалийн нөөцийн төрөл бүрийн онцлогийг харгалзан ялгамжтай, эрсдэлд суурилсан

зохицуулалт хийх.

Судалгааны энэ шатанд хийсэн харьцуулалтаар захиргааны шийдвэр, журам, хэм хэмжээний актын хувилбар нь богино хугацааны зохион байгуулалтын зарим асуудлыг шийдвэрлэх боломжтой боловч байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн нэгдсэн, тогтвортой, олон талт хяналттай, эрх зүйн баталгаатай тогтолцоог бүрдүүлэхэд хангалтгүй байж болзошгүй байна.

Харин хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлага байгаа эсэхийг судлах хувилбар нь асуудлыг илүү цогцоор авч үзэх, олон хууль, олон байгууллага, олон мэдээллийн санг нэг зарчимд уялдуулах, иргэний мэдэх эрх, байгаль орчны хариуцлага, авлигаас урьдчилан сэргийлэх, орон нутгийн оролцоо, хөрөнгө оруулалтын итгэлцлийг сайжруулах боломжтой хувилбар байж болохоор байна.

Иймд дараагийн шатанд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг илүү нарийвчлан тодорхойлж, түүний хамрах хүрээ, зохицуулах харилцаа, хэрэгжилтийн зардал, холбогдох хууль тогтоомжтой уялдах байдлыг гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй гэж үзэж байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Энэ бүлгийн хүрээнд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын асуудлыг олон улсын стандарт, бусад улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан авч үзэв. Ингэхдээ зөвхөн олборлох үйлдвэрлэлийн төлбөр, орлогын тайлагналаар хязгаарлахгүйгээр гэрээ, зөвшөөрөл, эцсийн өмчлөгч, байгаль орчны мэдээлэл, орон нутгийн үр өгөөж, нээлттэй өгөгдөл, олон нийтийн хяналт зэрэг Монгол Улсад тулгамдаж буй асуудалтай шууд хамаарах чиглэлүүдийг сонгон судлав.

Олон улсын туршлагаас үзэхэд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын зохицуулалт нь улс бүрт өөр өөр хүрээтэй боловч дараах нийтлэг чиг хандлагатай байна. Үүнд:

- олборлох үйлдвэрлэлийн татвар, төлбөр, роялти, ногдол ашиг, урамшуулал, төрд төлсөн бусад төлбөрийг нийтлэх;
- гэрээ, зөвшөөрөл, лицензийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох;
- эцсийн өмчлөгч, хяналт хэрэгжүүлэгч этгээд, улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой мэдээллийг тодорхой болгох;
- төрийн өмчит аж ахуйн нэгжийн ногдол ашиг, төрд ногдох үр өгөөж, зээл, баталгаа, төсвийн шинжтэй зарцуулалтыг ил тод болгох;
- байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, ус ашиглалт, хаалт, орон нутгийн үр өгөөж, хандив дэмжлэгийн мэдээллийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр нийтлэх;
- мэдээллийг цахим, нээлттэй, машин уншигдах, харьцуулах боломжтой хэлбэрээр нийтлэх.

6.1. Олон улсын стандарт, санаачилга

Стандарт,	Гол агуулга	Монгол	Улсад	хэрэглэх
-----------	-------------	--------	-------	----------

санаачилга		боломж
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга /EITI/	EITI стандарт нь газрын тос, хий, уул уурхайн салбарын ил тод байдал, хариуцлагын олон улсын жишиг стандарт юм. 2023 оны EITI стандарт нь лиценз, гэрээ, эцсийн өмчлөгч, төрийн өмчит компани, орлого, төлбөр, орон нутгийн шилжүүлэг, байгаль орчны мэдээлэл, олон талт оролцоог хамардаг.	Монгол Улс EITI-г олон жил хэрэгжүүлсэн туршлагатай. Гэвч уг туршлагыг зөвхөн олборлох салбараар хязгаарлахгүй, байгалийн нөөц ашиглалтын өргөн хүрээнд хэрэглэх боломж, хэрэгцээ байгаа эсэхийг судлах нь зүйтэй.
EITI гэрээний ил тод байдлын шаардлага	EITI стандартын дагуу 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш олгосон буюу өөрчилсөн газрын тос, хий, ашигт малтмалын гэрээ, лицензийг нийтлэх шаардлага тавигддаг.	Монгол Улсад гэрээний ил тод байдлыг зөвхөн нийтлэхээс гадна гэрээний төрөл, талууд, хэрэгжилт, нэмэлт өөрчлөлт, орон нутгийн гэрээтэй холбож харах хэрэгцээ байна.
EITI эцсийн өмчлөгчийн шаардлага	EITI хэрэгжүүлэгч орнууд 2020 оноос олборлох салбарын компаниудын эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох шаардлагатай болсон.	Зөвшөөрөл эзэмшигч, гэрээ байгуулагч, байгалийн нөөц ашиглагч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, улс төрд нөлөө бүхий этгээдийн мэдээллийг бүртгэл болон ил тод байдлын системтэй холбох шаардлага байгаа эсэхийг судлах нь зүйтэй.
Aarhus Convention	Орчны мэдээлэл авах, байгаль орчны шийдвэр гаргалтад олон нийт оролцох, байгаль орчны асуудлаар шүүхэд хандах эрхийг баталгаажуулсан олон улсын гол конвенц юм. Европын Комиссын тайлбарласнаар энэ конвенц байгаль орчны мэдээлэл, бодлого, арга хэмжээ, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой мэдээлэлд хандах эрхийг хамардаг.	Монгол Улсад байгаль орчны нөлөөлөл, ус ашиглалт, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, бохирдол, хяналт шинжилгээний мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, цаг тухайд нь хүргэх зарчмыг боловсруулахад сургамжтай.
Open Data Charter	Нээлттэй өгөгдлийн олон улсын зарчмууд нь “open by default”, цаг тухайтай, иж бүрэн, хүртээмжтэй,	Нэгдсэн портал байгуулах эсэхийг судлахдаа зөвхөн PDF тайлан нийтлэх бус, машин

	ашиглахад хялбар, харьцуулах боломжтой, харилцан ажиллах чадвартай байх зарчмыг тогтоодог.	уншигдах, татаж авах, харьцуулах, дахин ашиглах боломжтой өгөгдлийн стандарт шаардлагатай эсэхийг авч үзэх хэрэгтэй.
Beneficial Ownership Data Standard /BODS/	Open Ownership-ийн BODS нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулах, хадгалах, солилцох, нийтлэхэд ашиглах нээлттэй өгөгдлийн стандарт юм.	Эцсийн өмчлөгчийн мэдээллийг зөвхөн нэрсийн жагсаалт байдлаар бус, өмчлөл, хяналтын хэлхээ, хувь хэмжээ, өөрчлөлтийн түүхтэй нь холбож бүртгэх шаардлага байгаа эсэхийг судлахад чухал.

6.2. Бусад улсын эрх зүйн зохицуулалт

6.2.1. Канад Улс

Канад Улс Extractive Sector Transparency Measures Act /ESTMA/-аар олборлох салбарын компаниудын төрд төлсөн төлбөрийн ил тод байдлыг зохицуулдаг. Уг хуулийн зорилго нь олборлох салбарт авлигатай тэмцэх олон улсын үүргийг хэрэгжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, төрд төлсөн төлбөрийг тайлагнах үүрэг бий болгоход оршдог.

Канадын зохицуулалтын онцлог нь:

- тайлагнах этгээдийн босго, хамрах хүрээг тодорхой тогтоосон;
- татвар, роялти, хураамж, бүтээгдэхүүнээр төлсөн төлбөр, ногдол ашиг, урамшуулал, дэд бүтцийн төлбөр зэрэг төрд хийсэн төлбөрийг ангилж тайлагнадаг;
- төлбөрийг засгийн газрын түвшин болон төсөл тус бүрээр тайлагнах боломжийг бүрдүүлдэг;
- тайланг цахим хэлбэрээр нийтэлдэг.

Монгол Улсад нэвтрүүлж болох туршлага:

Канадын туршлага нь байгалийн нөөц ашиглагчийн төрд төлсөн төлбөрийг зөвхөн нийт дүнгээр бус, төлбөрийн төрөл, төлбөр хүлээн авагч, төсөл, зөвшөөрөл, орон нутгийн түвшнээр харьцуулах боломжтой болгох хэрэгцээ байгааг харуулж байна. Монголын хувьд зөвхөн уул уурхайн компаниудаар хязгаарлах эсэх, эсхүл байгалийн нөөц ашиглалтын бусад төрлийн төлбөр, хураамж, орон нутгийн орлого, хандив дэмжлэгийг хамруулах эсэхийг нарийвчлан судлах шаардлагатай.

6.2.2. Европын Холбоо

Европын Холбооны Нягтлан бодох бүртгэлийн удирдамжид олборлох үйлдвэрлэл болон анхдагч ойн салбарт үйл ажиллагаа явуулдаг томоохон компаниуд засгийн газарт төлсөн материаллаг төлбөрөө улс болон төсөл тус бүрээр тайлагнах зохицуулалт тусгагдсан. Европын Комиссын тайлбарласнаар уг зохицуулалт нь олборлох болон ой мод бэлтгэлийн томоохон компаниудад засгийн газарт төлсөн төлбөрөө тайлагнах үүрэг бий болгосон.

Энэ зохицуулалтын онцлог нь Монгол Улсад чухал ач холбогдолтой. Учир нь ЕХ олборлох үйлдвэрлэлээс гадна анхдагч ойн салбарыг мөн төлбөрийн ил тод байдлын хүрээнд хамруулсан байна. Энэ нь байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг зөвхөн ашигт малтмалаар хязгаарлахгүй байх хандлагатай нийцэж байна.

Монгол Улсад нэвтрүүлж болох туршлага:

Европын Холбооны туршлагаас байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн ил тод байдлыг зөвхөн уул уурхай, газрын тосоор бус, ой зэрэг бусад нөөц ашиглалтын төрлүүдэд хамааруулах боломжийг судлах нь зүйтэй. Мөн төлбөрийг “компани-төлбөрийн төрөл-төсөл-төрийн байгууллага” гэсэн ангиллаар нээлттэй болгох шаардлага байгаа эсэхийг авч үзэх хэрэгтэй.

6.2.3. Эстони Улс

Эстони Улс нь байгаль орчны мэдээлэл, нээлттэй өгөгдөл, цахим төрийн шийдлээр туршлагатай улс юм. Эстонийн Байгаль орчны бүртгэлийн тухай хуульд environmental register буюу байгаль орчны бүртгэлийн чиг үүрэг нь байгалийн нөөц, байгалийн өв, байгаль орчны төлөв байдал, байгаль орчны хүчин зүйлтэй холбоотой мэдээллийг хадгалах, боловсруулах, байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл болон орчны зөвшөөрөл олгоход шаардлагатай мэдээллээр хангахад оршино гэж заасан байна.

Мөн Эстонийн Байгаль орчны порталын мэдээллээр EELIS буюу Estonian Nature Information System нь тусгай хамгаалалттай газар, усны биет, байгалийн үнэ цэнэ, холбогдох эрх зүйн хязгаарлалтын талаар мэдээлэл цуглуулж, удирдаж, олон нийтэд мэдээлэл өгдөг үндэсний мэдээллийн сан юм. Эстонийн нээлттэй өгөгдлийн портал нь нээлттэй өгөгдлийг ашиглах, дүрслэх, өгөгдлийн тайлбар, бусад мэдээллийн удирдлагын системтэй холбох чиглэлээр хөгжиж байна.

Монгол Улсад нэвтрүүлж болох туршлага:

Эстонийн туршлага нь байгалийн нөөцийн ил тод байдлыг зөвхөн олборлох салбарын төлбөр, орлогоор хязгаарлахгүй, байгалийн нөөц, орчны мэдээлэл, зөвшөөрөл, хамгаалалтын бүс, хязгаарлалт, ус, ой, тусгай хамгаалалттай газар зэрэг мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн дэд бүтэц шаардлагатай байж болохыг харуулж байна. Монгол Улсад байгаль орчин, зөвшөөрөл, кадастр, гэрээ, төлбөрийн мэдээллийг нэг цонхоор харах хэрэгцээ байгаа эсэхийг Эстонийн загвартай харьцуулан судлах боломжтой.

6.2.4. Казахстан Улс

Казахстан Улс Монголтой адил пост-социалист эрх зүйн уламжлалтай, эрдэс баялаг, газрын тос, ураны салбарын эдийн засгийн өндөр ач холбогдолтой улс юм. Казахстаны Subsoil and Subsoil Use Code нь газрын хэвлий ашиглалтын эрх, төрийн удирдлага, зохицуулалтын дэглэмийг тогтоодог.

Казахстан EITI-г хэрэгжүүлдэг боловч 2025 оны EITI үнэлгээгээр 2019 оны EITI стандартын хэрэгжилтэд 56 оноо авч, “fairly low score” гэж үнэлэгдсэн байна. Уг үнэлгээнд ашиг сонирхлын эзэмшил, гэрээний ил тод байдал, олон талт оролцоо зэрэг чиглэлд цаашид сайжруулах шаардлага байгааг дурдсан.

Казахстаны туршлага нь зөвхөн “хуультай байх” хангалтгүй, хэрэгжилт, олон талт оролцоо, мэдээллийн систем, гэрээ, эцсийн өмчлөгчийн бодит ил тод байдал зэрэг нь давхар хангагдах шаардлагатайг харуулж байна.

Монгол Улсад нэвтрүүлж болох туршлага:

Казахстаны туршлага Монгол Улсад хоёр сургамж өгч байна. Нэгдүгээрт, газрын хэвлий, эрдэс баялгийн мэдээллийг хууль тогтоомжийн түвшинд зохицуулах нь чухал. Хоёрдугаарт, зөвхөн хууль, журамтай байх нь хангалтгүй бөгөөд олон талт оролцоо, тайлагналын чанар, мэдээллийн нээлттэй байдал, хэрэгжилтийн хяналт бодитоор ажиллах ёстой.

6.2.5. Нэгдсэн Вант Улс болон эцсийн өмчлөгчийн ил тод байдлын туршлага

Нэгдсэн Вант Улс нь компанийн эцсийн өмчлөгч буюу significant control бүхий этгээдийн мэдээллийг бүртгэх, олон нийтэд нээлттэй болгох чиглэлээр олон улсын түвшинд анхаарал татсан туршлагатай. Мөн Нэгдсэн Вант Улсын Засгийн газрын нээлттэй стандартын зөвлөмжид эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулах, ашиглах, солилцох, нийтлэхдээ Beneficial Ownership Data Standard /BODS/-ыг ашиглахыг зөвлөсөн байна.

Монгол Улсад нэвтрүүлж болох туршлага:

Байгалийн нөөц ашиглагч хуулийн этгээдийн өмчлөл, хяналтын мэдээлэл нь авлига, ашиг сонирхлын зөрчил, далд өмчлөл, улс төрд нөлөө бүхий этгээдийн оролцоог илрүүлэхэд чухал. Иймээс эцсийн өмчлөгчийн мэдээллийг зөвхөн нэг удаагийн мэдүүлэг бус, өөрчлөлтийн түүх, өмчлөл-хяналтын хэлхээ, хувь хэмжээ, төрийн өмчит этгээдийн оролцоотой нь холбож бүртгэх боломжийг судлах нь зүйтэй.

6.3. Монгол Улсын нөхцөлд илүү тохирох харьцуулалтын чиглэл

Дээрх олон улсын болон бусад улсын туршлагыг Монгол Улсад шууд хуулбарлан хэрэглэх боломжгүй. Харин Монгол Улсын байгалийн нөөц ашиглалтын бүтэц, олон хуульд тархсан мэдээллийн тогтолцоо, ОУИТБС-ын туршлага, байгаль орчны мэдээллийн сангууд, нийтийн мэдээллийн дэд бүтэц, орон нутгийн иргэдийн хяналт, уул уурхайн эдийн засгийн жинг харгалзан дараах чиглэлүүдийг илүү тохиромжтой гэж үзэж болно.

Чиглэл	Аль стандарт, улсын туршлагаас авах вэ	Монгол Улсад нийцүүлэх боломж
Төлбөр, орлого, төсвийн ил тод байдал	EITI, Канад ESTMA, ЕХ-ийн төлбөрийн тайлагнал	Татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, орон нутгийн шилжүүлэг, тусгай сангийн мэдээллийг нэг ангилал, нэг стандарттай болгох хэрэгцээ байгаа эсэхийг судална.
Гэрээ, зөвшөөрлийн ил тод байдал	EITI Requirement 2.4, Казахстаны газрын хэвлийн зохицуулалт	Гэрээ, зөвшөөрөл, лиценз, нэмэлт өөрчлөлт, орон нутгийн гэрээ, хэрэгжилтийн мэдээллийг нэгтгэх шаардлага байгаа эсэхийг судална.
Эцсийн өмчлөгчийн	EITI Requirement 2.5, Open Ownership BODS,	Эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч, улс төрд нөлөө бүхий этгээдийн мэдээллийг

мэдээлэл	UK open standard	зөвшөөрөл, гэрээ, төлбөрийн мэдээлэлтэй холбох хэрэгцээг судална.
Байгаль орчны мэдээлэл, олон нийтийн оролцоо	Aarhus Convention, Эстонийн Environmental Register ба EELIS	Байгаль орчны нөлөөлөл, ус ашиглалт, нөхөн сэргээлт, хаалт, хяналт-шинжилгээний мэдээллийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр нийтлэх хэрэгцээ байгаа эсэхийг судална.
Нээлттэй өгөгдөл, машин унших формат	Open Data Charter, Эстонийн open data portal	Мэдээллийг PDF хэлбэрээр нийтлэхээс гадна CSV, JSON, API, GIS зэрэг хэлбэрээр нийтлэх шаардлага байгаа эсэхийг судална.
Олон талт хяналт	EITI multi-stakeholder governance, Казахстаны сургамж	Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотой хяналт, зөвлөмж, тайлангийн зөрүүг шийдвэрлэх тогтолцоо хэрэгтэй эсэхийг судална.

6.4. Дүгнэлт

Олон улсын болон бусад улсын туршлагаас үзэхэд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдал нь зөвхөн уул уурхайн төлбөр, орлогын тайлангаар хязгаарлагдахгүй байна. Харин дараах таван том чиглэлд хөгжиж байна.

Нэгдүгээрт, төлбөр ба орлогын ил тод байдал. Канад, Европын Холбоо, EITI-ийн туршлагаас харахад төрд төлсөн төлбөрийг улс, төсөл, төлбөрийн төрөл, компани, төрийн байгууллагын түвшинд задалж нийтлэх нь авлигаас сэргийлэх, төсвийн хяналтыг сайжруулах үндсэн хэрэгсэл болж байна.

Хоёрдугаарт, гэрээ ба зөвшөөрлийн ил тод байдал. EITI стандарт нь 2021 оноос хойш олгосон буюу өөрчилсөн гэрээ, лицензийг ил тод болгох шаардлага тавьж байгаа нь Монгол Улсад гэрээний мэдээллийг илүү системтэй, ойлгомжтой, харьцуулах боломжтой болгох хэрэгцээ байгаа эсэхийг судлах үндэслэл болж байна.

Гуравдугаарт, эцсийн өмчлөгчийн ил тод байдал. EITI болон Open Ownership-ийн туршлагаас харахад эцсийн өмчлөгчийн мэдээллийг зөвхөн мэдүүлэх бус, өмчлөл, хяналтын хэлхээ, хувь хэмжээ, улс төрд нөлөө бүхий этгээдийн холбоотой нь нийтлэх нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд чухал байна.

Дөрөвдүгээрт, байгаль орчны мэдээллийн ил тод байдал. Aarhus Convention болон Эстонийн Environmental Register, EELIS-ийн туршлагаас харахад байгалийн нөөц ашиглалттай холбоотой орчны мэдээлэл, ус, ой, тусгай хамгаалалттай газар, нөхөн сэргээлт, хязгаарлалт, зөвшөөрлийн мэдээлэл нь олон нийтийн оролцоо, хяналтын үндэс болдог.

Тавдугаарт, нээлттэй өгөгдөл ба мэдээллийн архитектур. Open Data Charter болон Эстонийн нээлттэй өгөгдлийн туршлагаас харахад мэдээллийг нийтлэх нь хангалтгүй бөгөөд түүнийг машин унших, харьцуулах, татаж авах, дахин ашиглах боломжтой өгөгдөл болгох шаардлагатай байна.

Иймд Монгол Улсад байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын асуудлыг цаашид судлахдаа EITI-ийн олон талт тайлагналын стандарт, Канадын төлбөрийн тайлагнал, Европын Холбооны олборлох болон ойн салбарын төлбөрийн ил тод байдал, Эстонийн байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, Казахстаны газрын хэвлийн зохицуулалтын сургамж, Aarhus Convention-ийн орчны мэдээлэл авах эрх, Open Data Charter болон BODS-ийн өгөгдлийн стандартыг харгалзан үзэх нь зүйтэй байна.

Эдгээр туршлагыг Монгол Улсад шууд хуулбарлах бус, харин дараах асуултад хариулахад ашиглах нь зөв юм:

1. байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг зөвхөн олборлох салбараар хязгаарлахгүйгээр ус, ой, амьтан, ургамал, газар, газрын хэвлийтэй холбож авч үзэх шаардлага байгаа эсэх;
2. төлбөр, гэрээ, зөвшөөрөл, эцсийн өмчлөгч, байгаль орчин, нөхөн сэргээлт, орон нутгийн үр өгөөжийн мэдээллийг нэг цонхны цахим системээр харах хэрэгцээ байгаа эсэх;
3. мэдээллийг PDF тайлангаар бус, машин унших боломжтой, харьцуулахуйц өгөгдөл хэлбэрээр нийтлэх шаардлага байгаа эсэх;
4. мэдээллийн нууц, хувийн мэдээлэл, худалдааны нууц, нийтийн ашиг сонирхлын мэдээллийн ялгааг тусгайлан тодорхойлох хэрэгцээ байгаа эсэх;
5. төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотой олон талт хяналтын тогтолцоог илүү тогтвортой болгох шаардлага байгаа эсэх.

Ийм хэлбэрээр харьцуулбал олон улсын бүлэг нь ерөнхий “гадаадын туршлага” биш, харин Монгол Улсад байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын эрх зүйн хэрэгцээ байгаа эсэхийг нотлох нэг гол хэсэг болно.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Энэхүү урьдчилан тандан судалгааны хүрээнд байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт, мэдээллийн сангуудын уялдаа, олон нийтийн хяналт, гэрээ, төлбөр, эцсийн өмчлөгч, байгаль орчны мэдээлэл, олон улсын туршлага болон зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан авч үзэв.

Судалгааны дүнгээс үзэхэд байгалийн нөөц ашиглалттай холбоотой мэдээлэл Монгол Улсад огт байхгүй бус, харин олон хууль, олон байгууллага, олон мэдээллийн санд салангид байдлаар бүрдэж байна. Үүний улмаас иргэд, орон нутгийн иргэд, төрийн байгууллага, иргэний нийгэм, судлаачид, хөрөнгө оруулагчид байгалийн нөөц ашиглалтын талаарх мэдээллийг нэг эх сурвалжаас, ойлгомжтой, баталгаатай, харьцуулах боломжтой хэлбэрээр авах нөхцөл хангалтгүй байна.

Иймээс байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг ил тод, нэгдсэн, баталгаатай, олон нийтийн хяналттай болгох эрх зүйн зохицуулалт шаардлагатай гэж үзэж, дараах зөвлөмжийг гаргаж байна.

1. Анхдагч хууль боловсруулах шаардлагатай байна

Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн салангид байдал, тайлагналын давхардал, мэдээллийн нууцын тодорхойгүй байдал, гэрээ, эцсийн өмчлөгч, байгаль орчны мэдээллийн хүртээмжгүй байдал, олон талт хяналтын эрх зүйн баталгааны сул талыг зөвхөн захиргааны шийдвэр, журам, мэдээллийн сангийн зохион байгуулалтаар бүрэн шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байна.

Иймд Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай анхдагч хууль боловсруулах шаардлагатай гэж үзэв.

Уг хууль нь байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг зөвхөн тайлагналын асуудал гэж бус, харин иргэний мэдэх эрх, олон нийтийн хяналт, байгаль орчны хариуцлага, авлигаас урьдчилан сэргийлэх, орон нутгийн оролцоо, хөрөнгө оруулалтын итгэлцэлтэй холбоотой мэдээллийн засаглалын асуудал гэж авч үзэх нь зүйтэй.

2. Хуулийн үйлчлэх хүрээг байгалийн нөөцийн өргөн хүрээнд тогтоох шаардлагатай байна

Анхдагч хууль боловсруулах тохиолдолд түүний үйлчлэх хүрээг зөвхөн ашигт малтмал, газрын тос, олборлох үйлдвэрлэлийн мэдээллээр хязгаарлахгүй байх нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуульд газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх зарчмыг тогтоосон. Иймээс эрдэс баялаг нь байгалийн баялгийн нэг төрөл бөгөөд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг ус, ой, амьтан, байгалийн ургамал, газар, газрын хэвлий болон холбогдох бусад нөөцийн ашиглалттай уялдуулан авч үзэх шаардлагатай.

Гэхдээ хуулийн үйлчлэх хүрээг тогтоохдоо нөөцийн төрөл бүрийн онцлог, зөвшөөрлийн хэлбэр, ашиглалтын хэмжээ, байгаль орчны эрсдэл, тайлагналын ачааллыг харгалзан ялгамжтай, үе шаттай зохицуулалт хийх боломжийг судлах нь зүйтэй.

3. Мэдээллийг нэг цонхны зарчмаар нэгтгэх шаардлагатай байна

Судалгаагаар Монгол Улсад байгалийн нөөц ашиглалттай холбоотой олон мэдээллийн сан, цахим систем байгаа боловч тэдгээрийн хоорондын уялдаа хангалтгүй байна.

Иймд анхдагч хууль боловсруулахдаа байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг нэг цонхны зарчмаар хүлээн авах, бүртгэх, хадгалах, боловсруулах, шалгах, нийтлэх, солилцох эрх зүйн үндсийг тодорхойлох нь зүйтэй.

Энэ хүрээнд нэгдсэн порталын зохицуулалтыг зөвхөн шинэ цахим хуудас байгуулах асуудал гэж ойлгохгүй. Харин одоо байгаа мэдээллийн сангуудыг холбох, мэдээллийн ангилал, код, өгөгдлийн стандарт, мэдээлэл солилцооны горим, давхар мэдээлэл шаардахгүй байх зарчмыг хэрэгжүүлэх мэдээллийн архитектур гэж авч үзэх шаардлагатай.

4. Мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай байна

Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг ил тод болгохдоо хэн, ямар мэдээллийг, ямар хугацаанд, ямар хэлбэрээр, ямар баталгаатайгаар гаргах нь тодорхой байх шаардлагатай.

Иймээс төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, байгалийн нөөц ашиглагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, шаардлагатай тохиолдолд төрийн бус байгууллага зэрэг мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг хууль тогтоомжийн түвшинд тодорхойлох нь зүйтэй.

Энэ нь нэг талаас олон нийтэд үнэн зөв, бүрэн, цаг тухайтай мэдээлэл хүргэх, нөгөө талаас мэдээлэл нийлүүлэгчид давхардсан, тодорхойгүй, хэт ачаалалтай тайлагнал үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой.

5. Нийтийн ашиг сонирхлын мэдээллийн нууцын ялгааг тодорхой болгох шаардлагатай байна

Байгалийн нөөц ашиглалттай холбоотой зарим мэдээлэл нь хувийн хэвшлийн арилжааны үйл ажиллагаатай холбогдож болох боловч тодорхой мэдээлэл нь шууд нийтийн ашиг сонирхлын шинжтэй байна.

Тухайлбал, байгаль орчны нөлөөлөл, бохирдол, ус ашиглалт, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, төлбөр, татвар, хураамж, төрд төлсөн орлого, орон нутгийн гэрээ, хандив, дэмжлэг, эцсийн өмчлөгч, улс төрд нөлөө бүхий этгээдийн холбоотой мэдээллийг байгууллагын нууц, худалдааны нууц нэрээр үндэслэлгүй хаах эрсдэлийг бууруулах шаардлагатай.

Иймд анхдагч хууль боловсруулахдаа:

- ямар мэдээллийг нууцад хамааруулахгүй байх;
- ямар мэдээллийг хязгаарлагдмал хүрээнд нийтлэх;
- нууцлах шаардлагатай бол ямар шалгуур, хугацаа, тэмдэглэгээ хэрэглэх;
- нууцалсан ч тайлагнах үүргээс чөлөөлөгдөхгүй байх;
- нийтийн ашиг сонирхол ба хувийн мэдээлэл, худалдааны нууцын тэнцвэрийг хэрхэн хангах

зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулах нь зүйтэй.

6. Тайлан, зөрүү, баталгаажуулалтын механизмыг тусгах шаардлагатай байна

Байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл олон эх сурвалжаас бүрдэх тул төрийн байгууллага,

зөвшөөрөл эзэмшигч, бусад мэдээлэл нийлүүлэгчийн тайлан хооронд зөрүү гарах боломжтой.

Иймээс анхдагч хууль боловсруулахдаа Улсын нэгдсэн тайлан, төрөлжсөн тайлан, тайлангийн зөрүүг тодруулах, тайлбар авах, засварлуулах, олон нийтэд мэдээлэх, цаашид авах арга хэмжээний зөвлөмж гаргах механизмыг тусгах нь зүйтэй.

Мэдээллийг зөвхөн цуглуулах бус, түүний үнэн зөв, бүрэн, харьцуулах боломжтой байдлыг баталгаажуулах тогтолцоо бүрдэх шаардлагатай.

7. Олон талт хяналтын тогтолцоог хуульчлах нь зүйтэй байна

Монгол Улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх явцад төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотой олон талт зөвлөл, ажлын алба, орон нутгийн түвшний оролцооны тодорхой туршлага хуримтлуулсан байна.

Гэвч энэ туршлагыг тогтвортой, эрх хэмжээ нь тодорхой, санхүүжилт нь ойлгомжтой, тайлан мэдээлэлтэй ажиллах боломжтой институцийн тогтолцоо болгон хөгжүүлэх шаардлагатай.

Иймд анхдагч хууль боловсруулахдаа Үндэсний зөвлөл, Ажлын алба, салбар зөвлөл зэрэг олон талт оролцооны бүтцийг хууль тогтоомжийн түвшинд тодорхойлох нь зүйтэй. Гэхдээ эдгээр бүтцийн чиг үүрэг, бүрэлдэхүүн, санхүүжилт, хараат бус байдал, хуралдааны журам, тайлан, зөвлөмжийн хэрэгжилт, хариуцлагын механизмыг тодорхой болгох шаардлагатай.

8. Холбогдох хуулиудын уялдааг хангах шаардлагатай байна

Байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл нь нэг салбарын асуудал биш юм. Энэ нь ашигт малтмал, газрын тос, түгээмэл тархацтай ашигт малтмал, цөмийн энерги, ус, ой, амьтан, байгалийн ургамал, газар, газрын хэвлий, байгаль орчин, татвар, улсын бүртгэл, аудит, зөрчил, нийтийн мэдээлэл, шилэн данс зэрэг олон хуультай холбогдоно.

Иймд анхдагч хууль боловсруулахдаа холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээг хамтад нь судалж, уялдуулах шаардлагатай.

Ялангуяа дараах асуудлыг салбарын хуулиудтай нийцүүлэх нь зүйтэй:

- зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн мэдээлэл;
- гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлт;
- эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл;
- байгаль орчны нөлөөлөл, менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт, хаалт;
- ус, ой, амьтан, ургамлын нөөц ашиглалтын мэдээлэл;
- төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээлэл;
- хариуцлага, зөрчил, тайлагналын биелэлт.

9. Нэр томьёо, хамрах хүрээг энгийн, нэг мөр болгох шаардлагатай

Анхдагч хууль боловсруулахдаа нэр томьёог энгийн, ойлгомжтой, бусад хуультай зөрчилдөхгүй байдлаар тодорхойлох шаардлагатай.

Тухайлбал:

- байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл;
- мэдээлэл нийлүүлэгч;

- мэдээлэл хариуцагч;
- зөвшөөрөл эзэмшигч;
- байгалийн нөөц ашиглагч;
- тайлангийн зөрүү;
- эцсийн өмчлөгч;
- эцсийн эзэмшигч;
- улс төрд нөлөө бүхий этгээд;
- нийтийн ашиг сонирхлын мэдээлэл;
- нууцад хамаарахгүй мэдээлэл зэрэг нэр томъёог нэг мөр тодорхойлох нь зүйтэй.

Мөн “олборлох үйлдвэрлэл” болон “байгалийн нөөц ашиглалт” гэсэн ойлголтын ялгааг зөв тодорхойлох шаардлагатай. Олборлох үйлдвэрлэл нь байгалийн нөөц ашиглалтын нэг төрөл болохоос байгалийн баялгийн нийт хүрээг бүрэн орлох ойлголт биш юм.

10. Хэрэгжилтийн үе шат, зардал, чадавхыг урьдчилан төлөвлөх шаардлагатай

Анхдагч хууль боловсруулах нь дангаараа хангалтгүй. Хэрэгжилтийн үе шат, санхүүжилт, хүний нөөц, цахим систем, мэдээллийн стандарт, сургалт, гарын авлага, тайлангийн маягт, байгууллага хоорондын мэдээлэл солилцоо зэргийг хамтад нь төлөвлөх шаардлагатай.

Иймээс дараагийн шатанд:

- нэгдсэн порталын техникийн шийдэл;
- одоо байгаа мэдээллийн сангуудтай холбох боломж;
- өгөгдлийн стандарт;
- тайлангийн маягт, аргачлал;
- мэдээлэл нийлүүлэгчийн сургалт;
- төрийн байгууллагын мэдээлэл солилцоо;
- салбар зөвлөлийн санхүүжилт;
- орон нутгийн байгууллагын оролцоо;
- хэрэгжилтийн үе шат, шилжилтийн хугацаа зэргийг нарийвчлан тооцох нь зүйтэй.

Энэхүү урьдчилан тандан судалгааны дүнгээс үзэхэд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын асуудал нь зөвхөн олборлох үйлдвэрлэлийн тайлан гаргах асуудлаар хязгаарлагдахгүй байна. Харин байгалийн нөөц ашиглалттай холбоотой зөвшөөрөл, гэрээ, төлбөр, татвар, орлого, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт, ус ашиглалт, орон нутгийн гэрээ, хандив, дэмжлэг, эцсийн өмчлөгч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэх, баталгаажуулах, олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр хүргэх мэдээллийн засаглалын асуудал байна.

Одоогийн байдлаар энэ мэдээлэл олон хууль, олон байгууллага, олон мэдээллийн санд салангид байдлаар бүрдэж байгаа бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, салбарын хууль тогтоомж, ОУИТБС-ын туршлага зэрэг нь чухал суурь болж байгаа боловч байгалийн нөөц ашиглалтын онцлог мэдээллийг нэгтгэх,

баталгаажуулах, тайлангийн зөрүүг тодруулах, мэдээллийн нууцын ялгааг тогтоох, олон талт хяналтын тогтолцоог баталгаажуулахад хангалтгүй байна.

Иймд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах анхдагч хууль боловсруулах шаардлагатай гэж дүгнэв.

Уг анхдагч хуулийг боловсруулахдаа ашигт малтмал, газрын тосоор хязгаарлахгүйгээр ус, ой, амьтан, байгалийн ургамал, газар, газрын хэвлий зэрэг байгалийн нөөцийн өргөн хүрээг хамарч болох эсэхийг нарийвчлан тодорхойлж, мэдээллийг нэг цонхны зарчмаар нэгтгэх, мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох, нийтийн ашиг сонирхлын мэдээллийн нууцын ялгааг тодорхой болгох, тайлангийн зөрүүг шийдвэрлэх, олон талт хяналтын тогтолцоог хуульчлах, холбогдох салбарын хуулиудтай уялдуулах нь зүйтэй.

Ийнхүү анхдагч хууль боловсруулах нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан байгалийн баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх зарчим, иргэний мэдэх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, байгалийн баялгийн үр өгөөжийг шударга, ил тод, хариуцлагатай ашиглах бодлогын хэрэгжилтийг дэмжих ач холбогдолтой гэж үзэж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**1. Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн акт**

1. Монгол Улсын Ардын Их Хурал. (1992). *Монгол Улсын Үндсэн хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
2. Монгол Улсын Их Хурал. (2015). *Хууль тогтоомжийн тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
3. Монгол Улсын Засгийн газар. (2016). *Аргачлал батлах тухай: Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
4. Монгол Улсын Засгийн газар. (2016). *Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
5. Монгол Улсын Их Хурал. (2021). *Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
6. Монгол Улсын Засгийн газар. (2022). *Нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх журам болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам батлах тухай: Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоол*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
7. Монгол Улсын Их Хурал. (2014). *Шилэн дансны тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
8. Монгол Улсын Засгийн газар. (2016). *Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
9. Монгол Улсын Их Хурал. (2022). *Зөвшөөрлийн тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
10. Монгол Улсын Их Хурал. (2006). *Ашигт малтмалын тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
11. Монгол Улсын Их Хурал. (2014). *Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
12. Монгол Улсын Их Хурал. (1988). *Газрын хэвлийн тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
13. Монгол Улсын Их Хурал. (2002). *Газрын тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
14. Монгол Улсын Их Хурал. (2012). *Усны тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
15. Монгол Улсын Их Хурал. (2012). *Ойн тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
16. Монгол Улсын Их Хурал. (1995). *Байгалийн ургамлын тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
17. Монгол Улсын Их Хурал. (2012). *Амьтны тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.

18. Монгол Улсын Их Хурал. (2012). *Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
19. Монгол Улсын Их Хурал. (1995). *Байгаль орчныг хамгаалах тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
20. Монгол Улсын Их Хурал. (2012). *Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
21. Монгол Улсын Их Хурал. (2018). *Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.
22. Монгол Улсын Их Хурал. (2015). *Захиргааны ерөнхий хууль*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.

2. Монгол Улсын мэдээллийн сан, тайлан, цахим эх сурвалж

23. Ашигт малтмал, газрын тосны газар. (2026). *Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн кадастрын мэдээлэл*. Ашигт малтмал, газрын тосны газар.
24. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. (2024). *ОУИТБС-ын цахим тайлангийн систем*. Монголын ОУИТБС.
25. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. (2024). *ОУИТБС-ын нэгтгэлийн тайлан*. Монголын ОУИТБС.
26. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. (2026). *Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан*. Монголын ОУИТБС.
27. Байгаль орчны мэдээллийн төв. (2026). *Байгаль орчны мэдээллийн сан*. Байгаль орчны мэдээллийн төв.
28. Байгаль орчны мэдээллийн төв. (2026). *Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан*. Байгаль орчны мэдээллийн төв.
29. Байгаль орчны мэдээллийн төв. (2026). *Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлангийн мэдээллийн сан*. Байгаль орчны мэдээллийн төв.
30. Сангийн яам. (2026). *Шилэн дансны цахим систем*. Монгол Улсын Сангийн яам.
31. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. (2026). *Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем*. Монгол Улсын Засгийн газар.
32. Улсын бүртгэлийн ерөнхий газар. (2026). *Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сан*. Улсын бүртгэлийн ерөнхий газар.
33. Нээлттэй засаглалын түншлэл. (2023). *Монгол Улсын Нээлттэй засаглалын түншлэлийн 2023–2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөө*. Open Government Partnership.
34. Нээлттэй засаглалын түншлэл. (2023). *Advancing Extractive Industry Transparency in Mongolia /MN0057/*. Open Government Partnership.
35. Нээлттэй засаглалын түншлэл. (2021). *Beneficial Ownership Transparency in Mongolia /MN0044/*. Open Government Partnership.
36. Нээлттэй засаглалын түншлэл. (2021). *Strengthening Extractive Industry Transparency in Mongolia /MN0048/*. Open Government Partnership.

3. Олон улсын стандарт, санаачилга

37. Extractive Industries Transparency Initiative. (2023). *EITI Standard 2023*. EITI International Secretariat.
38. Extractive Industries Transparency Initiative. (2024). *Guidance Note: Contracts and Licenses*. EITI International Secretariat.
39. Extractive Industries Transparency Initiative. (2023). *EITI Requirement 2.5: Beneficial Ownership*. EITI International Secretariat.
40. Extractive Industries Transparency Initiative. (2023). *EITI Requirement 6.1: Social and Environmental Expenditures*. EITI International Secretariat.
41. Extractive Industries Transparency Initiative. (2024). *EITI Progress Report 2024*. EITI International Secretariat.
42. United Nations Economic Commission for Europe. (1998). *Convention on Access to Information, Public Participation in Decision-making and Access to Justice in Environmental Matters*. UNECE.
43. United Nations Treaty Collection. (1998). *Convention on Access to Information, Public Participation in Decision-Making and Access to Justice in Environmental Matters*. United Nations.
44. Open Data Charter. (2015). *International Open Data Charter Principles*. Open Data Charter.
45. Open Ownership. (2024). *Beneficial Ownership Data Standard*. Open Ownership.
46. Open Ownership. (2024). *Legislating for Effective Beneficial Ownership Transparency Reforms in the Extractive Sector*. Open Ownership.

4. Бусад улсын хууль, эрх зүйн зохицуулалт

47. Parliament of Canada. (2014). *Extractive Sector Transparency Measures Act*. Justice Laws Website, Government of Canada.
48. Government of Canada. (2015). *Extractive Sector Transparency Measures Act*. Government of Canada.
49. European Union. (2013). *Directive 2013/34/EU: Accounting Directive*. European Union.
50. European Commission. (2013). *Accounting Directive: Disclosure of Payments to Governments by Extractive and Logging Companies*. European Commission.
51. Republic of Estonia. (2014). *Environmental Register Act*. Riigi Teataja.
52. Republic of Estonia. (2022). *General Part of the Environmental Code Act*. Riigi Teataja.
53. Estonian Environment Agency. (2026). *EELIS: Estonian Nature Information System*. Estonian Environmental Portal.
54. Republic of Kazakhstan. (2017). *Code on Subsoil and Subsoil Use*. Adilet Legal Information System.
55. Extractive Industries Transparency Initiative. (2025). *Kazakhstan: EITI Country Information*. EITI International Secretariat.
56. Government of the United Kingdom. (2024). *Collect, Use and Exchange Beneficial Ownership*

Information. GOV.UK.

**БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай анхдагч хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог.

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төслийн тухайд Байгалийн нөөц ашиглалтын /амьтны нөөц ашиглалт, үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглалт, ой, түүний дагалт баялгийн нөөц ашиглалт, байгалийн ургамлын нөөц ашиглалт, олборлох үйлдвэрлэлийн/ ил тод байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, зохион байгуулах, мэдээллийг тайлагнах, ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд оролцож байгаа зардлыг төрийн байгууллагын зардал болон зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн зардал гэсэн 2 үндсэн оролцогчийн зардлыг тооцоолон гаргав. Хуулийн төсөлд олборлох салбард ил тод байдлыг хангах төрийн байгууллага, хуулийн этгээдийн хүлээх үүргийг тусгайлан заасан бөгөөд иргэний эрх, үүрэг тусгагдаагүй тул иргэний хувьд үүсэх зардлыг тооцоолоогүй болно.

Зардал тооцогдсон субъект:

- Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай /анхдагч хууль/ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон **төрд** үүсэх зардал;
- Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай /анхдагч хууль/ хуулийн хүрээнд **хуулийн этгээдэд** үүсэх зардал.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан.

- Төрийн байгууллага болон хуулийн этгээдийн энэхүү хуулиар хүлээсэн үүргийг оновчтой тодорхойлох.

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах талаар **төрийн байгууллагын** хуульд тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцохыг зорилоо.

Төр болон хуулийн этгээдэд үүсэх зардлыг тухайн үйл ажиллагааг явуулахад шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар хуулийн төсөлд тусгагдсан этгээдийн гүйцэтгэх үүрэг буюу үйл ажиллагааг тодорхойлох байдлаар гаргасан.

I. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР ТӨРД НЭМЭЛТЭЭР ҮҮСЭН БИЙ БОЛОХ ЗАРДАЛ:

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Хуулийн төсөлд шинээр тусгагдсан хэрэгжүүлэгч төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу түүний чиг үүргийг тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хэмжих боломжтой ажлыг хамааруулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Хоёрдугаар үе шатны хүрээнд: Шинээр нэмэгдсэн хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны гол мөнгөн зардлыг тооцсон болно. Түүнчлэн хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх бусад төрийн байгууллагад үүсэх зардлыг тодорхойлохыг зорилоо.

Гуравдугаар үе шатны хүрээнд: Энэ үе шатанд нийт дүнг тооцоолно.

Дөрөвдүгээр үе шатны хүрээнд: Хувилбарыг нягтлан хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэнэ. Төрийн байгууллагын зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтоохыг зорино.

1.1. Хуулийн төсөл батлагдснаар төрд шууд үүсэх зардлын тооцоо

Хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг хариуцах төрийн байгууллагуудад үүсэх зардлын тухайд

Тодорхой чиг үүрэг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан үүргийг хариуцах төрийн байгууллагууд нь тухайн чиг үүргийг шинээр ажилтан авч ажиллуулахгүйгээр одоо тухайн чиглэлээр ажиллаж байгаа хүний нөөцийг ашиглан, батлагдсан төсөвтөө багтаан гүйцэтгэх боломжтой харагдаж байна.

Хуулийн төсөлд хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцоонд шинээр тусгасан Үндэсний зөвлөл, түүний ажлын албаны зохицуулалттай холбогдон гарах зардал, түүний санхүүжилтийн тухайд

Монгол Улсын Засгийн 2012 оны 222 дугаар тогтоолын дагуу аймаг, нийслэл засаг дарга нарт “компаниуд болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ОУИТБС-ын дэд зөвлөлийг аймаг, нийслэлийн Засаг даргын орлогчоор ахлуулан орон нутгийн захиргааны байгууллага, компаниуд, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн төлөөллийн 3 талын тэгш оролцоо бүхий бүрэлдэхүүнтэйгээр байгуулан үйл ажиллагаанд нь хяналт тавих” үүрэг болгосны дагуу 2014-2015 онуудад 21 аймаг, нийслэл, 13 сум, 1 дүүрэгт дэд зөвлөлийг байгуулан ажиллуулж байна.

Мөн Засгийн газрын 2017 оны 263 тогтоолын дагуу аймаг, нийслэл, сум дүүргийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг 2019 оноос эхлэн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахаар заасан хэдий ч санхүүжилтыг олгоогүй өнөөг хүрсэн.

Улсын төсвөөс санхүүжилт байхгүйгээс шалтгаалан Дэд буюу салбар зөвлөлийн үйл ажиллагаа төдийлэн жигдэрч өгөөгүй байна. ОУИТБС-ын ажлын албанаас жил бүр ойролцоогоор 200 орчим сая төгрөгийн санхүүжилтыг ОУИТБС-ын салбар зөвлөлийн зарцуулалт, санхүүжилтийг төлөвлөн холбогдох байгууллагуудад оруулдаг байсан боловч улсын төсвийн хөрөнгө хязгаартай байна гэсэн шалтгааны улсаас батлагдахгүй өдий хүрээд байна.

2024 оны хувьд ОУИТБС-ын салбар зөвлөлийн зардалд нийтдээ 248,4 сая төгрөгийн санхүүжилт олгуулахаар холбогдох тооцоог боловсруулан 2024 оны улсын төсөвт тусгахаар санал хүргүүлээд байна. Үүнд: Салбар зөвлөлд ажиллах ажилтнуудын цалин ба урамшуулалд 151,8 сая, үйл ажиллагааны зардалд 96,6 сая төгрөг багтсан болно. Үйл ажиллагааны үндсэн чиглэл салбар зөвлөлийн хурал, гишүүдийн сургалт, ил тод байдлын сурталчилгаа, үйл ажиллагааны тайлан, газар дээр хийх зохион байгуулах шалгалт зэрэг байх юм.

Дээрх тооцооллоос үзвэл хуулийн төслөөс хамаарч төсөвт нэг жилд Үндэсний зөвлөл, түүний ажлын албаны зардалд 248.4 сая төгрөгний санхүүжилт шаардлагатай.

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагуудад үүсч болох зардал нь хуулийн үр өгөөжтэй харьцуулахад үлэмж бага буюу үр ашиг өндөр байна гэж үзлээ.

II.ОЛБОРЛОХ САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДОН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭН БИЙ БОЛОХ ЗАРДАЛ:

Олборлох салбарын ил тод байдлыг хангахад хуулийн этгээдийн хуульд тусгасан үүргээ хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцох шаардлагатай.

Хуулийн төсөлд тусгасны дагуу дээрх зардлуудын тооцох ажлыг дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн:

1. хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. зардлыг тооцох;
3. тоон үзүүлэлтийг тооцох;
4. нийт зардлын дүнг тооцож гаргах;
5. хялбарчлах боломжийг шалгах;
6. нэмэлт зардлыг тооцох.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Хуулийн төсөлд тусгасан хуулийн этгээдийн хүлээх үүргийг тодорхойлбол: Хуулийн төслийн дагуу хуулийн этгээд / төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага болон бусад хуулийн этгээд/ дараах үүргийг хүлээж байна:

- холбогдох мэдээллийн санд мэдээлэл оруулах
- ил тод байдлын тайлан илгээх
- мэдээллийг нийтэд цахимаар тогтмол мэдээлэх

Хоёрдугаар үе шатны хүрээнд: Хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд зарцуулах хугацааг тодорхойлсны үндсэн дээр нэг хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардлыг тооцов.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцдог.

Гуравдугаар үе шатны хүрээнд: Зардлын тооцоог хүний нөөцийн, бусад гэсэн зардлын бүрэлдэхүүн хэсэгт хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тодорхойлов.

Тоон үзүүлэлтийг тооцох зардлыг хуанлийн 1 жилийн хугацаанд тухайн үүргийг хуулийн этгээд хэдэн удаа хэрэгжүүлэхээс хамаарч гаргадаг бөгөөд дээрх хүснэгтэнд дурдсан үүрэгт үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг гүйцэтгэхтэй холбоотой гарах зардлуудыг тухайн хуулийн этгээд жилд 1 – 12 удаа хийдэг гэж үзсэн.

Дөрөвдүгээр үе шатны хүрээнд: Нийт зардлын дүнг тооцох үе шатанд зардлын нийт дүнг тооцож гаргадаг. Ингэж тооцохдоо тухайн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлж гаргасан.

Тавдугаар үе шатны хүрээнд: Энэ шатанд хялбарчлах боломжийг шалгадаг бөгөөд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг дараах асуулгаар тодруулж гүйцэтгэлээ.

2.1.Олборлох салбарт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой зардал

Хуулийн этгээд	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Хийгдэх ажиллагаа	Холбогдох зардал Жилд хэдэн удаа хийдэг	ОУИТБС-ын ажлын албаны тайлбар
Зөвшөөрөл эзэмшигч	Хуулийн төслийн 17 дугаар зүйл	Ил тод байдлын тайлан гаргагчаар бүртгүүлэх, энэ хуульд заасан журмын дагуу ил тод байдлын тайланг хуульд заасан хугацаанд холбогдох маягтын дагуу гаргах (17.3.);	0 төгрөг /1 удаа/	Мэдээллийн санд бүртгүүлэхэд төлбөр төлдөггүй. Тайлан гаргагч байгууллагын ажилтан (нягтлан бодогч, геологч г.м) хариуцан гүйцэтгэх бөгөөд ажлын дагалдах үүрэг тул ажил үүргийнхээ хүрээнд хамруулан гүйцэтгэнэ. Нэмэлт зардал гарахгүй.
		Үндэсний зөвлөл, түүний ажлын алба болон тайлан нэгтгэгчээс тавьсан тодруулгын хариуг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргах, шаардлагатай мэдээллийг хамаарал бүхий нэгж, салбар, толгой, охин компаниар	0 төгрөг	Тайлан гаргагч байгууллагын ажилтан (нягтлан бодогч, геологч г.м) хариуцан гүйцэтгэх бөгөөд ажлын дагалдах үүрэг тул ажил үүргийнхээ хүрээнд хамруулан гүйцэтгэнэ. Нэмэлт зардал гарахгүй.

		гаргуулах (11.2.5)		
		Олборлох салбарын ил тод байдлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх (11.2.7);	0 төгрөг	Тайлан гаргагч байгууллагын ажилтан (нягтлан бодогч, геологч г.м) хариуцан гүйцэтгэх бөгөөд ажлын дагалдах үүрэг тул ажил үүргийнхээ хүрээнд хамруулан гүйцэтгэнэ. Нэмэлт зардал гарахгүй.
		мэдээллийн санд мэдээллээ оруулах эрх бүхий албан тушаалтан нь бүрэн гүйцэд, үнэн зөв бичиг баримттай байх (11.2.8)		
		Мэдээллийг мэдээллийн сан тухай бүр оруулах	0 төгрөг /12 удаа буюу сард 1 удаа/	Нэмэлт зардал гарахгүй.
		Мэдээллээ нийтэд цахимаар ил тод мэдээлэх	0 төгрөг	Нэмэлт зардал гарахгүй.

	Асуулга	Тайлбар
1.	Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх	Олборлох салбарын ил тод байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийг тайлагнах, ил тод байдлыг хангах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахтай холбоотой төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход хуулийн төсөлд тусгасан хуулийн этгээдийн тоог багасгах шаардлага байхгүй гэж үзэж байна.
2.	Мэдээлэл хүргүүлэх	Мэдээллийг холбогдох газрууд тайлангийн хугацаандаа бэлтгэж байгаа мэдээллийг ил тод болгох нь хуулийн

	давтамжийг багасгах боломж байгаа эсэх;	төслийн үндсэн зорилт учраас давтамжийг багасгах шаардлагагүй гэж үзлээ.
3.	Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;	Олборлох салбарын ил тод байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийг тайлагнах нь нэг талаас нийгмийн хэрэгцээ шаардлага боловч нөгөө талаас хуулийн этгээдийн болон тухайн бизнесийн нууцтай холбоотой “эмзэг” мэдээллийг тайлагнах нь эрсдэл үүсгэх эсэхэд анхаарах шаардлагатай.
4.	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэх бүрэн боломжтой.
5.	Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;	Мэдээллийг цахимаар хүргүүлэхээр үүрэгжүүлсэн бөгөөд энэ нь хэрэгжихэд бүрэн боломжтой.
6.	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах шаардлага байхгүй гэж үзэж байна.
7.	Нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх	Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан ил тод байдлыг улам нэмэгдүүлэх.

Хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллага болон хуулийн этгээдээс гарах зардал нь:

- олборлох салбарын мэдээллийн санд түшиглэн салбарын бодлого, төлөвлөлтийг сайжруулах,
- орлого, үр өгөөж, эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх,
- хэрэгжүүлэх арга хэмжээний зарчмыг тодорхойлох,
- хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх болон
- салбарын үйл ажиллагаанд оролцогчдын чиг үүрэг, эрх зүйн байдалтай холбогдсон харилцааны үр өгөөжтэй байдлыг хангах ач холбогдолтой.

Энэхүү хүлээгдэж буй үр өгөөжтэй харьцуулахад тайлан гаргагч болон хуулийн этгээд хэрэгжүүлэгчдэд нэмэлт зардал гарахгүй, ажиллаж байгаа хүний нөөцдөө тулгуурлахаар хуулийн төслийг баталж хэрэгжүүлэх нь нийгэм, эдийн засагт ихээхэн ач холбогдолтой, үр ашиг өндөр байгаа нь энэхүү тооцооллоос харагдаж байна.

Үндэсний зөвлөл, түүний ажлын албаны тухайд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэд байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байгаа Олборлох салбарын ил тод байдлын санаачлагын ажлын албыг Засгийн газрын дэргэд шилжүүлэн ажиллуулах тул Үндэсний зөвлөл болон түүний ажлын албатай холбоотой нэмэлт зардал үүсэхгүй юм.

Мэдээллийн сан, системийн тухайд одоо ашиглаж, хэрэглэгдэж байгаа мэдээллийн сан, системүүдэд нэмэлт хөгжүүлэлт хийн ашиглах боломжтой тул мөн мэдээллийн сан, системтэй холбоотой нэмэлт зардал үүсэхгүй гэж үзэж байна.

---oOo---

**БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ
АЖЛЫН ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

А. Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх

Б. Мэдээллийг тайлагнах, ил тод байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой төрийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох

4.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

4.3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

4.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

4.5. Олборлох салбарын ил тод байдлын тухай хуулийн харилцан уялдаа.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох, арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад тус үнэлгээний ажлын зорилго оршино.

Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ үндсэн 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалт нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод нийцсэн эсэх, зорилгод хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэх, хуулийн төсөл нь ойлгомжтой, зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг үнэлж, төсвөөс гарах зардлын тооцоог хийж, тэдгээрийн үр дүнд үндэслэн анхаарах, өөрчлөх шаардлагатай зохицуулалтын талаар хуулийн төсөл боловсруулагчид зөвлөмж өгсөн.

Тус үнэлгээгээр Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төсөл батлагдсанаар байгалийн баялаг ашиглах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийг тайлагнах, ил тод байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой төрийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох цаашлаад байгалийн баялгаас ард түмэн үр өгөөж хүртэх орчин бүрдүүлж чадах эсэхэд хариулт өгнө.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн

зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн үндсэн зорилго нь төрийн байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн шаардлагатай бүхий л мэдээллийг тайлагнах процесс, тэдгээрийг нэгтгэх, батлах, хяналт тавих тогтолцоог нэвтрүүлэх, нээлттэй мэдээллийн санг бүрдүүлэх баяжуулах зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэж буйг анхаарч, хуулийн төслийн зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцов.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах үүднээс холбогдох этгээдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Олон улсын гэрээ, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг “Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан асуултад хариулах байдлаар үр нөлөөний үнэлгээг хийхээр сонгов.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар зэргийг холбогдох аргачлалын хүрээнд тооцон судлав.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг тусгай Тайланд тусгасан болно.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод хуулийн төслийн зохицуулалт нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийн зарим зүйл, хэсэг, заалтуудыг сонгон авсан болно.

“Практикт хэрэгжих боломж”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломж байна уу гэдгийг үнэлэх үүднээс хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой хуулийн төслийн зарим зүйл, хэсэг, заалтуудыг тус тус үнэлгээ хийхээр сонгосон болно.

“Ойлгомжтой байдал”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 22 зүйлтэй/

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх, байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлахаар зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож авав.

“Харилцан уялдаа”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 22 зүйлтэй/

**ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ
ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон бөгөөд урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон аргачлалд тодорхойлогдсон дараах шалгах хэрэгслүүд байна.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Төслийн 3.1, 12.1.1	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Төслийн 16 дүгээр зүйл Төслийн 17 дугаар зүйлийн зарим хэсэг	Хуулийн төслийг зөвшөөрөл эзэмшигч, төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Төслийн 16 дүгээр зүйл Төслийн 17 дугаар зүйлийн зарим хэсэг	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар өмнө хийгдсэн ажилд дүн шинжилгээ хийх
5	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс сонгосон хэм хэмжээг тухайн хуулийн төслийн зорилт болон хуулийн төслийн үзэл баримтлалд заасан хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэгдсэн эсэхийг судлах замаар үнэлгээг тогтооно.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны тайланд хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн

хамгаалалтад байна” гэж заасан. Ашигт малтмал, ой, ус, ан амьтан, байгалийн ургамлыг ашиглаж буй талаар мэдээллийг нэг эх сурвалжаас авах нөхцөлийг бүрдүүлэх замаар олон нийтийн мэдэх эрхийг хангах боломжтой;

- Эдийн засгийн голлох салбар учраас салбарын мэдээллийг нээлттэй байлгах, татварыг бүрэн төвлөрүүлэх, байгаль орчинд учрах хохирлыг бууруулах зорилгоор хяналт, дүн шинжилгээ, хариуцан тайлагнал зэргийг иж бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай;

- Олон улсын хэмжээнд уул уурхайн салбар нь авлига, мөнгө угаах гэмт хэргийн эрсдэл өндөр;

- Монгол Улс олборлох салбарын ил тод байдлын санаачилгад 2007 онд, Нээлттэй Засаглал түншлэлд 2013 онд тус тус нэгдэж олон улсын өмнө олборлох салбарын гэрээ болон эцсийн өмчлөгчийн гэх мэт мэдээллийг ил тод болгох үүрэг хүлээсэн.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг анх 2022 оны 12 дугаар сард Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд нар хамтран баталсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.6 дахь заалтын 1-д “Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдсэн байна.” гэж, 4.2 дахь заалтын 1-д “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдсэн байна.” гэж, 6.2 дахь заалтын 1-д “Биологийн олон янз байдлыг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэж хомсдолоос сэргийлэх, ашигт зүйлийг үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөц бүрдүүлнэ.” гэж, мөн заалтын 2-т “Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна.” гэж, мөн заалтын 4-т “Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлж, шинэ үеийн техник, технологийн шинэчлэл хийнэ.” гэж, 6.3 дахь заалтын 2-т “Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна.” гэж, мөн заалтын 4-т “Хүн амыг баталгаат ундны усаар хангах, усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлэх, төлөвлөлт, менежмент хийх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, мөн тус тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.1.5-д “Ил тод байдал, хамтын ажиллагаанд тулгуурлан гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.” гэж, 4.2.11-д “Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ.” гэж, 4.2.12-т “Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.6.5-д “олборлох салбарын ил тод байдлыг хангах” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 49-т Монгол Улсын эдийн засаг, нийгмийн урт хугацааны тогтвортой хөгжилд эрдэс баялгийн салбарын үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх” зорилгоор “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах” гэж тус тус заасан байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд зорилтыг “Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төслийн зорилт нь байгалийн баялаг ашиглалт, олборлох үйлдвэрлэлийн

засаглалыг сайжруулах замаар хувийн хэвшлээс хариуцлагатай хөрөнгө оруулалтыг татах, гадны хөрөнгө оруулагчдад ил тод, таатай орчин бүрдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүнээс хамаарах субъектив хамаарлыг бууруулах, салбарын үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтын талаарх мэдээллийг нэгтгэж, хяналттай, хариуцлагатай бөгөөд үр дүнтэй байхад төрийн бодлогыг чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон байна.

А. Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх

Энэ зорилтыг хэрэгжүүлэх зохицуулалтууд хуулийн төслийн 2, 3 дугаар бүлгүүдэд тусгагдсан байна.

Түүнчлэн тус хуулийн төслийн үйлчлэх хүрээг тодорхойлсон 3.1 дэх хэсэгт:

Хуулийн төслийн холбогдох заалт:

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль амьтан, ус, ой, ургамлын нөөц, эрдэс баялгийг ашиглахтай холбоотой энэ хуульд заасан мэдээлэл, тайланг нээлттэй, ил тод болгохтой холбоотой харилцаанд үйлчилнэ.

3.2.Мэдээллийг ил тод болгохтой холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар зохицуулна.

Дээрх зохицуулалт нь хуулийн төслийн зорилт болох “байгалийн нөөц, баялаг ашиглалтыг үндэсний ашиг сонирхолд нийцүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжих, байгалийн баялгийг нөхөн сэргээж, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх, олборлох үйлдвэрлэлийг байгальд сөрөг нөлөө багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлэх, байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлж, иргэний мэдэх эрхийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зорилгоор олборлох салбарын ил тод байдлыг хангах”-аар тусгагдсантай нийцэж байна.

Б. Мэдээллийг тайлагнах, ил тод байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох

Хуулийн төслийн сонгогдсон хэм хэмжээ	Хуулийн төслийн зорилго	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилго
<p>12.1.1.Улсын Их Хурлаас байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.1.1.Засгийн газраас хүргүүлсэн Улсын нэгдсэн тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан холбогдох байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж Засгийн газарт чиглэл өгөх.</p>	<p>Энэ хуулийн зорилго байгалийн нөөцийг ашиглахад олон нийт хяналт тавих, иргэний мэдэх эрхийг хангах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд оршино.</p>	<p>Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төслийн зорилт нь байгалийн баялаг ашиглалт, олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах замаар хувийн хэвшлээс хариуцлагатай хөрөнгө оруулалтыг татах, гадны хөрөнгө оруулагчдад ил тод, таатай орчин бүрдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүнээс хамаарах субъектив хамаарлыг бууруулах, салбарын үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтын талаарх мэдээллийг нэгтгэж, хяналттай, хариуцлагатай бөгөөд үр дүнтэй байхад төрийн бодлогыг чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.</p>

Үнэлгээ: Хуулийн төслийн 12.1.1 дэх заалт нь тухайн хуулийн төслийн зорилттой нийцэж байгаа эсэхийг тогтооно.

- Хуулийн төслийн 12.1.1 дэх заалт нь тухайн хуулийн төслийн зорилттой нийцэж байгаа эсэх:

УИХ нь Засгийн газраас хүргүүлсэн Улсын нэгдсэн тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан холбогдох байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж Засгийн газарт чиглэл өгөх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ; гэсэн нь хуулийн төслийн зорилттой нийцэж байна.

Дүгнэлт: Иймд хуулийн төслийн сонгогдсон зохицуулалт нь хуулийн төслийн зорилт болон түүнийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байна гэж дүгнэлээ.

4.2 “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэхээр хуулийн төслөөс сонгож авсан дараах зохицуулалтын талаар туршсан байдалд дүн шинжилгээ хийх, санал авч дүгнэлт гаргах замаар үр нөлөөг судаллаа.

Хуулийн төслийн сонгогдсон зохицуулалт	Тайлбар
<p>15 дугаар зүйл. Үндэсний зөвлөл</p> <p>15.1. Улсын хэмжээнд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хэрэгжүүлэх зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллах ба орон тооны Ажлын албатай байна.</p>	<p>МУ-ын Засгийн газрын 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 222 дугаар тогтоолоор Олборлох салбарын ил тод байдлын санаачилга (цаашид “ОУИТБС” гэх)-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэх)-ийг Засгийн газрын байгууллага, ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж, тэдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж (цаашид “компаниуд” гэх)-үүд, салбарын мэргэжлийн холбоо (цаашид “мэргэжлийн холбоо” гэх), олборлох салбарын ил тод байдлыг хангах чиглэлээр эвлэлдэн нэгдсэн иргэний нийгмийн эвсэл (цаашид “иргэний нийгмийн эвсэл” гэх)-ийн төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байхаар тогтоосон.</p>
<p>15.5. Үндэсний зөвлөл болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд зөвшөөрөл эзэмшигч, төрийн бус байгууллагын төлөөллийг сонгон шалгаруулж, томилох журмыг Засгийн газар батална.</p>	<p>МУ-ын Засгийн газрын 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 222 дугаар тогтоолоор Үндэсний зөвлөлийн дарга нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, нарийн бичгийн дарга нь Ерөнхий сайдын ахлах зөвлөх байхаар тогтоосон. (Засгийн газрын 2018 оны 289 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)</p>
<p>15.2. Үндэсний зөвлөл Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, байгаль орчин, геологи, уул уурхай, санхүү, төсөв, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, зөвшөөрөл эзэмшигчийн төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байна.</p>	<p>МУ-ын Засгийн газрын 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 222 дугаар тогтоолоор</p> <p>1.1. Засгийн газрын байгууллагын төлөөлөл-6;</p> <p>1.2. Улсын Их Хурал, түүний харьяа байгууллагын төлөөлөл-4;</p> <p>1.3. Компаниуд, мэргэжлийн холбоодын төлөөлөл-9, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжийн төлөөлөл-1;</p> <p>1.4. Иргэний нийгмийн эвслийн төлөөлөл 8;</p> <p>1.5. Байгаль орчны иргэний нийгмийн эвслийн төлөөлөл-2.</p>
<p>17.1. Үндэсний зөвлөл дараах чиг үүрэг бүхий Ажлын албатай байна:</p> <p>17.1.1. Энэ хуульд заасан мэдээлэл нийлүүлэгчээс байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тайланг хүлээн авах;</p> <p>17.1.2. Улсын нэгдсэн тайланг боловсруулах;</p>	<p>Засгийн газрын 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 222 дугаар тогтоолоор</p> <p>ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг Засгийн газрын байгууллага, компаниуд, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн эвслийн дараах төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байгуулсугай:</p>

<p>17.1.3. нэгдсэн порталын үйл ажиллагаа болон мэдээлэл нийлүүлэгчээс мэдээлэл, тайланг бүрэн нийлүүлж байгаа эсэхэд хяналт тавих, мэдээлэлд дүн шинжилгээ хийх;</p> <p>17.1.4. шаардлагатай тохиолдолд холбогдох шинжээч, мэргэжилтэн оролцуулж дүгнэлт гаргуулах, мэдээлэл, тайлангийн үнэн зөв байдлыг нягтлах;</p> <p>17.1.5. байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг сайжруулах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах санал, зөвлөмж боловсруулах;</p> <p>17.1.6. Улсын нэгдсэн тайланд үндэслэн цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж гаргах, зөвлөмжийг холбогдох этгээдэд хүргүүлэх, зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнгийн хариуг тогтоосон хугацаанд хүлээн авах;</p> <p>17.1.7. Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</p>	<p>3.1. Засгийн газрын байгууллагын төлөөлөл-10;</p> <p>3.2. Улсын Их Хурлын харьяа байгууллагын төлөөлөл-1;</p> <p>3.3. Компаниуд, мэргэжлийн холбоодын төлөөлөл-9, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжийн төлөөлөл-2;</p> <p>3.4. Иргэний нийгмийн эвслийн төлөөлөл 9;</p> <p>3.5. Байгаль орчны иргэний нийгмийн эвслийн төлөөлөл-2;</p> <p>3.6. Ажлын албаны зохицуулагч.</p>
<p>18.2. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу бэлтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба төсвийн ерөнхийлөн захирагч уг төсвийн төслийг багцдаа тусган батлуулна.</p>	<p>18 дугаар зүйл. Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт</p> <p>18.1. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс, түүний орон нутагт ажиллах салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.</p> <p>18.2. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу бэлтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба төсвийн ерөнхийлөн захирагч уг төсвийн төслийг багцдаа тусган батлуулна.</p> <p>18.3. Үндэсний зөвлөл салбар зөвлөлийн төсвийг тухайн аймаг, нийслэлийн төсөвт тусган баталуулна.</p> <p>18.4. Үндэсний зөвлөл, түүний салбар зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт бие даасан, хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд хүрэлцээтэй байна.</p> <p>18.5. Үндэсний зөвлөл, салбар зөвлөл мэдээлэл нийлүүлэгч этгээдээс зээл, хандив, дэмжлэг авахыг хориглоно.</p>

<p>15.7. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Ажлын албаны дарга байна.</p>	<p>Засгийн газрын 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 222 дугаар тогтоол</p> <p>4. Ажлын хэсгийн ахлагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нь ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч байхаар тогтоосугай. (Засгийн газрын 2018 оны 289 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)</p>
---	---

Үнэлгээ:

1. Одоогийн хууль эрх зүйн орчны хүрээнд Олборлох салбарын ил тод байдлын санаачилгыг (цаашид "ОУИТБС" гэх) хэрэгжүүлэх Үндэсний зөвлөл, түүний ажлын албыг Засгийн газрын МУ-ын Засгийн газрын 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 222 дугаар тогтоолоор, Үндэсний зөвлөл, ажлыг хэсгийн бүрэлдэхүүнд хамаарах төрийн байгууллагын албан тушаалтны бүрэлдэхүүнийг 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн Ерөнхий сайдын 62 дугаар захирамжаар баталсан нь хүчин төгөлдөр үйлчилж байна.

2. Тиймээс дээрх асуудал нь шинээр тусгагдаж буй зохицуулалт биш бөгөөд үүнийг хуульчлан баталгаажуулахаар тусгаж өгсөн байна. Одоогийн байдлаар Үндэсний Зөвлөлд 30 гишүүн, ажлын албанд орон тооны 4 гишүүн ажиллаж байна. Мөн ажлын хэсэг байгуулсан байх бөгөөд уг ажлын хэсэг нь 33 хүний бүрэлдэхүүнтэй байна. Хэрэв хууль батлагдсан тохиолдолд дээрх эрх зүйн актуудыг хүчингүй болгох эсхүл холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах шаардлагатай болно.

3. Хуулийн төслийн 15.3-т "Үндэсний зөвлөлийн 7 гишүүнийг зөвшөөрөл эзэмшигч, төрийн бус байгууллагын төлөөллөөс нээлттэй сонгон шалгаруулж, 3 жилийн хугацаагаар, үлдсэн 8 гишүүнийг энэ хуулийн 15.2-т заасан төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосноор Засгийн газар томилно" гэж заасан. Тус зохицуулалтаас харахад байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг орон нутагт хэрэгжүүлэх салбар зөвлөлийг байгуулах эсэх нь Үндэсний зөвлөлийн бүрэн эрх байхаар байна. Орон нутгийн төсвөөс санхүүжих дээрх салбар зөвлөлийг ямар нөхцөл шалгуурыг хангасан үед байгуулахыг хуульд хэм хэмжээний акт батлах эрх олгох замаар эсхүл шууд зохицуулсан зохицуулалтыг хуульд тусгах замаар зохицуулах нь оновчтой гэж үзэж байна.

Дүгнэлт: Үндэсний зөвлөл, түүний ажлын алба нь Засгийн газрын тогтоолоор байгуулагдаж, олон улсын байгууллагаас санхүүжиж ажиллаад нэлээдгүй уджээ. Хуулийн төслийн хэлэлцүүлэг³-ийн явцад энэхүү зохицуулалтай холбоотой дараах санал ирсэн:

➢ Энэ хуулийн хэрэгжилт орон нутагт гацах тохиолдол бий. Орон нутгийн засаг даргад эрх өгсөн, бараг хүчин төгөлдөр үйлчилж байгаа 600 хуулийн бүх хэрэгжилтийг хангах, уул уурхай, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүний нөөц, санхүүжилт дутмаг зэрэг шалтгаанаар удаашрах, гацах нь бий. Үндэсний зөвлөл нь салбар зөвлөлдөө асуудлыг тухайлан хариуцсан мэргэжилтэн, хүний нөөцтэй байх шаардлагатай. Шат шатандаа хуулийн хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бий болгох тал дээр анхаарч ажиллах.

➢ Засгийн газрын дэд зөвлөлийг санхүүжүүлэх тухай тогтоол хүчингүй болсон уу. Хуулийн төслийг бичсэн хүмүүс Иргэний нийгмийн хүсдэг бүх зүйлийг оруулсан байгаа нь ач холбогдолтой болсон байна. Иймд хуулийн төслийг эерэг талаас нь хараад илүү сайжруулах тал дээр саналаа хэлээд явъя. Нэг зүйл орхигдсон байгаа нь аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллагын чиг үүрэг ерөөсөө байхгүй, зөвхөн төсвийг баталж өгнө гэж байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь сангаа удирдаад, сан нь хандив

тусламжаа удирдаад явж байгаа байдал руу орж байгаа, ер нь нийтлэг болж байна гэсэн саналууд ирсэн байна.

Иймд сонгосон зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа хэдий ч үнэлгээ хэсэгт дурдагдсан өөрчлөх, найруулах, тодорхой шаардлагатай зохицуулалт байгааг анхаарах шаардлагатай байна.

4.3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг тогтоох зорилгоор 2020 оны 10 дугаар 06-ны өдөр Улаанбаатар хот, Туушин зочид буудал, Хархорин танхимд зохион байгуулсан “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуульд өгөх иргэний нийгмийн санал шүүмж боловсруулах хэлэлцүүлэг”,

http://forum.mn/index.php?sel=content&obj_id=5885 болон

<https://www.mmhi.gov.mn/public/forum/id/1089> цахим сайтад байршуулах замаар хуулийн төсөлд санал авахад хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд дараах саналыг ирүүлсэн байна.

➤ Тогтмол мэдээлэл гэсэн үг маш их гарч байна. Тогтмол мэдээлэл гэдэг нь өдөр бүр байх юм уу, энэ яг юу гэж ойлгогдох вэ. Нэр томъёоны тайлбар дээр байхгүй;

➤ Байгаль орчны яамтай холбоотой эрх, үүрэг дээр, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуультай давхцаж байгаа хэсэг байгаа эсэх, дээрээс нь төсөл гэдгийг хоёр янзаар тодорхойлсон байна гэсэн саналууд иржээ.

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцсэн байна.
29.1.2. тухайн хуулиар зохицуулах харилцаанд хамаарах нийгмийн асуудлыг бүрэн тусгасан байх;	Тус хуулийн төслөөр олборлох салбарын ил тод байдлын тогтолцоог бий болгоход шаардлагатай мэдээллийн сан, түүний бүрдэл, анхан шатны тайлан гаргаж өгөх этгээд, тайланг нэгтгэх, түүнийг хэрэгжүүлэх процессыг тодорхойлох асуудлыг бүрэн тусгасан.

<p>29.1.3. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;</p>	<p>Хуулийн төслийн 3.1. Энэ хууль нь амьтан агнах, барих, усны нөөц, ойн баялаг, байгалийн ургамлын нөөц ашиглах, эрдэс баялаг хайх, ашиглах үйл ажиллагааны мэдээлэл, гэрээ, хэлэлцээрийг нээлттэй байлгах, мэдээллийн сан бүрдүүлэх, ил тод байдлыг хангахтай холбогдох харилцаанд үйлчилнэ.” гэж заасан нь хуулийн төслийн зорилттой нийцэж байна.</p>
<p>29.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;</p>	<p>Тус хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгаагүй.</p>
<p>29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;</p>	<p>Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь хоорондоо уялдаж байгаа эсэхийг тайлангийн Хууль тогтоомжийн уялдаа холбоог судалсан хэсгээс харна уу.</p>
<p>29.1.6. хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;</p>	<p>Нэг удаа хэрэгжүүлэх заалт хуулийн төсөлд тусгаагүй.</p>
<p>29.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;</p>	<p>Бусад хуулийн заалтыг давхардуулан заагаагүй.</p>
<p>29.1.8. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;</p>	<p>Тус хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журамд нийцсэн.</p>
<p>29.1.9. шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн</p>	<p>Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагч, эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацааны зохицуулалтыг тусгасан.</p>

зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байна.
30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэсэн.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Хуулийн төсөлд “тогтмол мэдээлнэ” гэж 26 удаа орсон боловч үүнийгээ нэр томъёоны тодорхойлолтод тусгаж өгөөгүйн улмаас төөрөгдөл үүсгэх боломжтой байна.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Хүч оруулсан нэр томъёо хэрэглээгүй.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Олон тоон дээр хэрэглэсэн байдал байхгүй.

4.4.Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

БАЙГАЛИЙН БАЯЛАГ АШИГЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ БАЙДАЛ

Хуулийн зохицуулалт	Иргэд, хуулийн этгээдэд нөлөөлөх эсэх		
	Иргэний эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх	Аж ахуйн нэгжид шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх	Хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэх
<p>Хавсралт. Байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл</p> <p>1.1.2.Гэрээ, хэлэлцээр, түүний нэмэлт, өөрчлөлт болон хэрэгжилтийн мэдээлэл нь дараах мэдээллээс бүрдэнэ:</p> <p>1.1.2.1.бүтээгдэхүүн хуваах гэрээ;</p> <p>1.1.2.2.орд ашиглах гэрээ;</p> <p>1.1.2.3.үүсмэл орд ашиглах гэрээ;</p> <p>1.1.2.4.хөрөнгө оруулалтын гэрээ, түүнтэй адилтгах гэрээ;</p> <p>1.1.2.5.зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;</p> <p>1.1.2.6.нутгийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;</p> <p>1.1.2.7.зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан газар эзэмших, ашиглах гэрээ;</p> <p>1.1.2.8.өвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан ус ашиглах гэрээ;</p> <p>1.1.2.9.усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ;</p> <p>1.1.2.10.бичил уурхай эрхлэгчтэй байгуулсан гэрээ;</p> <p>1.1.2.11.нөхөн сэргээлтийн гэрээ;</p> <p>1.1.2.12.тогтворжуулалтын гэрээ, гэрчилгээ.</p>	Иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлаагүй.		Сонгогдсон зохицуулалт нь түүнийг хэрэгжүүлэх этгээдүүдийн үйл ажиллагаанд нийцэхээр байна.

<p>1.1.9.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн мэдээлэл нь дараах мэдээллээс бүрдэнэ:</p> <p>1.1.9.1.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч хүний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, харьяалал, төрсөн огноо, улс төрд нөлөө бүхий этгээд эсэх мэдээлэл, улс төрд нөлөө бүхий этгээдэд тооцогдож эхэлсэн талаарх мэдээлэл.</p> <p><i>Тайлбар: "хувьцаа эзэмшигч" гэж зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаар болон бусад этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд, тэдгээрийн эцсийн өмчлөгч хүнийг, "эцсийн өмчлөгч" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан хүнийг, "улс төрд нөлөө бүхий этгээд" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.5 д заасан албан тушаалтныг тус тус ойлгоно.</i></p>	<p>Иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй.</p>	<p>Мэдээлэл нийлүүлэгч этгээд: Хуулийн этгээдийн улсын бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллага байна.</p>	<p>Сонгогдсон зохицуулагч нь түүнийг хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд нийцэж байна.</p>
<p>1.1.6.төсвийн орлогын хуваарилалтын мэдээлэл нь дараах мэдээллээс бүрдэнэ:</p> <p>1.1.6.1.эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогын төсвийн хуваарилалт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн төсөвт шилжүүлсэн дүн, зарцуулалтын мэдээлэл;</p> <p>1.1.6.2.сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай данс, тусгай зориулалтын сангийн орлого, зарлагын мэдээлэл.</p>	<p>Иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй.</p>	<p>Мэдээлэл нийлүүлэгч этгээд: Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байна.</p>	<p>Сонгогдсон зохицуулагч нь түүнийг хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд нийцэж байна.</p>
<p>1.1.3.Зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны мэдээлэл нь дараах мэдээллээс бүрдэнэ:</p> <p>1.1.3.1.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж;</p> <p>1.1.3.2.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хянагдсан техник, эдийн засгийн үндэслэлийн нууцад хамааруулснаас бусад мэдээлэл;</p> <p>1.1.3.3.эрх бүхий этгээдийн хянасан/хүлээн авсан хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан, уулын ажлын төлөвлөгөө, тайлангийн нууцад хамааруулснаас бусад мэдээлэл;</p> <p>1.1.3.4.Байгаль орчны албаны зөвшөөрөл;</p> <p>1.1.3.5.Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-т заасан комиссын шийдвэр;</p>	<p>Иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй.</p>	<p>Мэдээлэл нийлүүлэгч этгээд: Зөвшөөрөл эзэмшигч байна.</p>	<p>Сонгогдсон зохицуулагч нь түүнийг хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд нийцэж байна.</p>

<p>1.1.3.6.палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн судалгааны ажлын тайлан, дүгнэлт;</p> <p>1.1.3.7.цацраг идэвхт ашигт малтмалын аюулгүй ажиллагааны олон улсын стандартын шаардлагад нийцсэн иж бүрэн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үйл ажиллагаа эрхлэх байрны цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүйн стандартын шаардлага хангасан талаарх төрийн захиргааны байгууллагын үнэлгээ, цөмийн болон цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, цацрагийн түвшний 30 хоног тутмын мэдээлэл;</p> <p>1.1.3.8.эрх бүхий байгууллагаас тавьсан акт, албан шаардлага, шүүхийн өмнөх болон шүүхийн журмаар шийдвэрлэсэн хэрэг, маргаан, шийдвэрийн мэдээлэл.</p>			
<p>1.1.7.зөвшөөрөл эзэмшигчээс нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн зарцуулалтын мэдээлэл нь дараах мэдээллээс бүрдэнэ:</p> <p>1.1.7.1.бусдад өгсөн хандив, дэмжлэг, тусламж, урамшууллын хэмжээ, хэлбэр, зориулалт, гэрээ;</p> <p>1.1.7.2.нийгмийн хариуцлагын хүрээнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн нийт дүн;</p> <p>1.1.7.3.нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хэрэгжүүлэхэд гарсан зардлын хэмжээ;</p> <p>1.1.7.4.Газрын тосны тухай хуулийн 40.1, Ашигт малтмалын тухай хуулийн 41.1-д заасны дагуу төлсөн хохирлын нөхөн төлбөр, холбогдох бусад зардлын мэдээлэл;</p>	<p>Иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй.</p>	<p>Мэдээлэл нийлүүлэгч этгээд: Зөвшөөрөл эзэмшигч байна.</p>	<p>Сонгогдсон зохицуулалт нь түүнийг хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд нийцэж байна.</p>

4.5.Харилцан уялдаа шалгуурын хүрээнд:

БАЙГАЛИЙН БАЯЛАГ АШИГЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ
хуулийн төслийн харилцан уялдаа

Хуулийн зохицуулалт	Давхардсан эсхүл зөрчилдсөн хуулийн зохицуулалт байгаа эсэх
<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилго байгалийн нөөцийг ашиглахад олон нийт хяналт тавих, иргэний мэдэх эрхийг хангах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд оршино.</p>	Үгүй
<p>2 дугаар зүйл.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын хууль тогтоомж 2.1.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль тогтоомж Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p>	Үгүй
<p>2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.</p>	Үгүй
<p>3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 3.1.Энэ хууль амьтан, ус, ой, ургамлын нөөц, эрдэс баялгийг ашиглахтай холбоотой энэ хуульд заасан мэдээлэл, тайланг нээлттэй, ил тод болгохтой холбоотой харилцаанд үйлчилнэ.</p>	Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.15, 11.1.5, 11 ¹ .1.3, 16.4.40 ² .1.2, 48.4 дах хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2.9, 2.10, 4.4, 8.2, 15.1.15, 16.2.3, 28.1.4, 30.3.6, 7 дугаар бүлэг буюу 33-44 дүгээр зүйлд эрдэс баялаг, геологи, байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан үүсгэх нийтэд мэдээлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.
<p>3.2.Мэдээллийг ил тод болгохтой холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар зохицуулна.</p>	Үгүй
<p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:</p>	Үгүй

<p>4.1.1.“Байгалийн нөөц ашиглалтын мэдээ лэл” гэж ус, ой, ургамал, амьтан, эрдэс баялгийг ашиглахтай холбоотой Засгийн газраас баталсан жагсаалтад хамаарах мэдээллийг;</p> <p>4.1.2.“зөвшөөрөл эзэмшигч” гэж Байгалийн нөөц ашиглалтын үйл ажиллагаа эрхлэхээр зөвшөөрөл авсан Зөвшөөрлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.3-т заасан этгээдийг;</p> <p>4.1.3.“мэдээлэл нийлүүлэгч” гэж энэ хуулийн 8.1-д заасан этгээдийг;</p> <p>4.1.4.“мэдээллийн нэгдсэн портал” гэж энэ хуульд заасан тайлан, мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хадгалах, нийтлэх зориулалттай цахим системийг;</p> <p>4.1.5. “олборлох үйлдвэрлэл” гэж ашигт малтмал, газрын тос хайх, ашиглахтай холбоотой Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай хуульд хамаарах эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг;4.1.6.“тайлан” гэж энэ хуулийн 9.1, 10.1-т заасан тайланг;</p> <p>4.1.7.“тайлангийн зөрүү” гэж өөр өөр мэдээлэл нийлүүлэгчийн тайланд ижил үзүүлэлтээр зөрүүтэй дүн, тайлбар, мэдээлэл гарсныг.</p> <p>4.1.8. “эрдэс баялаг” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.1-д заасан ашигт малтмал, Газрын тосны тухай хуулийн 4.1.1-д заасан газрын тосыг.</p> <p>4.1.9.“эцсийн өмчлөгч гэж” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан этгээдийг;</p> <p>4.1.10.“эцсийн эзэмшигч” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.48-д заасан этгээдийг;</p> <p>4.1.11.“мэдээлэл бий болсон” гэж гэрээ, хэлэлцээр, шийдвэр, зөвшөөрлийн баримт бичиг албан ёсоор байгуулагдсан, гаргасан, эсхүл бүртгэгдсэн, төлбөр, хураамж, татвар, төлбөр тооцоо хийгдсэн, хяналт шалгалт, үзлэг, шинжилгээ, хэмжилт хийгдэж, түүний үр дүн бүрдсэн, тайлан, акт, дүгнэлт, зөвлөмж албан ёсоор бүрдүүлэгдсэн, баталгаажсан, мэдээлэл бодит байдалд үүсч, түүнийг баримтжуулсан, бүртгэсэн өдөр зэргийн аль нэгээр үүссэн, бүрдүүлсэн, эсхүл бүртгэгдсэн байдлыг.</p> <p>4.1.12.“мэдээлэл нийлүүлэгч болох үндэслэл үүссэн” гэж энэ хуулийн 8.1.2-т заасан төрийн бус байгууллага нь зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал, санхүүжилт, эсхүл бусад хэлбэрийн үнэ бүхий зүйлийг анх удаа хүлээн авсан өдрийг.</p>	
<p>5 дугаар зүйл.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн баримтлах зарчим</p> <p>5.1.Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангахад дараах зарчмыг баримтална:</p> <p>5.1.1.мэдээлэл, тайлан олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байх;</p> <p>5.1.2.мэдээлэл, тайлан үнэн зөв, бүрэн байх;</p> <p>5.1.3.оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;</p>	<p>Үгүй</p>

<p>5.1.4.мэдээлэл, тайлан харилцан уялдаатай, нэгдмэл байх;</p> <p>5.1.5.олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх;</p> <p>5.1.6. өрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх.</p>	
<p>6 дугаар зүйл.Байгалийн нөөц ашиглалтын нэгдсэн портал</p> <p>6.1.Энэ хуульд заасан тайлан, мэдээллийг цахимаар хүлээн авах, бүртгэх, хадгалах, боловсруулах, шалгах, нийтлэх, мэдээлэл солилцох зориулалт бүхий мэдээллийн нэгдсэн портал (цаашид “нэгдсэн портал” гэх) ажиллуулна.</p> <p>6.2.Нэгдсэн портал Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.6-д заасан шаардлагад нийцсэн, 27.10-т заасан нэгдсэн, ангилал, код, тайлбартай байна.</p> <p>6.3.Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн жагсаалтыг Засгийн газар батална.</p> <p>6.4.Нэгдсэн порталд бүртгэх мэдээлэл тоон мэдээлэл, өгөгдөл, дуу авиа, дүрс бичлэг, зураг, газрын зураг, кадастрын зураг, график, бичгийн хэлбэртэй байна.</p> <p>6.5.Нэгдсэн порталд байрших газрын зураг, кадастрын зурган мэдээ Засгийн газраас тодорхойлсон солбицол, өндрийн тогтолцоонд нийцсэн байна.</p> <p>6.6.Үндэсний зөвлөл нэгдсэн порталын үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн хариуцна.</p> <p>6.7.Нэгдсэн портал бусад хуульд заасан байгалийн нөөцийн, зөвшөөрлийн, шилэн дансны, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн, татварын зэрэг холбогдох мэдээллийн сантай холбогдсон, мэдээлэл солилцох боломжтой байна.</p> <p>6.8.Нэгдсэн порталд цахим хэлбэрээр хүргүүлсэн мэдээлэл, тайлан цахим гарын үсэг, эсхүл хуульд заасан бусад баталгаажуулах арга, хэрэгслээр баталгаажсан байна.</p> <p>6.9.Хуульд өөрөөр заагаагүй бол нэгдсэн порталд бүртгэсэн мэдээллийг төрийн байгууллага хүн, хуулийн этгээдээс дахин шаардахгүй.</p> <p>6.10.Байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой бусад хуульд заасан тайлан, мэдээ, мэдээллийг нэгдсэн порталаар дамжуулан цахимаар хүргүүлсэн бол тухайн мэдээллийг холбогдох төрийн байгууллагад хүргүүлсэнд тооцно.</p> <p>6.11.Нэгдсэн порталд бүртгэгдээгүй, эсхүл баталгаажгаагүй мэдээллийг байгалийн нөөц ашиглалттай холбоотой зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, төлөвлөгөө батлах, хяналт шалгалт хийх, тайлан боловсруулах үндэслэл болгохгүй.</p> <p>6.12.Нэгдсэн порталын мэдээллийг 16 жилээс доошгүй хугацаанд хадгална.</p> <p>6.13.Нэгдсэн порталд мэдээлэл нийлүүлэх, хадгалах, ашиглах, ашиглалтад хяналт тавих журмыг Үндэсний зөвлөл батална.</p> <p>6.14.Үндэсний зөвлөлийн ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх) нэгдсэн порталд илгээсэн мэдээллийн хэлбэр, хугацаа, бүрдлийг шалгана.</p> <p>6.15.Ажлын алба мэдээлэл дутуу, алдаатай, зөрүүтэй бол мэдээлэл нийлүүлэгчид буцааж, засварлах шаардлага хүргүүлнэ.</p>	<p>Үгүй</p>

<p>6.16.Мэдээлэл нийлүүлэгч энэ хуулийн 6.15-т заасан шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор засварласан мэдээллийг дахин илгээнэ.</p> <p>6.17.Энэ хууль болон холбогдох бусад хуульд заасан тайлан, мэдээллийг мэдээлэл нийлүүлэгч нэг удаа холбогдох мэдээллийн сан, нэгдсэн портал, эсхүл салбарын эрх бүхий байгууллагад цахимаар хүргүүлсэн бол төрийн байгууллага уг мэдээллийг дахин шаардахгүй бөгөөд нийтийн мэдээллийн дэд бүтэц, мэдээлэл солилцооны системээр дамжуулан авч ашиглана.</p> <p>6.18.Үндэсний зөвлөл нэгдсэн порталаар тайлан, мэдээллийг нэг цонхоор хүлээн авах, харилцан солилцох, дахин шаардахгүй байх техникийн боломжтой байна.</p>	
<p>7 дугаар зүйл.Мэдээллийн нууц</p> <p>7.1.Байгалийн нөөц ашиглалтын улмаас зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, бохирдол, доройтол, осол, нөхөн сэргээлт, аюултай эсхүл хортой бодисын хэрэглээ, хог хаягдал, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамж, татвар, эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгч, улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого, төрийн болон орон нутгийн өмчит этгээдэд төлсөн төлбөр, ногдол ашиг, хандив, тусламж, дэмжлэгийн мэдээллийг Байгууллагын нууцын тухай болон бусад хуулиар хамгаалагдсан нууц мэдээлэл гэж үзэхгүй.</p>	Үгүй
<p>7.2.Энэ хуульд заасан гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийг нэгдсэн порталд бүтнээр нь ил тод байршуулна.</p>	Үгүй
<p>7.3.Гэрээ хэлэлцээрийн хуулиар хамгаалагдсан төрийн нууц, байгууллагын нууцад хамаарах хэсгийг нууцалж нийтэлж болох бөгөөд энэ нь гэрээний бусад хэсгийг ил болгох үүргийг хязгаарлахгүй.</p>	Үгүй
<p>7.4.Энэ хуулийн 7.3-т заасан мэдээллийг нууцлах шалгуур, тэмдэглэгээ, нууцлах хугацаа, шийдвэрлэх журмыг Засгийн газар батална.</p>	Үгүй
<p>7.5.Энэ хуулийн 7.3-т заасны дагуу мэдээллийг тодорхой хугацаанд нууцлах тохиолдолд мэдээлэл нийлүүлэгч тайлан, мэдээлэл гаргах үүргээс чөлөөлөгдөхгүй.</p>	
<p>8 дугаар зүйл.Мэдээлэл нийлүүлэгч, түүний эрх, үүрэг</p> <p>8.1.Дараах этгээд мэдээлэл нийлүүлэгч байна:</p> <p>8.1.1.зөвшөөрөл эзэмшигч;</p> <p>8.1.2.энэ хуулийн 10.5-д заасан төрийн бус байгууллага;</p> <p>8.1.3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан мэдээлэл хариуцагч.</p>	Үгүй
<p>8.2.Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөл олгосноос хойш ажлын 5 өдрийн дотор нэгдсэн порталд бүртгүүлнэ.</p>	Үгүй
<p>8.3.Энэ хуулийн 8.1.2-т заасан төрийн бус байгууллага нь энэ хуулиар мэдээлэл нийлүүлэгч болох үндэслэл үүссэнээс хойш ажлын 15 өдрийн дотор нэгдсэн порталд бүртгүүлнэ.</p>	Үгүй

<p>8.4.Мэдээлэл нийлүүлэгчийн бүртгэлийн журмыг Үндэсний зөвлөл батална.</p>	<p>Үгүй</p>
<p>8.5.Мэдээлэл нийлүүлэгч дараах үүрэгтэй: 8.5.1.мэдээлэл бий болсноос хойш ажлын 10 өдрийн дотор багтаан нэгдсэн порталд баталгаажуулан оруулах, тухайн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 5 өдрийн дотор шинэчлэх; 8.5.2.Үндэсний зөвлөл, түүний Ажлын албанаас шаардсан тодруулгын хариуг ажлын 10 өдөрт багтаан хүргүүлэх; 8.5.3.мэдээлэл, тайлангийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах; 8.5.4.энэ хуульд заасан тайланг нэгдсэн порталд байршуулах; 8.5.5.хууль тогтоомж болон Үндэсний зөвлөлөөс баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх; 8.5.6.нэгдсэн порталд энэ хуульд заасан журмын дагуу бүртгүүлэх.</p>	<p>Үгүй</p>
<p>8.6.Мэдээлэл нийлүүлэгч дараах эрхтэй: 8.6.1.энэ хуульд заасан тайлан гаргахтай холбоотой сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө, тодруулга, мэдээллийг авах; 8.6.2.энэ хуулийн 7.4-т заасан журмын дагуу тодорхой мэдээллийг нууцлах хүсэлт гаргах.</p>	<p>Үгүй</p>
<p>8.7.Энэ хуулийн 8.1.3-т заасан мэдээлэл нийлүүлэгч дараах үүрэгтэй: 8.7.1.өөрийн эрхлэх асуудлын эсхүл чиг үүргийн хүрээнд үүссэн, энэ хуульд заасан мэдээллийг бүрдүүлэх, хадгалах, боловсруулах, шинэчлэх, нэгдсэн порталд хүргүүлэх; 8.7.2.Ажлын албанд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх, цахимаар хүргүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах.</p>	<p>Үгүй</p>
<p>9 дүгээр зүйл.Байгалийн нөөц ашиглалтын улсын нэгдсэн тайлан 9.1.Байгалийн нөөц ашиглалтын Улсын нэгдсэн тайлан (цаашид “Улсын нэгдсэн тайлан” гэх) дор дурдсан тайлангаас бүрдэнэ: 9.1.1.амьтны нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан; 9.1.2.үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан; 9.1.3.ой, түүний дагалт баялгийн нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан; 9.1.4.байгалийн ургамлын нөөц ашиглалтын ил тод байдлын тайлан; 9.1.5.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан.</p>	<p>Үгүй</p>
<p>9.2.Улсын нэгдсэн тайлан боловсруулах, нэгдсэн порталд байршуулах, тайланд залруулга хийх журмыг Үндэсний зөвлөл батална.</p>	<p>Үгүй</p>
<p>9.3.Үндэсний зөвлөл Улсын нэгдсэн тайланг жил бүр боловсруулна.</p>	<p>Үгүй</p>

<p>9.4.Үндэсний зөвлөл мэдээллийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр түгээх зорилгоор Улсын нэгдсэн тайлангийн хураангуй тайланг жил бүр боловсруулна.</p>	<p>Үгүй</p>
<p>9.5.Үндэсний зөвлөл Улсын нэгдсэн тайланг энэ хуулийн 10.6-д заасан тайлан ирүүлэх хугацаа дууссанаас хойш хуанлийн 30 хоногийн дотор хэлэлцэн олон нийтэд мэдээлж, Засгийн газарт хүргүүлнэ.</p>	<p>Үгүй</p>
<p>9.6.Энэ хуулийн 9.1.5-д заасан тайланд дор дурдсан мэдээллийг тусгана:</p> <p>9.6.1.улсын эдийн засагт олборлох үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээ;</p> <p>9.6.2.олборлох үйлдвэрлэлийн нийт орлого, тэдгээрээс төсөвт болон бусад байдлаар улсад төвлөрүүлсэн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, зарцуулалт, төсвийн орлогын тогтвортой байдлын талаар;</p> <p>9.6.3.олборлосон, баяжуулсан, боловсруулсан, борлуулсан, экспортолсон эрдэс баялгийн төрөл, хэмжээ /зөвшөөрөл тус бүрээр/;</p> <p>9.6.4.зөвшөөрөл эзэмшигчээс бусдад өгсөн хандив, зээл, тусламж, дэмжлэгийн хэмжээ, хэлбэр;</p> <p>9.6.5.нийгмийн хариуцлагын хүрээнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн нийт дүн;</p> <p>9.6.6.зөвшөөрөл эзэмшигчийн болон төрийн байгууллагын ил тод байдлын тайлан хоорондын зөрүү, түүний тайлбар, тодруулга;</p> <p>9.6.7.ил тод байдлын тайлан ирүүлээгүй зөвшөөрөл эзэмшигч болон төрийн байгууллагын талаарх мэдээлэл;</p> <p>9.6.8.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, засаглалыг сайжруулах талаарх дүгнэлт, зөвлөмж, өмнөх тайлангийн зөвлөмжийн хэрэгжилт;</p> <p>9.6.9.төлбөр, орлогын дүнгийн тэнцэл;</p> <p>9.6.10. олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах хувь нэмрийн талаа, дүгнэлт;</p> <p>9.6.11.олборлох үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;</p> <p>9.6.12.уурхайн хаалт, байгаль орчин нөхөн сэргээлтийн мэдээлэл.</p>	<p>Үгүй</p>
<p>9.7.Энэ хуулийн 9.1.1-9.1.4-т заасан нөөц ашиглалтын ил тод байдлын тайланд дор дурдсан мэдээллийг тусгана:</p> <p>9.7.1.улсын эдийн засагт тухайн салбарын байгалийн нөөц ашиглалтын эзлэх хувь хэмжээ;</p> <p>9.7.2.тухайн салбарын байгалийн нөөц ашиглалтын нийт орлого, тэдгээрээс төсөвт төвлөрүүлсэн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, зарцуулалт, төсвийн орлогын тогтвортой байдлын талаар;</p> <p>9.7.3.зөвшөөрөл эзэмшигчийн болон төрийн байгууллагын ил тод байдлын тайлан хоорондын зөрүү, түүний тайлбар, тодруулга;</p> <p>9.7.4.ил тод байдлын тайлан ирүүлээгүй зөвшөөрөл эзэмшигч болон төрийн байгууллагын талаарх мэдээлэл;</p>	<p>Үгүй</p>

9.7.5. тухайн салбарын байгалийн нөөц ашиглалтын ил тод байдал, засаглалыг сайжруулах талаарх дүгнэлт, зөвлөмж, өмнөх тайлангийн зөвлөмжийн хэрэгжилт.	
9.8. Улсын нэгдсэн тайлан, эсхүл түүний бүрдэл тайланд төрийн бус байгууллага дүгнэлт гаргаж болно.	Үгүй
9.9. Энэ хуулийн 9.8-д заасан дүгнэлт гаргасан төрийн бус байгууллага нь 10.6-д заасан тайлан ирүүлэх хугацаа дууссанаас хойш ажлын 25 өдрийн дотор дүгнэлтээ Ажлын албанд хүргүүлнэ.	Үгүй
10 дугаар зүйл. Байгалийн нөөц ашиглалтын төрөлжсөн тайлан 10.1. Энэ хуулийн 9.1.1-9.1.5-д заасан тайлан дор дурдсан төрөлтэй байна: 10.1.1. төрийн байгууллагын; 10.1.2. зөвшөөрөл эзэмшигчийн; 10.1.3. төрийн бус байгууллагын;	Үгүй
10.2. Энэ хуулийн 10.1.1, 10.1.2-т заасан тайлангийн маягтыг байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл бүрийг хамруулж Үндэсний зөвлөл батална.	Үгүй
10.3. Энэ хуулийн 8.1.3-т заасан мэдээлэл нийлүүлэгч тухайн жилийн төрийн байгууллагын ил тод байдлын тайланг гаргана.	Үгүй
10.4. Зөвшөөрөл эзэмшигч тухайн жилийн зөвшөөрөл эзэмшигчийн ил тод байдлын тайланг гаргана.	Үгүй
10.5. Зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал зэрэг болон бусад аливаа хэлбэрээр санхүүжилт авсан төрийн бус байгууллага тухайн жилийн төрийн бус байгууллагын ил тод байдлын тайланг гаргана.	Үгүй
10.6. Энэ хуулийн 10.1.1-10.1.3-т заасан ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Үндэсний зөвлөлөөс баталсан загварын дагуу гаргаж, нэгдсэн порталд оруулна.	Үгүй
10.7. Мэдээлэл нийлүүлэгч энэ хуулийн 10.1.1-10.1.2-т заасан ил тод байдлын тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн гаргана.	Үгүй
10.8. Төрийн бус байгууллагын ил тод байдлын тайланд дор дурдсан мэдээллийг тусгана: 10.8.1. үүсгэн байгуулагч, удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын дэлгэрэнгүй мэдээлэл; 10.8.2. санхүүжилт, түүний зориулалт, зарцуулалтын мэдээлэл; 10.8.3. үйл ажиллагааны чиглэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, олборлолтын мэдээ, засаглалын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл; 10.8.4. мэдээлэл нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, хэлцлийн мэдээлэл.	Үгүй

<p>11 дүгээр зүйл.Ил тод байдлын тайлангийн зөрүүг хянан шийдвэрлэх 11.1.Ажлын алба ил тод байдлын тайлангийн мэдээллийн зөрүүг тодруулах хүсэлтийг холбогдох тайлан гаргасан этгээдэд хүргүүлж болно.</p>	<p>Үгүй</p>
<p>11.2.Энэ хуулийн 11.1-д заасан хүсэлтийг хүлээн авсан этгээд ажлын 5 өдрийн дотор холбогдох нэмэлт мэдээлэл, тайлбарыг Ажлын албанд хүргүүлнэ.</p>	<p>Үгүй</p>
<p>11.3.Ажлын алба энэ хуулийн 11.2-т заасан нэмэлт мэдээлэл, тайлбарыг хүлээн авсны дараа зөрүүг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ. Тухайн этгээд шаардлагатай тохиолдолд зөрүү үүсгэж байгаа мэдээлэлтэй танилцаж болно.</p>	<p>Үгүй</p>
<p>11.4.Ажлын алба тайлангийн зөрүүг шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл энэ талаар тайлбар, зөвлөмжийг Улсын нэгдсэн тайланд тусгаж, тайлан гаргах үүрэг бүхий этгээдэд мэдэгдэнэ.</p>	<p>Үгүй</p>
<p>11.5.Үндэсний зөвлөл Улсын нэгдсэн тайланд тусгагдсан зөрүүг хэрхэн шийдвэрлэж болох талаарх зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлнэ.</p>	<p>Үгүй</p>
<p>12 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх 12.1.Улсын Их Хурал байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.1.Засгийн газраас хүргүүлсэн Улсын нэгдсэн тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан холбогдох байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж Засгийн газарт чиглэл өгөх.</p>	<p>Үгүй</p>
<p>13 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх 13.1.Засгийн газар байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 13.1.1.байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; 13.1.2.Улсын нэгдсэн тайланг бүрдэл бүрээр хэлэлцэн, хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт 8 дугаар сарын 25-ны дотор Улсын Их Хуралд хүргүүлэх; 13.1.3.энэ хуулийн 12.1.1-д заасан холбогдох байнгын хорооны санал, дүгнэлт, Засгийн газарт өгсөн чиглэлийн биелэлтийг хангах арга хэмжээ авах; 13.1.4.энэ хуулийн 6.3-д заасан жагсаалтыг батлах; 13.1.5.Үндэсний зөвлөлийн дүрмийг батлах.</p>	<p>Үгүй</p>
<p>13.2. Засгийн газар энэ хуулийн 13.1.4-т заасан байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн жагсаалтыг дараах ангиллын хүрээнд батална: 13.2.1.зөвшөөрөл, түүний бүртгэлийн мэдээлэл; 13.2.2.гэрээ, хэлэлцээрийн мэдээлэл; 13.2.3.зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны мэдээлэл;</p>	<p>Үгүй</p>

<p>13.2.4.байгалийн нөөцийн олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын мэдээлэл; 13.2.5.төсвийн болон орлого төвлөрүүлэлтийн мэдээлэл; 13.2.6.нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн хөрөнгө зарцуулалтын мэдээлэл; 13.2.7.уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн мэдээлэл; 13.2.8.ашиг хүртэгч хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн мэдээлэл; 13.2.9.олборлох үйлдвэрлэл эрхлэгч төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээлэл; 13.2.10.олборлох үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах байдлаар олсон орлогын мэдээлэл; 13.2.11.олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах хувь нэмрийн мэдээлэл; 13.2.12.олборлох үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийн мэдээлэл.</p>	
<p>14 дүгээр зүйл. Засаг даргын бүрэн эрх 14.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.1.1.өөрийн нутаг дэвсгэрт зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан захиргааны шийдвэр, түүний үндэслэлийг өөрийн цахим хуудаст нийтлэх; 14.1.2.түгээмэл тархацтай ашигт малтмалын зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон мэдээллийг нэгдсэн порталд байршуулах, өөрийн цахим хуудаст нийтлэх; 14.1.3.байгаль орчны хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааг зохион байгуулах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 14.1.4.ажлын алба, салбар зөвлөлтэй хамтран ажиллах, байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хангах талаар санал, мэдээллийг тогтмол солилцох; 14.1.5.Ажлын алба, байгаль орчны хяналтын улсын байцаагчаас ирүүлсэн мэдээллийг хянан үзэж, шаардлагатай арга хэмжээг авах.</p>	Үгүй
<p>15 дугаар зүйл.Үндэсний зөвлөл 15.1.Улсын хэмжээнд байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хэрэгжүүлэх зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллах ба орон тооны Ажлын албатай байна.</p>	Үгүй
<p>15.2.Үндэсний зөвлөл Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, байгаль орчин, геологи, уул уурхай, санхүү, төсөв, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, зөвшөөрөл эзэмшигчийн төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байна.</p>	Үгүй
<p>15.3.Үндэсний зөвлөлийн 7 гишүүнийг зөвшөөрөл эзэмшигч, төрийн бус байгууллагын төлөөллөөс нээлттэй сонгон шалгаруулж, 3 жилийн хугацаагаар, үлдсэн 8 гишүүнийг энэ хуулийн 15.2-т заасан</p>	Үгүй

төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосноор Засгийн газар томилно.	
15.4.Энэ хуулийн 15.3-т заасан төрийн бус байгууллага нь Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдал, сайн засаглалыг хангах, авлига болон ашиг сонирхлын зөрчлийг бууруулах чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан мэргэжлийн холбоо эсхүл төрийн бус байгууллага байна.	Үгүй
15.5.Үндэсний зөвлөл болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд зөвшөөрөл эзэмшигч, төрийн бус байгууллагын төлөөллийг сонгон шалгаруулж, томилох журмыг Засгийн газар батална.	Үгүй
15.6.Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг тухайн шатны Засаг дарга Үндэсний зөвлөлөөс баталсан журамд нийцүүлэн батална.	Үгүй
15.7.Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Ажлын албаны дарга байна.	Үгүй
<p>16 дугаар зүйл.Үндэсний зөвлөлийн бүрэн эрх</p> <p>16.1.Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>16.1.1.Улсын нэгдсэн тайланг бүрдэл бүрээр хэлэлцэх, олон нийтэд мэдээлэх, Засгийн газарт хүргүүлэх;</p> <p>16.1.2.мэдээлэл нийлүүлэгчийн тайланд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, холбогдох этгээдэд хүргүүлэх, зөвлөмжийн биелэлтийг шаардах, хариу, мэдээлэл авах;</p> <p>16.1.3.байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг сурталчлах, олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авч, холбогдох хэлэлцүүлгийг зохион байгуулах;</p> <p>16.1.4.байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын талаар авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээний талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах;</p> <p>16.1.5.төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагатай харилцах, хамтран ажиллах;</p> <p>16.1.6.энэ хуульд заасан этгээдээс байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын талаар авч хэрэгжүүлсэн ажил, ирүүлсэн мэдээлэл, тайлан, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, шалгалт хийх, биелэлтийг хангуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;</p> <p>16.1.7.энэ хуульд заасан мэдээлэл нийлүүлэгчээс тайлан, мэдээлэл гаргуулан авах;</p> <p>16.1.8.Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын хэрэгжилт, нэгдсэн порталын үйл ажиллагаа, мэдээлэл бүрэн нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих, энэ чиглэлээр энэ хуульд заасан этгээдтэй хамтарч ажиллах;</p> <p>16.1.9.Үндэсний зөвлөлийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх талаар холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах, хариу авах;</p> <p>16.1.10.байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хэрэгжүүлэх асуудлаар гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх;</p>	Үгүй

<p>16.1.11.байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах;</p> <p>16.1.12. Байгалийн нөөц ашиглалтын мэдээлэл тайлангийн заавар, маягт батлах.</p>	
<p>17 дугаар зүйл.Ажлын алба</p> <p>17.1.Үндэсний зөвлөл дараах чиг үүрэг бүхий Ажлын албатай байна:</p> <p>17.1.1.энэ хуульд заасан мэдээлэл нийлүүлэгчээс байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тайланг хүлээн авах;</p> <p>17.1.2.Улсын нэгдсэн тайланг боловсруулах;</p> <p>17.1.3.нэгдсэн порталын үйл ажиллагаа болон мэдээлэл нийлүүлэгчээс мэдээлэл, тайланг бүрэн нийлүүлж байгаа эсэхэд хяналт тавих, мэдээлэлд дүн шинжилгээ хийх;</p> <p>17.1.4.шаардлагатай тохиолдолд холбогдох шинжээч, мэргэжилтэн оролцуулж дүгнэлт гаргуулах, мэдээлэл, тайлангийн үнэн зөв байдлыг нягтлах;</p> <p>17.1.5.байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлыг сайжруулах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах санал, зөвлөмж боловсруулах;</p> <p>17.1.6.Улсын нэгдсэн тайланд үндэслэн цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж гаргах, зөвлөмжийг холбогдох этгээдэд хүргүүлэх, зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнгийн хариуг тогтоосон хугацаанд хүлээн авах;</p> <p>17.1.7.Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</p>	Үгүй
<p>17.2. Зөвшөөрөл эзэмшигчийн эрх бүхий этгээд ил тод байдлын тайланг баталгаажуулаагүй бол Ажлын алба тайланг хүлээн авахаас татгалзаж, үндэслэлийн хамт мэдээлэл нийлүүлэгчид ажлын 2 өдрийн дотор мэдэгдэнэ.</p>	Үгүй
<p>17.3. Энэ хуулийн 17.2-т зааснаар татгалзсан тайланг мэдээлэл нийлүүлэгч засварлан, баталгаажуулалтыг хангасны дараа дахин хүргүүлж болно. Дахин хүргүүлсэн тайланг энэ хуулийн 10.6-д заасан хугацаа дуустал хүлээн авна.</p>	Үгүй
<p>17.4. Хэрэв мэдээлэл нийлүүлэгч 10.6-д заасан хугацаанд баталгаажуулалтыг хангасан тайланг хүргүүлэхгүй бол тайлан ирүүлээгүйд тооцож, энэ хуулийн 9.6.7, 9.7.4-т заасны дагуу Улсын нэгдсэн тайланд тусгана.</p>	Үгүй
<p>17.5.Нэгдсэн порталын мэдээлэл, тайланг Ажлын алба олон нийтэд ойлгомжтой байдлаар байршуулан мэдээлж, тогтмол шинэчилж байна.</p>	Үгүй
<p>18 дугаар зүйл.Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт</p> <p>18.1.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс, түүний орон нутагт ажиллах салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.</p>	Үгүй

18.2.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу бэлтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба төсвийн ерөнхийлөн захирагч уг төсвийн төслийг багцдаа тусган батлуулна.	Үгүй
18.3.Үндэсний зөвлөл салбар зөвлөлийн төсвийг тухайн аймаг, нийслэлийн төсөвт тусган баталуулна.	Үгүй
18.4.Үндэсний зөвлөл, түүний салбар зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт бие даасан, хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд хүрэлцээтэй байна.	Үгүй
18.5.Үндэсний зөвлөл, салбар зөвлөл мэдээлэл нийлүүлэгч этгээдээс зээл, хандив, дэмжлэг авахыг хориглоно.	Үгүй
19 дүгээр зүйл. Байгаль орчны хяналтын улсын байцаагч 19.1.Байгаль хамгаалагч байгалийн нөөц ашиглалтын мэдээллийг ил тод болгох чиглэлээр дараах үүрэгтэй ажиллана: 19.1.1.нэгдсэн порталд байршуулсан мэдээлэл бодит нөхцөлтэй нийцэж байгаа эсэхэд газар дээр нь хяналт тавих; 19.1.2.хяналт шалгалтын дүн, акт, албан шаардлагыг нэгдсэн порталд байршуулах.	Үгүй
20 дугаар зүйл.Гомдол хянан шийдвэрлэх 20.1.Энэ хуулийн мэдээлэл нийлүүлэгч этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл холбогдох хуулийн дагуу гомдол гаргах эрхтэй: 20.1.1.салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох гомдлыг Үндэсний зөвлөлд; 20.1.2.Үндэсний зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагаатай холбогдох гомдлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.	Үгүй
20.2.Энэ хуулийн 20.1-д заасны дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.	Үгүй
21 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинж , юл Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Үгүй
21.2.Энэ хуулийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Үгүй

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

1. ҮР ДҮНГ БАРИМТЖУУЛАХ

Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд зориулж шалгах хэрэгслийг хэрэглэх явцад ашигласан мэдээлэл тоо баримт, дүгнэлт, оролцогчид, мэргэжлийн холбоодын санал зэрэг холбогдох бүх материалыг цуглуулсан бөгөөд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үе шат бүрийг баримтжууллаа. Энэ нь хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааны үр дүнг дүгнэж, зөвлөмж өгөх үндэслэл болох бөгөөд цуглуулсан бүх баримт, мэдээлэл зөвлөмжийн хавсралт болно.

2. ҮНЭЛЭХ

Хуулийн төслийн үр нөлөөг шалгах хэрэгслийг ашиглан үнэлэхэд дараах хүндрэлтэй асуудлууд гарсан болно. Ашигт малтмал, Газрын тос, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиудад тусгагдсан зохицуулалтыг Шилэн дансны тухай болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хэд хэдэн хуулиар мэдээллийн сан, түүний бүрдэл, бүрдүүлэх нөхцөл журмыг зохицуулсан байсан нь үнэлгээ хийхэд тэдгээрийн үйлчлэх хүрээг ялгаж зааглахад бага зэрэг хүндрэлтэй байлаа.

Хуулийн төслийн үр нөлөөг Зорилгод хүрэх байдал, Практикт хэрэгжих боломж, Уялдаа холбоо, зардал тооцох гэсэн шалгууруудаар ерөнхийд нь үнэлэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн хуулийн төсөлд тавигдах шаардлагыг хангасан гэж дүгнэхээр байна. Үүнийг шалгуур тус бүрээр нарийвчлан авч үзвэл

№	Шалгуур	Дүгнэлт
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн сонгогдсон зохицуулалт нь хуулийн төслийн зорилго болон түүнийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байна.
2.	Практикт хэрэгжих боломж	Ил тод байдлыг хангах Үндэсний зөвлөл, түүний ажлын алба нь Засгийн газрын тогтоолоор байгуулагдан олон улсын байгууллагаас санхүүжиж ажиллаад нэлээдгүй удсан нь практикт хэрэгжүүлэх боломжтойг илэрхийлж байна. Гэхдээ хуулийн төслийн анхан шатны тайлан гаргах цаг хугацаа, тайлан нэгтгэх, тайланг мэдээлэх зэрэг цаг хугацааг Засгийн газрын тогтоолоор батлахдаа хэрэгжих боломжтой байдлаар журамлахыг анхаарах шаардлагатай байна.

Баримтжуулсан материалуудыг хавсралт хэсгээс харна уу.

3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөлд тусгасан “нэгдсэн портал”-аас мэдээлэл авах сонирхолтой иргэд нэг шугамаар буюу E-Mongolia-аас авах уу? Нэгдсэн порталын дата баазыг хаана төвлөрүүлэх эсэхийг тодорхой болгор шаардлагатай байна.
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	<p>1. Олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэд байгалийн баялгийн ашиглалт, орлогын мэдээллийг ил тод болгохыг дэмждэг. - Авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулах хүлээлт өнөөгийн нийгэмд өндөр байгаа. <p>2. Төрийн байгууллагын хувьд:</p> <ul style="list-style-type: none"> - Ил тод байдал нэмэгдэх нь засаглалын чанарыг сайжруулна. - Зарим байгууллагын хувьд мэдээлэл нээлттэй болгох бэлэн байдал хангалтгүй байх эрсдэлтэй. <p>3. Уул уурхайн олборлох салбарын компаниудын хувьд:</p> <ul style="list-style-type: none"> - Ил тод байдал нь итгэлцэл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлдэг. <p>4. Олон улсын шаардлагын хувьд:</p> <ul style="list-style-type: none"> - <u>Extractive Industries Transparency Initiative</u> (EITI) зэрэг санаачилгууд ил тод байдлыг дэмждэг. - Монгол Улс тус стандартыг хэрэгжүүлж ирсэн тул уг хууль нь олон улсын чиг хандлагатай нийцнэ. - Гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.
5.	Уялдаа холбоо	<p>Хуулийн төсөлд бусад хуультай уялдаж байгаа эсэхийг дахин сайтар нягтлах. Үүнд:</p> <p>Ашигт малтмалын тухай хууль;</p> <p>Байгаль орчныг хамгаалах тухай хууль;</p> <p>Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хууль;</p> <p>Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;</p> <p>Шилэн дансны тухай хууль;</p> <p>Төрийн болон албаны нууцын тухай хууль;</p> <p>Улсын бүртгэлийн тухай хууль.</p>

3.ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлээд дараах зөвлөмжийг гаргаж байна.

1. Үндсэн хуульд заасан байгалийн баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх зохицуулалт, байгалийн нөөц баялгийг ямар этгээд, ямар хэмжээгээр ашиглаж байгаа талаар, ашигласны дүнд ямар хэмжээний татвар хураамжийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй мэдээллийг нэг шугамаар авч болох эрх зүйн зохицуулалт бүрдэж байна. Гагцхүү зөвшөөрөл эзэмшигчийг олон төрлийн тайлан гаргах, олон байгууллагууд руу хүргүүлэх хүнд суртлыг багасгах тал дээр анхаарах шаардлагатай байна.

2. Мэдээллийг ОУИТБС-ын шаардлагатай уялдуулах, иргэдэд ойлгомжтой хэлбэрээр нийтлэх.

3. Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлын тухай хууль зөрчсөн, ил тод байдлыг хангаагүй тохиолдолд торгууль ногдуулах, тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түр зогсоох зэрэг бодит хариуцлага тооцох.

4. Ил тод байдлыг бодитоор хангахын тулд зөвшөөрөл эзэмшигчийн нууцалж болох мэдээллийг тодорхой болгох шаардлагатай байна.